



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТХЗ-ТОЙ УЯЛДСАН
ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН



(2021 ОНЫ 10 САРЫН 01 – 2022 ОНЫ 9 САРЫН 30)



ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

Тайлангийн хугацаа	2021 оны 10 дугаар сарын 01 – 2022 оны 9 дугаар сарын 30-ын өдөр
Санхүүжүүлэгч	Европын холбоо
Улс	Монгол Улс
Төслийн нэр	АСА/2020/418-930 BS TA Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь
Төслийн зорилго, зорилт	Төсөл нь Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах 2 зорилтуудыг тавьж ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ▪ Бодлогыг сайжруулах замаар хөдөлмөр эрхлэх чадавх, боломжийг нэмэгдүүлэх ▪ Хөдөлмөр эрхлэлтийн салбарт үр дүнд чиглэсэн, үр нөлөөтэй, нотолгоонд суурилсан бодлого, төсвийн уялдааг хангах төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах
Төсөл эхэлсэн/дуусах огноо	2020 оны 10 дугаар сарын 01 - 2024 оны 4 дүгээр сарын 01
Хамтран хэрэгжүүлэгчид	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, ХХААБ, ОУХБ
Үндэсний болон орон нутгийн түвшний хамтрагчид	Сангийн Яам Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам Эдийн Засаг, Хөгжлийн яам Боловсрол, шинжлэх ухааны яам Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Их Хурал Үндэсний Аудитын Газар Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо Залуучуудын хөдөлмөрлөх эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудыг багтаасан Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ ИНБ болон судалгаа/хэвлэл мэдээллийн байгууллагууд Орон нутгийн Засаг захиргаа
Төслийн үр шимийг хүртэгсэд	Залуучууд Тариаланчид, малчид Алслагдсан орон нутгийн залуучууд, зорилтот бүлгүүд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Охид, эмэгтэйчүүд Албан бус эдийн засагт ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс Ажилгүй, бүрэн бус хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, Ажил хайгчид
Төслийн нийт төсөв	7,400,000 евро
Холбоо барих хүн	Илейн Конкиевич НҮБХХ-ийн суурин төлөөлөгч elaine.conkievich@undp.org

ТОВЧЛОЛ

АХ	Ажлын хэсэг
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГШҮ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ДХЗХ	Дунд хугацааны зардлын хүрээ
ЕХ	Европын холбоо
ЖАТ	Жилийн ажлын төлөвлөгөө
ЗИШ	Зарлагын болон институцийн шинжилгээ
ЗЗХС	Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ
ЗДЗТ	Зөв дадал-зан төлөв суулгах
ИНБ	Иргэний нийгмийн байгууллагууд
ИХЗЗАХ	Идэвхтэй хөдөлмөрийн зах зээлийн арга хэмжээ
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МШНЗ	Мөнгөн шилжүүлгийн нийтлэг зарчим
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХС	Олон улсын хөдөлмөрийн стандарт
СНТ	Стратегийн нийцлийн төлөвлөлт/төлөвлөгөө
СХБ	Сургалтын хөтөлбөр боловсруулах
СЯ	Сангийн яам
ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТША	Төсвийн шинжилгээний алба
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТХХТ	Төр-хувийн хэвшлийн түншлэл
УА	Удирдлагын академи
УИХ	Улсын их хурал
УАГ	Үндэсний аудитын газар
ҮДСТ	Үр дүнд суурилсан төсөвлөлт
ҮДСНУ	Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ҮЗХ	Хөгжлийн зорилтот хөтөлбөр (Дунд хугацааны хөгжлийн бодлого)
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХНХЕГ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан
ХЭДХ	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр
ХЭДҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөл

ХХҮДХ	Хөтөлбөрийн хөгжлийн үр дүнгийн хүрээ
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЯҮДХ	Яамны үр дүнгийн хүрээ

АГУУЛГА

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ	2
1. ХУРААНГУЙ.....	6
2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	11
3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ҮР ДҮН.....	14
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А. БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ.....	15
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ	27
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ С. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ:.....	37
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ Д. ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ (ОУХБ).....	58
4. ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	65
5. МЭДЭЭЛЭЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	66
6. ТӨСЛИЙН УДИРДЛАГА	70
7. БЭРХШЭЭЛ/ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	71
8. ЦААШДЫН ЧИГЛЭЛ	72
9. ЦААШДЫН ЧИГЛЭЛ	72
10. САНХҮҮГИЙН ТАЙЛАН	73
11. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ	74
12. ХАВСРАЛТУУД	74

1. ХУРААНГУЙ

Төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг (А) нь Монгол Улсын Засгийн газарт үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байгаа бөгөөд тайлант хугацаанд энэ чиглэлээр томоохон ахиц гарсан. Үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх замын зургийн төслийг боловсруулсан нь Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын суурийг тавихад тус дөхөм болсон ажил боллоо. Санал болгож буй замын зургийг гол оролцогч талууд болох Сангийн яам (СЯ), Эдийн засаг хөгжлийн яам (ЭЗХЯ), Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг олон улсын байгууллагуудад танилцуулах, хэлэлцэн зөвшилцөх ажил явагдаж байна.

Төслийн хамтрагч гурван яам (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам) **2023 оны төсвийн төслөө үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйгээр боловсруулсан.** Ингэхдээ Монгол Улсын дунд хугацааны бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн (ХЗХ) төслийн үзэл санааг харгалзан холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнгийн хүрээ (ТЕЗХҮХ), түүнийг хэрэгжүүлэх Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээ (ХХҮХ) болон хяналт-шинжилгээний үнэлгээний хүрээг боловсруулан, тусгасан. Төсвийн тухай хуулийн хавсралт 1-д тусгагдсан хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийг үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлантай уялдуулах зорилгоор тайлангийн маягт болон удирдамжийг боловсруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-д үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйг хэрэгжүүлэх, төсвийг хуваарилах аргачлалыг сайжруулах, ингэхдээ одоо хэрэглэж буй үйлчилгээ, арга хэмжээг санхүүжүүлэх жишиг зардлыг дахин тооцоолж, шинэчлэх саналыг хүргүүлж, батлуулсан. ХЭДС-ийн 2023 оны төсвийг үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгасан төсвийн маягтын дагуу боловсруулан, орон нутагт хуваарилсан. Тус өөрчлөлтүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр (ХЭДХ), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний зөвлөмжид үндэслэж боловсруулсан. Уг шинэчлэл нь хөдөлмөр эрхлэлтийн салбарын санхүүжилтийн механизмыг нотолгоонд суурилсан төсөв төлөвлөлт рүү шилжүүлэхэд ихээхэн хувь нэмэр орууллаа.

Төслийн хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг (В) нь төсвийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд Улсын их хурал (УИХ), Иргэний Нийгмийн Байгууллагууд (ИНБ), Үндэсний Аудитын газар (ҮАГ)-ын төсөвт тавих хяналтыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг.

2022 оны 9 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан “Халамжаас Хөдөлмөрт” сэдэвт хэлэлцүүлэгт дэмжлэг үзүүлэн ажилласан. Ингэхдээ профайлинг буюу хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээ, орон нутгийн онцлогийг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хувиараа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг боловсронгуй болгох чиглэлээр төслийн хүрээнд хийсэн ажлуудыг танилцуулсан.

Тайлант хугацаанд олон нийтийн төсөвт тавих хяналтыг дэмжих зорилгоор ИНБ-ын дунд тэтгэлэгт хөтөлбөр санаачлан, амжилттай зохион байгуулсан бөгөөд одоогоор 10 ИНБ төсвийн хяналт хийж

байна. Эдгээр 10 ИНБ-ын 6 нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт, боловсролын салбарт 2, эрүүл мэндийн салбарт 1, татварын орлого бүрдүүлэлтийн чиглэлээр 1 байгууллага төсвийн хяналт хийж байна.

ҮАГ-ын гүйцэтгэлийн аудитад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд холбогдох 4 төрлийн техникийн удирдамжийг боловсруулсан. Үүнд i) [төрийн бодлого болон төсөвлөлт](#) ii) [ТХЗ-д уялдсан төсөвлөлт](#) iii) [улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө](#) iv) [2023 оны Жилийн Төсвийн Төсөл](#)-д хийх гүйцэтгэлийн аудитыг дэмжих чиглэлийн удирдамжууд багтсан. Мөн стратеги төлөвлөлт, чанарын хяналтын тухай техникийн зөвлөмж боловсруулсан нь ҮАГ гүйцэтгэлийн аудит хийх, байгууллагын зохион байгуулалтыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан. ҮАГ-аас [эрүүл мэнд](#) ба [хөдөлмөр эрхлэлтийн салбарт](#) хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитад техникийн дэмжлэг үзүүлсэн.

Төслийн гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийн (С) хүрээнд хөдөлмөр эрхлэх боломжуудыг нэмэгдүүлэх дараах 4 гол үр дүнд хүрэхэд чиглэнэ. Үүнд: одоо хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг сайжруулж, уялдааг хангах; аж ахуй эрхлэлт/инновацын экосистемийг Монголд хөгжүүлэх; үр чадвар олгох, чадавх бэхжүүлэх олон төрлийн үйлчилгээг дэмжих; хөдөлмөр эрхлэлтийн бодлогын чиглэлд нөлөөлөхүйц туршилтуудыг хэрэгжүүлэх замаар эхний 3 үр дүнд хүрэх юм. Тайлант хугацаанд [Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл](#)-ийг боловсруулж ХНХЯ-д хүлээлгэн өгсөн. 2023 оноос хэрэгжүүлэх ХЭД хөтөлбөрүүдийн загварыг хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, мөн хэрэгжүүлэх нэгдсэн удирдамжийг удирдамжийн хамт шинээр боловсруулаад байна. 2022 онд профайлинг буюу хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх арга зүйн сургалтыг бүх шатны хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг хамруулан үндэсний хэмжээнд зохион байгуулсан. 21 аймаг, 9 дүүргээс нийт 242 хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн (59 эрэгтэй, 183 эмэгтэй), газар хэлтсийн дарга нар хамрагдаж ажил хайгч, ажилгүй иргэдэд Хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах талаар мэдлэг, чадвар эзэмшсэн. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-аас мэдээлснээр 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 13,600 гаруй ажил хайгч иргэнд профайлинг хийсэн.

2023-2024 онд хэрэгжих **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** арга хэмжээ/ хөтөлбөрт тусгах зорилгоор дараах **дөрвөн арга хэмжээг** туршин хэрэгжүүлж байна, үүнд: 1) Дадлагажих хөтөлбөр 2) Мэргэжлийн сургалт 3) Хоршоог дэмжих 4) Жижиг дунд үйлдвэрлэл болон аж ахуй эрхлэлтийг дэмжих арга хэмжээ багтсан. Түүнчлэн, эдгээр туршилтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай өртгийн тооцоолол хийгдэж байна.

2022 онд төслийн дэмжлэгтэйгээр **Богино хугацааны/түр сургалтын байгууллагын мэдээллийн санг** www.mergejil.mn цахим хуудаст байршуулсан. Мөн МСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мөшгөх системийн хөгжүүлэлтийн хийж дууссан ба холбогдох яамдад хүлээлгэж өгөх шатанд явж байна. МБС-ын байгууллагуудын ажлын чиг үүрэг, хариуцлагын давхардлыг арилгах зорилгоор төлөвлөлтөөс үнэлгээ хийх хүртэл бүх үе шатуудыг хамруулсан [Чанарын Баталгаажуулалтын Хүрээг](#) боловсруулсан. Уг хүрээний үе шат бүрд зорилго, шаардлагатай арга хэрэгсэл, шалгуур, хэрэгжүүлэгч талуудыг тус тус тодорхой зааж өгсөн.

МБС-ын байгууллагад суралцагчдын бизнес эрхлэх үр чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн **аж ахуй эрхлэлтийн сургалтын модуль, гарын авлагыг** мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт

тусган боловсруулсан бөгөөд энэ нь Монгол улсад тус чиглэлээр хийгдсэн анхны хөтөлбөр юм. Түүнчлэн, мэргэжлийн боловсролын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд (ХБИ) зориулсан i) Архив, бичиг хэргийн ажилтан, ii) Цахим үйлчилгээний ажилтан, iii) Үйлчилгээний ажилтан гэсэн гурван мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Эрсдэл, хориглох гэх мэт мэргэжлийн үг, нэр томъёог тайлбарлах 300 гаруй шинэ дохио боловсруулсан.

Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг дэмжих зорилгоор *Мал нядлагч болон Хөдөө аж ахуйн машин механизмын оператор, засварчны* хоёр богино хугацааны мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институци (ХНХСҮСИ)-р батлуулаад байна.

Хөдөө аж ахуйн экспортын бүтээгдэхүүнийг дэмжих, Төр хувийн хэвшлийн түншлэлийн зохистой загварыг бий болгох зорилгын хүрээнд төслийн дэмжлэгтэйгээр **20 гишүүнтэй ингэний хоормог үйлдвэрлэгчдийн хоршоо байгуулав**. Ингэний сүүний өртгийн сүлжээ дундаа хамгийн сулд тооцогдож байсан ингэний сүү нийлүүлэлт нь 2022 оны 2-р сард өдөрт 225 литр байсан бол төслийн дэмжлэгтэйгээр хоршоо байгуулснаас хойш 9-р сар гэхэд өдөт 700-800 литр болж нэмэгдсэн үр дүн гарсан. Мөн хоршоонд элссэн хүмүүсийн тоо 9 өрхийн 18 (9 эрэгтэй, 9 эмэгтэй) байсан бол 40 хүн (20 эрэгтэй, 20 эмэгтэй) (гэр бүлийн гишүүдийг оруулаад) болж 2 дахин нэмэгдсэн байна.

Төслийн дөрөвдүгээр бүрэлдэхүүн хэсэг (D). Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын хөдөлмөрийн хяналтын хоёр конвенцод нэгдэн орох бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд ХНХЯ нэгдэн орох тухай төсөлд шаардлагатай үзэл баримтлал, хуулийн харьцуулалтын судалгааг бэлтгэж байна.

Төрийн хяналт шалгалтын шинэчилсэн найруулгад ОУХБ-с техникийн санал, зөвлөмж өгсөн. Уг санал зөвлөмжид урьдчилан мэдэгдэлгүйгээр гэнэтийн хяналт шалгалт хийх, зөвхөн төр хяналт хийх, хяналт шалгалт хийсэн хугацаа ба давтамж зэргийг тусгасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд техникийн санал зөвлөмжийг 2023 оны эхний улиралд багтаан өгөхөөр ажиллаж байна.

“Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай” 167 дугаар конвенцын хэрэгжилтийн тайланг 2022 онд Төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт дэд хороо, ХНХЯ хамтран бэлтгэсэн.

Аж ахуйн нэгжүүд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих өөрийн үнэлгээний хэрэгслийг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ) Төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан бөгөөд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭАХ) тухай хуулийн хэрэгжилтийг барилга, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүчний салбарт үнэлж хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих стратегийн төлөвлөлтийн (СТ) аргазүйг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-ын хөдөлмөрийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж эхлээд байна. Тэргүүлэх чиглэлийн дөрвөн салбарыг (уул

уурхай, барилга, хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүчний) тодорхойлж холбогдох сургалтуудыг зохион байгууллаа.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ БА ЖЕНДЭРИЙН ТОО, МЭДЭЭ

Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд жендерийн тэгш байдал нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл төдийгүй хурдасгагч хүчин зүйл юм. Төслийн эцсийн үр шим хүртэгчид буюу зорилтод бүлэгт залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, алслагдсан аймаг сумдад амьдардаг иргэд багтана. Төсөл нь зорилтод бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараахыг анхаарч байна: бодлого боловсруулах болон системийг зураглахдаа асуудлыг нь харгалзан үзэх, мөн зорилтод бүлэгт шууд хүрэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Салбарын төсвийн зарлагын шинжилгээгээр бүс нутгийн байршлаас хамааран санхүүжилт ялгаатай олгогдож байгааг харуулсан. Байршил, жендер, зорилтод бүлгийн задаргаа бүхий мэдээлэл нь үр дүнд суурилсан төлөвлөлт ба төсөвлөлт хийхэд дэмжлэг болдог. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилт, зарцуулалтын судалгаагаар санхүүжилт нь зорилтод бүлэгтээ буюу дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүстээ хүрэхгүй байгааг илрүүлсэн. Профайлинг үнэлгээ нь зорилтод бүлгийг тодорхойлох, улмаар шаардлагатай нөөцийг хуваарилахад дэмжлэг үзүүлэх мэдээллээр хангах боломжтой. Гэвч дээрх ажлын ач холбогдол нь хэнийг ч орхигдуулахгүй байхад анхаарсан үнэлгээ, гүйцэтгэлийн тайлагналын хөгжилтэй үялдана. Төсөл нь бүхий л үйл ажиллагаандаа үр шим хүртэгчдийг анхаарах, дэмжих зорилгоор зөвлөхүүдэд зориулсан Загварчлах сэтгэлгээ сэдэвт сургалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Тус сургалт нь үндэсний хэмжээнд төрийн албан хаагчдыг хамруулсан үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйн сургалтын хөтөлбөрт мөн багтсан.

Залуучуудад зориулсан үйл ажиллагаанууд. 2022 онд Засгийн газраас санаачилсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оролцоо” төсөлтэй хамтран ажилласан. “Оролцоо” төсөлд салбар бүрийн 15-34 насны 1,240 ажил хайгч залуучууд хамрагдсан. Үүнээс 545 хүн (345 эмэгтэй, 200 эрэгтэй) нь төслийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй профайлинг үйлчилгээнд хамрагдсан.

Зохистой хөдөлмөр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагатай үр чадвар зэрэг ойлголтуудыг залуучуудад түгээх зорилгоор цуврал подкаст хийсэн. Нийт 10 подкаст хийгдсэн ба Төсөл цаашид хөдөлмөр эрхлэлтийн сэдвийг залуучуудын дунд яригдах гол сэдэв байлгах зорилготойгоор залуучуудтай хийх хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна.

2022 оны 9-р сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) хамтран Сүхбаатарын талбайд залуучуудыг татан оролцуулах үйл ажиллагаа бүхий Хөдөлмөрийн Яармаг амжилттай зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг хамгийн том бэрхшээлүүдийн нэг нь тэдний хэрэгцээ шаардлага, хүртээмжийг харгалзсан мэргэжлийн боловсрол сургалтын тухайлсан сургалтын хөтөлбөр байдаггүй явдал юм. Хэрэгцээ шаардлагын үнэлгээнд тургуулан МБС-ын 3 сургалтын хөтөлбөрийг өнгөрсөн жил боловсруулан, энэ

жил туршилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Үүнд: i) Архив, бичиг хэргийн ажилтан, ii) Цахим үйлчилгээний ажилтан, iii) Үйлчилгээний ажилтан. Холбогдох багш, сурагчийн гарын авлагыг мөн боловсруулсан. Сурагчийн гарын авлага нь нийт 22 чадамжийн нэгж агуулсан бөгөөд дохионы хэл бүхий зураглалыг багтаасан. Гарын авлагыг бэлтгэх явцад эрсдэл, хориглох гэх мэт 300 гаруй мэргэжлийн үг, хэллэгийг тайлбарласан тэмдэгтүүдийг шинээр боловсруулсан. Гарын авлагын эх бэлтгэлийг 2022 оны 12-р сард дуусгахаар ажиллаж байна. Сургалтын гарын авлагын цахим хувилбарыг боловсруулж байна. Сургалтын хөтөлбөрүүдийг Улаанбаатар хот дахь Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвд 2 дахь жилдээ туршин, нийт 28 суралцагч бэлтгэгдсэнээс 16 нь Цахим үйлчилгээний ажилтан, 12 нь Архив, бичиг хэргийн ажилтнаар бэлтгэгдээд байна.

Төв аймгийн Баянчандмань Политехник коллежид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх чиглэлээр засварын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн дээр дурдсан сургалтын хөтөлбөрүүдийг тус коллежийн сургалтын хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төслөөс хэрэгжүүлж буй гол мэдээлэл, харилцааны бүтээгдэхүүнүүдийг дохионы хэл ба хадмал орчуулгатай болгосон. Төслийн 2023 оны үйл ажиллагаа, хөтөлбөр, сургалтуудын гарын авлагуудын хүртээмжтэй байдлыг хангахад анхаарч ажиллана.

Алслагдсан нутгийн ажил хайгчдад зориулсан үйл ажиллагаанууд. Тайлангийн хугацаанд Ковид-19-тэй холбоотой хорио цээр цуцлагдсан нь орон нутгийн албан хаагчдад зориулсан чадавхжуулах сургалтыг талбарт хэрэгжүүлэхэд эергээр нөлөөлсөн. 2022 онд төсвийн хүндрэлээс үүдэн Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, аливаа сургалт арга хэмжээг хязгаарласан хэдий ч олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа хязгаарлагдаагүй. Иймд 2022 онд улс даяар Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах болон үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн сэдвээр 2 төрлийн сургалтыг зохион байгуулсан. Профайлинг арга зүй нь үйлчлүүлэгчдэд чиглэсэн, ажил хайж буй этгээдийн хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээг агуулдаг нь алслагдсан нутгийн залуучуудад тохирсон арга барил юм.

2022 онд улсын хэмжээнд 13,600 гаруй ажил хайгчдын үнэлгээг хийж, мэдээллийн санг бүрдүүлсэн.

Жендэрийн тоо мэдээ

Үйл ажиллагаа	Эрэгтэй	Эмэгтэй	Бусад	Нийт	Порпорци
А бүхэлдэхүүн хэсэг - сургалт	844	1363	-	2207	38:62
В бүхэлдэхүүн хэсэг - сургалт	290	400	-	690	42:58
С бүхэлдэхүүн хэсэг - сургалт	455	945	-	1400	33:67
Мэдээлэл үүсгэх үйлчилгээ	2473	3649	-	6122**	40:60
Хөдөлмөрийн яармаг* (НҮБХХ, ХХААБ, ОУХБ хамтран зохион байгуулсан)	107	163	2	272	39:60:1

* Хөдөлмөрийн яармагийн үеэр оролцогчдоос авсан асуулгын үр дүн

**Нийт 13,602 хүнд профайлинг үнэлгээ хийсэн ба 7480 хүний мэдээлэлд боловсруулалт хийгдэж байна.

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Олон улсын валютын сангийн ажлын хэсэг 2022 оны 5 дугаар сард Монгол Улсын цар тахлын дараах үеийн эдийн засгийн сэргэлт нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, хилийн хаалттай байдал, Оросын эсрэг хориг арга хэмжээнүүд шинээр нэмэгдэх, дэлхий нийтэд тулгарч байгаа санхүүгийн хүндрэл, цар тахал дахин дэгдэх зэрэг хүндрэлүүдээс хамаарч удаашрах хандлагатай гэж дүгнэсэн.

Монгол Улс нь 2022 оны төсвийн тодотголд урсгал зардлыг танах, төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгцээт салбарт нэмэгдүүлэх асуудлыг тусгах замаар төсвийн зохистой бодлогыг баримталж байна. Энэ нь шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтыг түргэтгэх, хилийн боомт дээрх зогсонги экспортыг дэмжих зэргээр нийлүүлэлтийн тасалдлын асуудлыг шийдэж байна. Мөн засгийн газраас төсвийн хязгаарлагдмал хөрөнгийг зохистой зарцуулаад зогсохгүй эрчим хүчний хэрэглээг хэмнэхэд туслах зорилгоор эрчим хүчний үнийг зах зээлийн зарчмаар тогтоох нөхцөлийг бүрдүүлэх боломжийг олгож байна.

Үр дүнд суурилсан хөгжлийн төлөвлөгөө: 2022 оны 5 дугаар сарын 26-ны УИХ-ын хуралдаанаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө¹ баталсан. Энэ нь ЭЗХЯ байгуулагдсанаас хойш хийгдэж буй анхны жилийн төлөвлөгөө юм. Төлөвлөгөө нь 5 бүлэг, 18 зорилго, 75 үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд холбогдох шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгүүд тусгагдсан. Чуулганы хуралдаанаар жилийн төлөвлөгөөг хөгжлийн тэргүүлэх зорилттой уялдуулах шаардлагатайг онцолсон.

Дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт болох Хөгжлийн Зорилтот Хөтөлбөрүүдийг боловсруулж, 2022 оны 7 дугаар сард УИХ-д батлуулахаар өргөн барьсан. 2022 оны 10 сард² анхны хэлэлцүүлэг хийгдэж шалгуур үзүүлэлтүүдийн эрэмбэлэлд, салбар хоорондын бодлогын уялдааг сайжруулахыг цохон тэмдэглэсэн.

Төсвийн санхүүгийн удирдлагын шинэчлэл (ТСУ): Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж, түүний удирдлагын (МУНДЗЗТУ)³ тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2022 оны 1 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээр төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн төсвийн орлогын хуваарилалтын шинэ зохицуулалт хэрэгжиж эхэлсэн. Өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд төсвийн хянамгай байдлыг нэмэгдүүлэх, өрийн зохистой түвшинг хангах чиглэлд 2023-2025 онуудад баримтлах дунд хугацааны шинэ стратегийг хэрэгжүүлж байна. Өрийн удирдлагын стратегит ТХЗ-ын санхүүжилтийг дэмжих, холбогдох салбарын яамны хамтын ажиллагааг хангах талаар тухайлсан заалтыг тусгасан⁴. Тэрчлэн төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хувийн хэвшлийн оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих, хувийн хэвшлийг идэвхжүүлэх зорилгоор төр-хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг боловсруулан гаргасан ба энэхүү хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан. Төсвийн зарцуулалтын урт хугацаанд гарах дарамтыг бууруулах зорилгоор Засгийн газраас тэтгэвэр, төрийн өмчит үйлдвэрийн

¹ <https://montsame.mn/mn/read/297798>

² <https://montsame.mn/mn/read/305208>

³ НҮБХХ Уг хуулийг сайжруулахад техникийн дэмжлэг үзүүлсэн

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530615487321>

газрууд, төрийн хөрөнгө оруулалт, санхүүгийн эрсдэлийн удирдлага зэрэгт шинэчлэл хийхээр зорьж байна⁵.

Төсвийн шинэчлэл: УИХ-ын төсвийн байнгын хороо 2022 оны 9 дүгээр сард “Төсвийн бодлогын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж төсөв санхүүгийн шинэчлэл хийхэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн. 2023 оны төсвийн төсөл нь төслийн зорьж буй зорилттой уялдсан 2 асуудлыг i) эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээний чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн санхүүжилтийн тогтолцоог эрчимжүүлэх үлмаар өөр бусад салбарт нэвтрүүлэх ii) гүйцэтгэлд суурилсан төрийн албаны цалингийн шинэчлэлийг тусгасан⁶.

2022 оны 10 дугаар сард Монгол Улсын Их Хурал түүхэнд анх удаа 2023 оны төсвийн төслийн талаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Төсвийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг хийхээс өмнө УИХ-ын цахим хуудсанд 2023 оны төсвийн төслийг нээлттэй байршуулж олон нийтээс санал хүсэлт авсан. Олон нийтээс ирсэн санал, дүгнэлт төдийлөн их биш байсан ч төсвийн ил тод байдлыг хангах, төсөв боловсруулахад олон нийтийн оролцоог хангахад ач холбогдолтой хэлэлцүүлэг болсон.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын шинэчлэл: ХНХЯ нь ядуурлыг бууруулах бодлогын хүрээнд нэн ядуу өрхүүдэд чиглэсэн ‘Төгсөлтийн аргачлал’-түршиж эхлээд байна. Энэхүү аргачлал нь зорилтот бүлгийн иргэдийн үндсэн хэрэгцээг хангахаас эхлээд өрхийн хуримтлал, жижиг бизнес эрхлэх үр чадварыг хөгжүүлэх, сургалтад хамруулах, нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлж өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх гэх мэт цогц дэмжлэгийг багтаасан аргачлал юм. Аргачлалын үргэлжлэх хугацаа 18 сар бөгөөд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 1,500 өрхийг хамруулахаар төлөвлөж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оролцоо” төслийг 2022 онд 4 үе шаттайгаар хэрэгжүүлсэн ба 15-34 насны 1,240 залуучууд хамрагдаж ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг болохуйц салбар хоорондын нэгдсэн мэдлэг мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлсэн.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо 2022 оны 9 дүгээр сард “Халамжаас Хөдөлмөрт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж профайлинг буюу хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээ, орон нутгийн онцлогийг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хувиараа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг боловсронгуй болгох чиглэлээр төслийн хүрээнд хийсэн ажлуудыг танилцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин 2022 онд 59.3 хувь байсан ба эрэгтэй 67.7 хувь, эмэгтэй 51.9 хувь буюу жендерийн зөрүү 15.8 нэгж⁷ байв. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцооны түвшин тогтмол буурсаар байна.

⁵ УИХ-ын 2022 оны намрын ээлжит чуулган, УИХ-ын даргын хэлсэн нээлтийн үг

⁶ <https://online.flippingbook.com/view/240352611/>

⁷ <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Labour%20force%202022%20Q2.pdf&ln=Mn>

Хөдөлмөрийн хяналт. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжсэн ба өмнө нь хасагдсан бүлгүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг өргөжүүлж дүрэм журам, зохицуулалтад олон тооны өөрчлөлт орсон юм. Өнөөдөр албан ба албан бус хэвшилд ажлын байранд гэнэтийн хөдөлмөрийн шалгалт хийхийг хуулиар зөвшөөрсөн байгаа нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хяналтын тухай 81, 129 дүгээр конвенцын гол зарчмыг тусгасан чухал алхам юм.

2022 оны 9 дүгээр сард Засгийн газрын шийдвэрээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт (МХЕГ) бүтцийн өөрчлөлт хийж, хувийн хэвшил/аж ахуйн нэгжийн ачааллыг хөнгөвчлөх зорилгоор техникийн хяналт шалгалтыг салбарын яамдад шилжүүлсэн.

МХЕГ нь нийт 26 төрлийн техникийн төрийн хяналтыг одоогоор хийдэг. Бүтцийн өөрчлөлтөөр хөдөлмөрийн хяналт, шалгалтыг 2023 оны 1 дүгээр сараас эхлээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжүүлэхээр болсон.

Хөдөө аж ахуйн салбар: 2021 онд Сүм хөгжлийн сан өргөжиж, улс даяар Хоршоог хөгжүүлэх сан болж, шинэчилсэн зохион байгуулалтад орсон. “АТАР-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аян 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн орон даяар хэрэгжиж эхэлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал” үндэсний шинэ хөдөлгөөн нь 2022 онд батлагдсан бөгөөд 2026 он хүртэл хэрэгжинэ. Энэхүү хөдөлгөөн нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авах тухай тусгасан.

3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ҮР ДҮН

ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮН – БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

Төслийн зорилт 1-д оруулсан хувь нэмэр:

Зорилт 1	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	Хэрэгжилтийн үр дүн
Бодлого, үр дүнтэй уялдсан төсвийн хөтөлбөр байна	Үр дүнд суурилсан ДХЗХ, салбарын болон ТХЗ-ын зорилтот түвшин бүхий жилийн төсвийн санал боловсруулж, СЯ-тай хэлэлцсэн яам, салбарын тоо (хувь)	Байгаль орчин, эрүүл мэндийн салбарын туршилт (2019 он)	2 салбар (13%)	Төлөвлөсний дагуу 3 салбар (ХНХЯ, ХХААХҮЯ) (НҮБХХ-ийн өөр төслийн төсөл дэмжлэгтэй БШУЯ).

Хоёр (ХНХЯ ба ХХААХҮЯ) яам нийт 13 хөтөлбөрийг Сангийн яамнаас баталсан үр дүнд суурилсан загварт нийцүүлж 2022 онд боловсруулж, өргөн мэдүүлж баталсан. Завсрын үр дүнгийн тайлангаар туршилтын яамдад туршилтын журмаар хэрэглэгдэж буй үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалыг бусад салбаруудад өргөжүүлэх боломжтой нь харагдсан. Доорх хүснэгт үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн жилийн ахиц дэвшлийг харуулсан.

2021 оны санхүүгийн жил	2022 оны санхүүгийн жил	2023 оны санхүүгийн жил
Туршилтын яамдад (БОАЖЯ, ЭМЯ, БШУЯ) ТХЗ-ын зааварчилгаанд нийцсэн төсвийн удирдамж	Туршилтын яамдад (БШУЯ, ХНХЯ, ХХААХҮЯ) тодорхой зааварчилгаатай төсвийн удирдамж	Туршилтын яамдад (БШУЯ, ХНХЯ, ХХААХҮЯ) зориулан хавсралт 1-ийг сайжруулах төсвийн удирдамж
Үр дүнд суурилсан төсөвлөлтөөс өмнө үр дүнд суурилсан төлөвлөлт хийгдээгүй	Үр дүнд суурилсан төсөвлөлтөөс өмнө үр дүнд суурилсан төлөвлөлт хийгдээгүй	Үр дүнд суурилсан Дунд хугацааны хөгжлийн бодлого (Үндэсний зорилтод хөтөлбөрүүд) боловсруулагдаж УИХ-аар батлагдах шатандаа орсон.
Үр дүнг зөвхөн салбарын үндсэн үзүүлэлтээр тодорхойлсон	Үр дүнг яамны/хөтөлбөрийн нэг түвшнөөр тодорхойлсон	Үр дүнг 4 үе шатаар тодорхойлсон, үндэсний, салбарын, яамны, хөтөлбөрийн
Дээд түвшний үр дүнд оруулсан хувь нэмэр, харилцан уялдаа холбоо тодорхой бус байсан	Дээд түвшний үр дүнд оруулсан хувь нэмэр, харилцан уялдаа холбоо тодорхой бус байсан	Дээд түвшний үр дүнд оруулсан хувь нэмэр, харилцан уялдаа холбоо илүү тодорхой болсон
Тохирох түвшинд хамааралгүй янз бүрийн өөр түвшний үр дүнгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ашигласан	Тохирох түвшинд хамааралгүй янз бүрийн өөр түвшний үр дүнгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ашигласан	Тохирох түвшинд нь хамаарах байдлаар нь гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эрэмбэлсэн
Зорилтуудыг аймаг, дэд нэгжид задлаагүй яамны ерөнхий зорилт хэвээр үлдсэн	Зорилтуудыг аймаг, дэд нэгжид задлаагүй яамны ерөнхий зорилт хэвээр үлдсэн	Зорилтуудыг аймгуудад хуваарилагдсанаар аймаг бүр өөрсдийн хүрэх ёстой зорилтыг

		хэрэгжүүлж улсын зорилт биелэх боломжтой
Туршилтын яамд ба Сангийн яамны хооронд Төсвийн тойм хэлэлцэх үеэр туршилтын яамдууд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд үндэслэн төсвийн төслөө албан ёсоор хамгаалсан	Туршилтын яамд ба Сангийн яамны хооронд Төсвийн тойм хэлэлцэх үеэр туршилтын яамдын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд үндэслэн төсвийн төслийг хүлээн авсан.	Сангийн яам ба холбогдох яамд Төсвийн тойм хэлэлцэх үеэр үр дүнд суурилсан төсөвлөлтийн шалгуурыг боловсруулж, хэсэгчлэн ашигласан.
Төсвийн хөтөлбөрийн ангилал өмнөх шигээ хэвээр үлдсэн. Ирэх оны төсвийг боловсруулахдаа туршилтын яамд шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тайлагнаагүй.	Төсвийн хөтөлбөрийн ангилал өмнөх шигээ хэвээр үлдсэн. Туршилтын яамд 2022 оны эцэст гүйцэтгэлийн үзүүлэлтээ тайлагнах төлөвтэй байна	Туршилтын яамдын Төсвийн хөтөлбөрийн ангиллыг боловсруулсан. Туршилтын яамд төрийн санд албан ёсоор гүйцэтгэлийн үзүүлэлтээ тайлагнах төлөвтэй байна
Туршилтын яамд ба холбогдох аймгийн хэлтсүүд үр дүнд суурилсан төсөвлөлтийн сургалтад хамрагдсан. Сургалт салбарын гүйцэтгэлийн үзүүлэлт болон төсөв боловсруулахад чиглэсэн.	Туршилтын яамд ба холбогдох аймгийн хэлтсүүд үр дүнд суурилсан төсөвлөлтийн сургалтад хамрагдсан. Сургалт салбарын гүйцэтгэлийн үзүүлэлт болон төсөв боловсруулахад чиглэсэн.	2022 оны эхээр туршилтын 3 яам үр дүнд суурилсан төлөвлөлт ба үр дүнд суурилсан төсөвлөлтийн хосолсон сургалтад хамрагдсан. Дараа нь туршилтын яамд холбогдох аймгийн хэлтсүүдэд биечлэн сургалтыг улс даяар зохион байгуулсан. Сургалт гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт ба үр дүнд суурилсан төсөвлөлтийн түвшингийн ялгаа ба үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн талаар явагдсан.

Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсан (ЭЗХЯ), Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулсан, Үндэсний хөгжлийн жилийн төлөвлөгөөг УИХ-аах хэлэлцсэн, 2022 ба 2023 оны төсөв боловсруулах ажил, Үндэсний Аудитын газрын (ҮАГ) зөвлөмж, ҮДСТ талаар олон тооны сургалт зохион байгуулах төслийн санаачилга, зардлын тойм судалгаа зэрэг олон хүчин зүйлээс харахад үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлт, удирдлагын төсвийн бодлогыг батлах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Бодлого, санхүүгийн хэлтсийн мэргэжилтнүүд бодлого, төсвийн уялдаа нь нэгдсэн үр дүнд хүрэх, зорилтод бүлгүүд хамтарч ажиллаж боломжийг бүрдүүлэх учир бодлого, төсвийн уялдааны хэрэгцээ байгаа гэж үзсэн. Уг хэрэгцээ нь улс даяар зохион байгуулагдсан үр дүнд суурилсан төлөвлөлт ба ҮДСТ сургалтын үеэр мөн ажиглагдсан.

НЭГДҮГЭЭР БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А. БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

Уг бүрэлдэхүүний хүрээнд төсөл дараах дөрвөн үндсэн үр дүнд хүрэхийг зорьсон:

A.1 Төсвийн төлөвлөлтийг үр дүнгийн мэдээлэлд үндэслэн, стратегич байдлаар боловсруулах

A.2 Үр дүнд суурилсан төсвийн танилцуулга,

A.3 Нотолгоонд суурилан төсөв боловсруулах,

А.4 Үр дүнд суурилсан төсөв, ТХЗ-д чиглэсэн төсвийн төлөвлөгөө боловсруулах СЯ, салбарын яамдын чадавхыг бэхжүүлэх

А.1 ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ҮР ДҮНГИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН СТРАТЕГИЧ БАЙДЛААР БОЛОВСРУУЛАХ (ДХЗХ)

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	Хэрэгжилтийн үр дүн 2022
А.1.1 ДХЗХ-г шинэчлэх төлөвлөгөө боловсруулна	А.1.1.1. ДХЗХ болон ҮДСТТ-ийн шинэчлэлийн замын зураг, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах	0	-	Хугацаандаа хэрэгжиж байна. ДХЗХ болон ҮДСТТ-ийн шинэчлэлийн замын зураг, гол үйл ажиллагаануудыг боловсруулсан, СЯ, ЭЗХЯ, бусад оролцогч талуудтай харилцан санал солилцож байна.
	А.1.1.2. Төлөвлөгөөний биелэлтэд жил бүр үнэлгээ хийх	н/а	1	Хугацаандаа хэрэгжиж байна. Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг албан ёсоор дүгнээгүй ч замын зураглал гарч, гол үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж байна.
А.1.2 Үр дүнд суурилсан ДХЗХ-г боловсруулах тогтолцоо бүрдэнэ	А.1.2.1. ДХЗХ-ний загвар, маягыг шинэчлэгдэж, СЯ баталснаар үр дүн, тэргүүлэх чиглэлд суурилсан төсвийн хэлэлцүүлэг хийгддэг байх	БОАЖЯ түршилт (2019 он)	ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ	Хугацаандаа хэрэгжиж байна. Түршилтын яамдын 2023 оны төсвийн төсөл нь төсвийн удирдамжид тусгагдсан ҮДСТТ-н маягын дагуу боловсруулагдсан.
	А.1.2.4. Сонгосон яамд үр дүнд суурилсан ДХЗХ, төсвийн саналаа боловсруулсан байх	БОАЖЯ түршилт (2019 он)	Багадаа 2	Хугацаандаа хэрэгжиж байна. ХНХЯ, ХХААХҮЯ, БШУЯ гэсэн 3 яам ҮДСТТ-ийн дагуу саналаа боловсруулж УИХ-аар батлуулахаар өргөн барьсан.
	А.1.2.5. Сонгосон яамдын үр дүнд суурилсан ДХЗХ-г хэлэлцсэн байх	БОАЖЯ түршилт (2019 он)	2	Хугацаандаа хэрэгжиж байна. Түршилтын 3 яам үр дүнд суурилсан жилийн төсвийн санал боловсруулсан.

Төсвийн төлөвлөлтийг үр дүнгийн мэдээлэлд үндэслэн, стратегич байдлаар боловсруулах (ДХЗХ) нь ҮДСТТ-ийн ахисан түвшний үе шатуудын нэг бөгөөд урт ба дунд хугацааны үр дүнгийн хүрээ, бүх салбарын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт, өмнөх жилүүдийн санхүүгийн өгөгдөл мэдээлэлд үндэслэн

дунд хугацааны төсөвлөлтийг хийнэ. ДХЗХ нь малгай нэр томьёо⁸ байдлаар хэрэглэгдэх ба энэ нь дараалсан гурван үе шаттай, тэдгээр нь ДХТХМ, ДХТХ, ДХГХ юм.

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ) нь тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлан салбаруудын зарцуулалтад шаардлагатай нөөцийг олон жилээр хуваарилах ба ингэхдээ нэгдсэн нөөцийн хязгаарыг дээрээс доош чиглэлтэй тодорхойлдог.
- Дунд хугацааны төсвийн хүрээ (ДХТХ) нь агентлагуудын доороос дээш гаргасан хүсэлтийн дагуу зарцуулалтад шаардлагатай нөөцийн хуваарилалтыг олон жилийн хүрээг ашиглан, дээрээс доош чиглэлтэй хийдэг.
- Дунд хугацааны гүйцэтгэлийн хүрээ (ДХГХ) нь ДХТХ-н дээр гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлтүүд, хэмжигдэхүүн, зорилтуудыг нэмсэн байдлаар тодорхойлогддог.

Иймд 2023-2024 онуудад хэрэгжүүлэх төслийн техникийн дэмжлэг нь 2021, 2022 онд хийгдсэн чухал алхмуудад суурилан, ДХТХМ-ийн тогтолцооноос ДХТХ/ ДХГХ-рүү шилжих шилжилт, төсөвлөлтийн стратегийн үүргийг нэмэгдүүлэх зэрэгт чиглэнэ. ДХТХ/ ДХГХ-нд чиглэсэн гол алхмуудыг дараах хэсгүүдэд тайлбарласан болно.

А.1.1 Үр дүнд суурилсан төсвийг (ҮДСТ) шинэчлэх шинэчлэлийн төлөвлөгөө. Төслөөс 2022 онд боловсруулсан үзэл баримтлалын тэмдэглэл, баримт бичгүүдэд ДХТХ/ДХГХ-рүү шилжих болон ҮДСТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай гол зарчим, аргазүй, нөхцөл байдлын оношилгоо, бэлтгэл ажлуудыг тусгасан.

Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг-ийг (“Хөгжлийн Зорилтот Хөтөлбөр”)⁹ үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйгээр хэвтээ ба босоо уялдааг ханган, Алсын хараа 2050-д нийцүүлж 2021-2022 онд боловсруулсан. Улсын секторт үр дүнг хангах төлөвлөгөө боловсруулах, мөн төсвийн зарчмыг баримтлахад урт хугацааны хараа шаарддаг. Техникийн дэмжлэг нь Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага (ҮДСНУ)-ын аргазүйг баримталсан ба энэ нь манай төрийн байгууллагуудад өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ аргазүй юм. Иймд баримт бичиг боловсруулах явцад ҮДСНУ-ын ойлголтыг бий болгох зорилгоор сургалт, хэлэлцүүлгүүдийг эрчимтэй зохион байгуулсан. Энэхүү техникийн дэмжлэгийг НҮБХХ-ийн өөр төслөөс санаачлан, уг Төслөөр дамжуулан хэрэгжүүлж байна. Дунд хугацааны бодлогын баримт бичиг болох ХЗХ-үүд батлагдсанаар ДХТХ/ДХГХ болон ҮДСТ-д шилжих чухал урьдчилсан нөхцөл хангагдана.

Үр дүнд суурилсан төлөвлөлтийг ҮДСТ-тэй уялдуулах аргазүйг боловсруулж, түршсан. Үр дүнд суурилсан төлөвлөлт ба үр дүнд суурилсан төсөвлөлтийн гол зарчим, аргазүйг 2022 онд боловсруулсан. Тус аргазүйд үндэслэн ҮДСТ-ийн зарчмуудыг тодорхойлж буй бөгөөд энэ нь ҮДСТ ба

⁸ Төсөв боловсруулах үйл явцыг сайжруулах институци ба хэрэгслүүд, Төсвийн асуудал эрхэлсэн хэлтэс (ТАЭХ), ОУВС, ДХЗХ-ний бичиг баримт 2014

⁹ <https://d.parliament.mn/tusul/20dc7b53-b8e0-44a9-9095-4e51c9264148>

өнөөгийн төсөв боловсруулах системийн ялгааг харуулсан. Туршилтын яамд уг аргазүйг 2023 оны төсвийн санал боловсруулахад туршсан ба бусад яамдад мөн хэрэглэх боломжтой.

ҮДСТ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үе шат, арга хэмжээнүүд болон мөн ДХТХМ-ээс ДХТХ/ДХГХ-рүү шилжилтийг гол элементүүдийг тодорхойлсон. Үүнд: 2022 онд ҮДСТ-ийн суурийг тавьж, 2023 онд бүрэн туршилт хийж, 2024 онд үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг бүрэн хэрэгжүүлэхийг зорьсон. 2024 онд хэрэгжилтийг хангахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт, маягтуудыг боловсруулсан. Мөн ҮДСТ болон ДХТХ, ДХГХ-ний замын зургийг урьдчилсан байдлаар боловсруулж СЯ, ЭЗХЯ-д танилцуулсан. Энэхүү шинэлэг ойлголт, зарчмын талаар нэгдсэн ойлголт бий болгох зорилгоор туршилтын яамдад сургалт, зөвлөгөө өгч байгаа ба энэ нь цаашдаа үр дүнтэйгээр хамтран ажиллах суурийг бэхжүүлж байна.

ҮДСТ-ийг хэрэгжүүлэх замын зураг нь салбарын төсвийн зарлагын шинжилгээ, салбарын тэргүүлэх чиглэлүүдийг боловсруулах, гүйцэтгэлийн үзүүлэлт, хөтөлбөрүүдийн ангиллыг уялдуулах зэрэг салбарын яамдын чиг үүрэгт хамаарах арга хэмжээг агуулсан. Үүнээс гадна ДХТХ/ДХГХ-ний шилжилтэд төсвийн дээд хязгаарыг тогтоох, салбаруудын орлогыг тооцох, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардал, жил дамнасан хөтөлбөрийн төсөв, шинэ бодлогын хөтөлбөрүүд гэх мэт СЯ талаас хийх шаардлагатай системийн өөрчлөлтийн ажлууд ч тусгасан. Үзэл баримтлалын тэмдэглэлүүдэд үндэслэн 2022 онд ДХТХ/ДХГХ, стратегийн төсөвлөлтийн асуудлаар СЯ, ЭЗХЯ-д техникийн болон бодлогын түвшний зөвлөгөөн хийж эхэлсэн. Холбогдох алхмууд 2023 онд хийгдэнэ.

“ДХТХМ-д тусгагдсан салбарын нэгдсэн төсвийн болон нөөцийн хязгаарт үндэслэн, ҮДСТ нь яамд өөрийн эрхэлсэн асуудлын хүрээнд салбарын үндсэн чиглэлийг биелүүлэхэд шаардлагатай нөөцийг дунд хугацааны төсвийн хязгаарын хүрээнд хуваарилна. Яамдын зардлын дээд хязгаарыг тогтоохдоо өмнөх жилүүдийн хөтөлбөрийн зарцуулалт болон гүйцэтгэл, ирэх онуудын үндэсний болон салбарын тэргүүлэх чиглэлд оруулах хувь нэмэр зэргийг үндэс болгоно. Яамдын тэргүүлэх чиглэлийн бодлого, зардлын дээд хязгаар нь дунд хугацааны стратегийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад гол чиглэл болно” (ДХТХМ-ээс ДХТХ/ ДХГХ-д шилжих Үзэл баримтлалын Тэмдэглэл).

Гол оролцогч талууд үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт рүү шилжих шилжилтийг дэмжихээ илэрхийлэв. ТСУ/ҮДСТ-ийн шинэчлэлийн явцыг хурдасгах зорилгоор төслийн олон улсын зөвлөхүүд 2022 оны 4, 8 дугаар саруудад Засгийн газрын хэрэг эрхлэх газар, СЯ, ЭЗХЯ, ҮАГ, салбарын яамд, ХНХЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Европын Холбоо, АХБ, ДБ-тай хэд хэдэн дээд хэмжээний уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан. Уулзалтын үеэр ихэнх оролцогч талууд үр дүнд суурилсан төсөвлөлтийн шинэчлэлийг хийхэд салбарын туршилтаас илүү засгийн газар түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг дээр эерэг байр суурь илэрхийллээ. Засгийн газрын түвшинд хийх шилжилт нь гурван үе шаттайгаар 2-3 жил үргэлжилнэ гэж тооцсон.

Шилжилтэд зарцуулах хугацаа, хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг 2022 онд харилцан зөвшилцсөн ба санал болгож буй үйл ажиллагааг СЯ-ны ТСУ-ын шинэчлэлийн стратегид тусгасан. Гэвч 2023 онд ҮДСТ-ны үндсэн заримуудыг үйл ажиллагааны удирдамжид хөрвүүлэн илүү бодитой ажил хэрэг болгох талаар хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг үргэлжлүүлэх шаардлагатай.

Гарч буй хүндрэлүүд: Монгол улсын төрийн удирдлагын систем нь хэт хууль, журам, удирдамж, дүрэмд суурилсан байдаг нь шаардлагатай үйл ажиллагааг эхлэхээс өмнө хууль, эрх зүйн орчин бүрдсэн байхыг шаарддаг. Энэ нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт гэх мэт шинэ аргагүй нэвтрүүлэхэд тодорхой хүндрэл учруулж байна. Жишээлбэл, Хөгжлийн Зорилтот Хөтөлбөр буюу дунд хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнд суурилж боловсруулахаар төлөвлөгдөж байсан боловч Төслийн аргагүй, баталсан аргачлал хоёр зарим талаараа зөрүүтэй байсан нь ҮДСНУ-н зарчмыг бүрэн баримталж чадахгүй байхад нөлөөлсөн.

Өнгөрсөн хоёр жил төрийн албан хаагчид, ТХН болон дотоодын зөвлөхүүд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагыг үндэсний орчин нөхцөлд хөрвүүлэх талаар их зүйл суралцсан жил байлаа.

А.2 ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	2022 оны бодит хэрэгжилт
А.2.1 Төсвийн багц хөтөлбөрүүд бодлого, үр дүнтэй уялдсан байна	А.2.1.1. Бодлогын зураглалыг төсвийн хөтөлбөрийн бүтэцтэй харьцуулах (ҮДСТ агуулгад хамаарах бүтэцлэгдсэн мэдээллийг байршуулахын тулд үндэсний хөтөлбөрүүдийг дахин загварчлах)	0	2 салбар	Хугацаандаа хэрэгжиж байна. Хоёр салбар төсвийн 2023 оны төсвийн төслийг ҮДСТ-өөр боловсруулж, төсвийн хөтөлбөрөө дахин боловсруулсан. 2 салбарт хэрэгжүүлсэн.
	А.2.1.2. ТХЗ-д нийцүүлэхээр хянуулсан хөтөлбөрийн төсвийн ангилал	0	2 салбар	Хугацаандаа хэрэгжиж байна. 2 салбарт хэрэгжүүлсэн.
	А.2.1.3. ТХЗ-ын зорилтуудыг улсын төсвийн Хавсралт 1-д нэгтгэх	2 салбарын төсөл (2019)	4 салбар	Хугацаандаа хэрэгжиж байна. НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй өөр төслийн хүрээнд хийгдсэн боловсролын салбарыг оруулаад 3 салбарт хэрэгжүүлсэн.
А.2.2 Зардлын гүйцэтгэл буюу үр дүнгийн хяналт-шинжилгээ, тайлагнал	А.2.2.1. Гүйцэтгэлийн тайлангийн загвар, форматыг боловсруулах	0	Шинэ загвар, журам	Хугацаандаа хэрэгжиж байна. удирдамж, маягтын төслийг боловсруулж СЯ-д танилцуулсан.

А.2.3 ТХЗ-ын Иргэний төсөв	А.2.3.1. Иргэдийн төсөвт бодлогын тэргүүлэх чиглэл, үр дүнг нэгтгэх	Иргэдийн төсөв аль ч салбарын зорилтот болгоогүй (2018)	2 төсөл	<p>Хугацаандаа хэрэгжиж байна. 2023 оны төсөв батлагдмагц 2023 оны Иргэдийн төсөвт бодлогын тэргүүлэх чиглэл, үр дүнг тусгана</p> <p>2023 оны эхэнд 2 салбар гүйцэтгэнэ.</p>
----------------------------	---	---	---------	---

А.2.1 Бодлого, үр дүнтэй уялдсан төсвийн хөтөлбөр: “Төсвийн хөтөлбөр” эсвэл төсвийг хөтөлбөрөөр ангилах ажил нь 12 жилийн өмнө танилцуулагдсан боловч гүйцэтгэл, үр дүнтэй холбоогүй зөвхөн үйл ажиллагааны гарчиг төдий ашиглагдаж байна. Төсвийн захирагчдын ашиглаж буй программ хангамжтай холбоотойгоор шинэчилсэн ангиллыг тухай бүрд оруулах боломжгүй байсан. Европын холбооны санхүүжилттэй Дэлхийн Банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” (ТСТББ), төслийн зөвлөхүүдтэй тус Төсөл хамтран хөтөлбөрийн ангиллыг шинэчлэх, түүнийг туршилтын хоёр салбарт хэрэгжүүлж ажлуудыг хийж байна.

Туршилтын хоёр яам 2023 оны төсвөө үр дүнд суурилсан маягтын дагуу үндэсний хүрэх үр дүнг салбарын бодлого, зорилттой уяж, холбогдох шалгуур үзүүлэлтийг тусгасан байдлаар бэлтгэсэн. СЯ нь 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан 2023 оны **Төсвийн Удирдамжид** туршилтын хоёр яам болох ХХААХҮЯ, ХНХЯ-д зориулан ҮДСТ-ны маягт, ажлын хүснэгт, зааварчилгааг тусгасан.

Туршилтын хоёр яамдад олон улсын ба дотоодын зөвлөхүүд шаардлагатай техникийн дэмжлэг үзүүлсэн. ТЕЗ-ын хүрэх үр дүнгийн хүрээ (ТЕЗХҮДХ), Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хүрээ (ХХҮДХ), хяналт үнэлгээний хүрээнүүдийг дунд хугацааны үндэсний хөгжлийн бодлогын баримт бичиг, ХЗХ-үүдэд тусгагдсан үндэсний зорилт шалгуур үзүүлэлтүүдтэй уялдаатайгаар боловсруулсан. Улсын болон салбарын тэргүүлэх чиглэлийн хөндлөн ба босоо уялдаа холбоог тодорхойлоход Хөтөлбөрийн Логик Уялдаа холбоо (ProLL)-ны аргагүй (оролцогч талуудын шинжилгээ, асуудлын мод, шийдлийн мод) –г ашигласан. Төсвийн **төслийн хяналтын хуудсыг** мөн боловсруулсан.

ҮДСТ-н маягтыг орон нутгийн түвшинд боловсруулж, туршсан. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээг боловсруулахад хэвтээ болон босоо уялдааг хангах зорилгоор орон нутгийн онцлог асуудал, хүрэх үр дүнг нэгтгэдэг. Гэвч төв болон орон нутгийн нэгжүүдийн аль нь ч бодлогын тэргүүлэх чиглэл, тоон ба чанарын зорилтуудаа тодорхойлохдоо нэгдмэл цогц байх арга хандлагыг ашигласан эсэх нь тодорхойгүй байсан. Иймд **Хөвсгөл аймгийн жишээн дээр** төсөв боловсруулж буй үйл явц, хөтөлбөрийн кодчилал, тайлагналын өнөөгийн байдалд кейс шинжилгээ хийсэн. Туршилтаар төсвийн гурван хөтөлбөрийг (хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, байгаль орчин) ҮДСТ бүтэц рүү хөрвүүлсэн. Холбогдох зөвлөмжийг боловсруулсан ба зөвлөмж, саналыг СЯ болон орон нутгийн удирдлагын оролцогч талуудад танилцуулсан. Бодлого төсвийн уялдааг хангах зорилгоор ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйг ашиглан төсвийн удирдамж, холбогдох арга зүйн зааврыг боловсруулах чиглэлийн ажлууд хийгдсэн. **Төсвийн ангиллын хэрэглээний тухай санал болгож буй загваруудыг** (хөтөлбөр, эдийн засаг, зориулалтын ангилал) СЯ 2022 оны 12-р сард хийхээр төлөвлөж буй төсвийн ангиллын өөрчлөлтөд тусгахаар хүлээн авсан.

Салбарын хүрэх үр дүнг орон нутгийн түвшинд ҮДСТ-ийн маягт ашиглан буулгах туршилтын ажил 9 ба 10 дугаар сард зохион байгуулсан ‘Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүй’ сэдэвт сургалтын үеэр хийгдсэн.

А.2.2 Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, тайлан: Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлт нь гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, тайлангүйгээр амжилттай хэрэгжих боломжгүй юм. Одоо хэрэглэж буй хяналт шинжилгээний систем, төсвийн гүйцэтгэлийн тайланг үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн ерөнхий агуулгын хүрээнд сайжруулах хэрэгтэй.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн одоогийн нөхцөл байдал хяналт хийж тайлангийн маягтыг үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлтийн зарчимтай уялдуулж 2022 онд шинээр боловсруулсан. Гүйцэтгэлийн мэдээлэл, төсвийн нөөцийн хуваарилалт, үйл ажиллагааны үр дүнгийн гүйцэтгэл зэрэг нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагддаггүй байсныг энэ судалгаагаар олж илрүүлсэн бөгөөд энэ нь улмаар төсвийн үр ашиг, үр дүнтэй байдлын шинжилгээ хийхэд саад учруулдаг болохыг тэмдэглэсэн. Иймд **үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн боловсруулах удирдамж** боловсруулан СЯ-аар хянуулахаар хүргүүлсэн ба тус удирдамж нь үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйтэй уялдаатай боловсруулагдсан. Боловсруулсан тайлангийн загвар дараах зүйлсийг агуулдаг i) ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ii) хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэл iii) Хөтөлбөрийн бүтээгдэхүүн, арга хэмжээний үр дүнгийн гүйцэтгэл iv) ТЕЗ-ийн үр дүнд суурилсан хөтөлбөрүүдийн үр дүнгийн гүйцэтгэл (эдийн засгийн ангиллаар) v) ТЕЗ-ийн үр дүнд суурилсан хөтөлбөр арга хэмжээний төсвийн гүйцэтгэл/ эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар.

Төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж буй практик, түүнийг сайжруулахтай холбоотой санал болгож буй маягт, зөвлөмжийг СЯ-ны Төрийн сангийн холбогдох албан хаагчдад танилцуулсан.

Гарч буй хүндрэлүүд: Төсвийн удирдамж, боловсруулалт, төсвийн саналын хяналт, хэрэгжүүлэлт, хяналт шинжилгээ, тайлагнал болон бусад захиргааны үйл явц хоорондоо уялдаж гэмээ ҮДСТ бодитой хэрэгжих боломжтой. Одоогоор, ҮДСТ нэвтрүүлэх ажил нь зөвхөн туршилтын байгууллагуудын төлөвлөлт, төсөвлөлт боловсруулах шатанд хийгдэж байна. Энэ нь ойрын хугацаанд зохицуулалт, хэрэгжилтийн орчныг бүрдүүлж, нэвтрүүлэлтийг өргөжүүлэхгүй бол хэрэгжилт ухрах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор СЯ-ны төрийн сангийн зөвлөх баг гүйцэтгэлд суурилсан тайлагналын маягт, гарын авлагыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Мөн төслийн зүгээс холбогдох талуудтай (ЭЗХЯ болон ЗГХЭГ гэх мэт) уулзалтуудыг зохион байгуулж нэгдсэн чиглэлээ тодорхойлж, хамтрах талбараа тогтоохоор зорин ажиллаж байна.

А.3 НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	2022 оны бодит хэрэгжилт
А.3.1. Төсвийн шийдвэрийг мэдээлэл, нотолгоонд үндэслэн гаргадаг байхын тулд салбарын төсвийн зарлага, институцийн бүтцэд дүн шинжилгээ хийх	А.3.1.1. ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн салбарын төрийн үйлчилгээ, төсвийн үр нөлөө, өгөөжийг судлах	0	1 судалгаа	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт ХЭДС, түүний хөтөлбөрүүдийн үр дүнтэй, үр ашигтай байдлыг үнэлсэн.
	А.3.1.2. Салбарын төсвийн зарлагын болон институцийн үнэлгээ (ТЗИУ/PEIR) хийж нотолгоонд суурилсан төсөв батлах	0	1 ТХЗ тэргүүлэх салбар ТЗИУ	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Хөдөлмөрийн салбар болон Хөвсгөл аймгийн ТЗИШ хийгдэж байна. Зам тээврийн салбарт НҮБХХ-ийн өөр төслийн ТЗШ хийгдсэн.
А.3.2. Салбарын хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлийг сайжруулна	А.3.2.1. Салбар доторх ба салбар хоорондын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг зөвлөмжийг ТХЗ-н зорилтод тулгуурлан улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, ДХҮХ-тэй уялдуулан боловсруулсан	0	-	Хугацаандаа хэрэгжиж байгаа. ЭЗХЯ-д улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах арга зүйн дэмжлэг үзүүлж байна.
А.3.3. Бодлого хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог сайжруулна	А.3.3.1. Үндэсний хөтөлбөрүүдийн зардлын тооцоо хийх	АХБ-ны хийж гүйцэтгэсэн 3 зардлын тооцоо (эрүүл мэнд)	Бүх хөтөлбөрийн зардлыг тооцож дууссан	Хугацаандаа хэрэгжиж байгаа. МБС ба хөдөлмөрийн салбарт тооцоо хийгдсэн

А.3.1. Салбарын төсвийн зарлага, институтийн шинжилгээ хийж нотолгоонд суурилсан төсөв:

ТЗИШ нь ирэх онуудын төсвийн хуваарилалтыг дэмжих зорилгоор өмнөх жилүүдийн зарцуулалтыг хянаж, татвар төлөгчдийн мөнгийг юунд зарцуулсан тухай төсвийн зарцуулалтын үр өгөөж, мөнгөний үнэ цэний үзүүлэлтийг ашиглан үнэлгээ хийдэг. Төсөл 2021 онд хөдөлмөр эрхлэлт, хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээг хийсэн. 2022 онд эдгээр салбаруудын төсвийн зарлагын шинжилгээг шинэчлэн боловсруулах ажил эхэлсэн бөгөөд 2022 оны

сүүл эсвэл 2023 оны эхээр дуусгах төлөвтэй байна. Тус шинжилгээгээр өмнөх ажлын сургамж дээр үндэслэн, аргагүйг сайжруулах, олон улсын сайн туршлагыг тусгахаар зорьж байна.

Хэдий 2021 онд төсвийн зарлагын шинжилгээг хоёр салбарт хийсэн¹⁰ ч төсвийн санал боловсруулах, төсвийн төсөл хянахдаа шинжилгээний үр дүнг ашиглах байдал дутмаг байна. ДХТХ, ДХГХ-г нэвтрүүлж, хөтөлбөрийн үялдаа, гүйцэтгэлийн шалгуур, хөтөлбөрийн ангилал, тайлагнал сайжрахын зэрэгцээ зарлагын шинжилгээний хэрэглээ өсөх боломжтой.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үйл явц, хугацаа, тулгамдаж буй асуудлыг шат шатанд нь шинжилсэн бөгөөд санхүүжилтийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмжийг боловсруулсан. ХЭДС нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, үйл ажиллагааг санхүүжүүлэх гол эх үүсвэр болдог. Судалгаагаар хөтөлбөрийн зорилго, агуулга, хамрах хүрээ, зорилтот бүлэг, санхүүжилт, хяналт шинжилгээ, тайлагналыг үнэлсэн. Судалгаанд Сонгинохайрхан дүүрэг, Дорноговь, Өвөрхангай, Орхон аймгууд хамрагдаж газар дээрх бодит байдлын үнэлгээ хийсэн. Тайлант хугацаанд судалгааны мөрөөр дараах дөрвөн үйл ажиллагааг гүйцэтгэсэн. Үүнд:

- Санхүүжилтийн үр шимийг дээшлүүлэх, санхүүжилт олгогдоогүйгээс болж үүсэх үйлчилгээний доголдоос сэргийлэх зорилгоор 2023 оноос эхлэн оны эхэнд зарцуулалт хийх тухай анхны хэлэлцээрийг СЯ болон ХНХЯ хооронд хийсэн (одоогоор 4 ба 10 сард биш). Үүнтэй уялдуулаад СЯ-ны Төрийн сангийн газраас санхүүжилт олгох нөхцөлийг боловсруулсан.
- Эмэгтэйчүүдийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр гэх мэт ХЭДС-н хөтөлбөр хооронд төлбөрийн үян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төлбөрийн шинэчилсэн журмыг боловсруулсан. Энэ өөрчлөлт нь тухайн байршилд байгаа ихэнх үйлчлүүлэгчид тухайн зорилтот бүлэгт хамааралгүй тохиолдолд санхүүжилтийг нэн шаардлагатай зорилтот бүлэгт зориулах боломжийг бүрдүүлсэн.
- Аймгуудаас ирүүлсэн төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэх аргачлалыг нягталж байна. Өмнө нь аймгуудын ХЭДС-ын төсвийн хуваарилалтын шалгуурыг хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн тоо, өрхийн тоо, ядуурлын зурвасаас доор байгаа хүм амын тоо зэргийг харгалзаж олгодог байсан бол шинэчлэлийн хүрээнд төсвийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан үзүүлсэн үйлчилгээний бодит үр дүн, гарцтай уялдуулж хуваарилдаг болох юм.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, хөтөлбөрийн жишиг нэгжийн өртгийн тооцоог гаргаж ХНХЯ-аар хянуулахаар илгээсэн. Энэхүү санал болгож буй өөрчлөлт нь ҮДСТ-н шилжихэд хувь нэмэр оруулж, хөтөлбөрийн үр шимийг үйлчилгээ, байршлаар нь шинжилгээ хийхэд явцыг хялбарчлах төлөвтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний сайжруулсан загварыг 3 аймагт туршиж байна. Дээрх судалгааны үр дүнд 3 аймгийн бодит дата мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-д уялдуулсан үр дүнд суурилсан төсвийн төслийг боловсруулж ХНХЯ-нд загвар болгон

¹⁰ НҮБХХ-н ТХЗ-ын санхүүжилт төслийн хүрээнд хийгдсэн Зам, Тээврийн Салбарын шинжилгээ, 2022

хүргүүлэв. Санал болгосон шалгуур үзүүлэлтүүдийг ХНХЯ дэмжсэн боловч маягтуудыг 2023 оноос ашиглаж эхэлнэ.

А.3.2. Салбарын хөтөлбөр боловсруулалтад тэргүүлэх чиглэлийг харгалзах: Энэ нь салбар доторх ба салбар хоорондын бодлогын уялдааг хангах зорилгоор тэргүүлэх чиглэлийг харгалзах, салбарт төсөл сонгон шалгаруулах үйл явцыг уялдуулах зорилготой. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Төслийн хүрээнд туршилтын яамд төсвийн төслөө ҮДСТ-д уялдуулах зорилгоор зөвхөн салбар доторх тэргүүлэх чиглэлүүдийг анхаарч ажилласан. ЭЗХЯ нь салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах үүрэгтэйгээр 2022 оны эхээр байгуулагдсан ба дунд хугацааны буюу 10 жилийн хугацаатай хөгжлийн бодлого болох Хөгжлийн Зорилтот Хөтөлбөрүүдийг (ХЗХ) боловсруулалтыг манлайлж ажиллах үүрэг хүлээсэн. Төсөл одоогоор ЭЗХЯ-ны Улсын Хөгжлийн Жилийн Төлөвлөгөө боловсруулах удирдамж боловсруулах ажилд техникийн дэмжлэг үзүүлж байна. Төсөл нь салбар хоорондын үр дүнд суурилсан зохицуулалтын талаар ЭЗХЯ -тай 2023 онд хамтран ажиллахаар төлөвлөж байна.

А.3.3. Бодлогын өртөг тооцооллыг сайжруулах: Дээд түвшний төсвийн шийдвэр гаргалтад ашиглагдах гол мэдээллүүд нь бодлогын өртөг тооцоолол болон (А.3.2)-т туссан салбарын хөтөлбөр боловсруулалтад тэргүүлэх чиглэлийг харгалзах ажлаас гарна. Өртөг тооцооллын ажлыг НҮБХХ ба АХБ-ны дэмжлэгтэйгээр Сангийн яам ба Эрүүл мэндийн яам хамтран эрүүл мэндийн салбарт хийж гүйцэтгэсэн.

МБС-ын өртөг тооцох аргачлал боловсруулан 37 МСҮТ-ийн 122 сургалтын хөтөлбөрт туршиж МБС санхүүжилтийн механизмыг шинэчлэхэд суурь мэдээлэл болгон БШУЯ-д хүлээлгэн өгсөн. Өртгийг - нэг оюутанд ноогдох өртөг мөн - нэг хөтөлбөрт ноогдох өртөг гэсэн хоёр хэлбэрээр тооцсон. БШУЯ-ны 2023 оны төсвийн төслийг боловсруулахад гурван Политехник коллеж ҮДСТ-ийн арга зүйгээр боловсруулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайд МБС-ын салбарыг үр дүнд суурилсан санхүүжилтэд¹¹ шилжүүлнэ гэж олон нийтэд мэдээлсэн ч МБС-ын санхүүжилтэд ашиглах өртөг тооцооллын арга зүйг батлах тухай шийдвэр гараагүй байна.

Дээр А.3.1. дурдсанчлан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өртөг тооцох ажил үргэлжилж байна. Гэвч 2 туршилтын болон бусад салбарт өртөг тооцох ажил хараах эхлээгүй байна. 2023 оны Төслийн жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд өртөг тооцох ажлын хамрах хүрээг ЭЗХЯ, СЯ болон бусад холбогдох яамдтай хийх зөвшилцөлд суурилан хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн татаасны судалгаа хийгдэж байна. Уг судалгааны хүрээ хэт өргөнтэй холбоотой, төсөлд уг судалгааг хийж гүйцэтгэхэд тодорхой хүндрэл учирсан. Судалгааны үр дүнгийн төслийг 2022 оны эцэс гэхэд ХХААХҮЯ-д танилцуулах төлөвтэй байна.

Гарч буй хүндрэлүүд: Төсвийн шийдвэрүүд өмнөх оны гүйцэтгэл, төсвийн санхүүжилтийн үр өгөөжтэй байдлыг харгалзахгүй байгаа учир салбарын хөтөлбөрүүдийн өртөг тооцох хэрэгцээ маш

¹¹ <www.mnb.mn/i/275191/>.

бага байна. Мөн салбарын өртгийн тооцоолол хийх аргагүйгээр мэргэшсэн дотоодын зөвлөхүүд цөөн байна. Тиймээс 2023-2024 онд хүний нөөцөө чадавхжуулах хэрэгцээ үүссэн.

А.4 ТХЗ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХАД СЯ БА САЛБАРЫН ЯАМДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	2022 оны бодит хэрэгжилт
А.4.1 Стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ	А.4.1.1. Стратегийн зөвлөлдөх хороо (СЗХ)-ны уулзалтууд зохион байгуулж зөвлөмж гаргах	0	Стратегийн зөвлөмж, Шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулсан, 1 хурал зохион байгуулсан	Хугацаандаа хэрэгжиж байгаа. ҮДСТ-н зөвлөхүүд ДХЗХ, ҮДСТ -г алхам алхмаар хэрэгжүүлэхэд дэмжлэг болох удирдамж боловсруулж байна
А.4.2. Бүсийн сургалт, танилцах аялал зохион байгуулна	А.4.2.1. ДХЗХ-ний асуудлаар чадавх бэхжүүлэх, мэдлэг мэдээлэл солилцох	0	танилцах аялал 1 удаа	2023 онд хэрэгжинэ
А.4.3 Ажлын байранд чадавх бэхжүүлэх сургалт явуулна	А.4.3.1. ҮДСТ-ийн төлөвлөлтийн талаар СЯ, салбарын яамдын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах	0	4	Бүрэн хэрэгжсэн. Улс даяар, 21 аймаг УБ-хотын захиргааг хамруулсан ҮДСТТ сургалт зохион байгуулсан.

А.4.3. Ажлын байран дахь чадавх бэхжүүлэх сургалт: Ажлын байран дахь чадавх бэхжүүлэх сургалт нь ДХЗХ, ДХТХ, ДХГХ-ний талаар нэгдсэн ойлголтыг нэмэгдүүлэх, түүнийг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлттэй уялдуулж засгийн газрын болон нийгмийн оролцогч талуудад ойлгуулах зорилготой. Энэ сургалт нь мөн Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын тогтвортой байдлыг хангах, цаашлаад ТСУ-н ерөнхий шинэчлэлийг дэмжих зорилготой.

“Үр дүнд суурилсан хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт” сэдвийн хүрээнд цуврал сургалт зохион байгуулж СЯ, ХХААХҮЯ, ХНХЯ, ЭМЯ, БОАЖЯ-ын төсөв санхүүгийн хэлтсийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Мөн холбогдох яамдын 293 гаруй албан хаагчид (139 эрэгтэй 154 эмэгтэй) уг сургалтад хамрагдсан (СЯ-аас 57, ХХААХҮЯ-аас 69, ХНХЯ-аас 40, 21 аймгийн эрүүл мэндийн газраас 53, БОАЖЯ-аас 74). Сургалтаар ҮДСНУ-н ерөнхий ойлголт, зарчим, бүрэлдэхүүн хэсгүүд, үндэсний болон ТЕЗ-ын түвшинд хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой, практик хосолсон агуулгыг түгээсэн. ХЗХ-ийн төсөл, түүний шалгуур үзүүлэлт, төсөв, үр дүнд суурилсан нэгдсэн

удирдлагын тогтолцоонд төрийн албан хаагчийн оруулах үүрэг зэрэг ойлголтыг өгсөн нь оролцогчид ба хамтрагч талуудын хооронд ҮДСНУ ба одоо хэрэглэгдэж буй төлөвлөлт, төсөвлөлтийн аргачлалын ялгааг олж харж, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг бүрдүүлсэн. Уг сургалт нь зөвхөн ҮДСТ-ын талаар ойлголт олгохоор хязгаарлагдаагүй ба төрийн албан хаагчдыг 2023 онд үр дүнд суурилсан төсвийн төсөл боловсруулахад бэлтгэхэд чиглэсэн.

Яам тус бүрд чиглэсэн хэд хэдэн сургалтын дараа ТСУ/ҮДСТ-н шинэчлэл хийхэд шаардагдах үр чадвар, манлайллыг бэхжүүлэх зорилгоор олон талын оролцоот семинар зохион байгуулсан. Семинар нь “Монгол улсад үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэхэд тулгарч буй асуудлууд, цаашдын арга зам” сэдэвтэйгээр олон улсын төлөвлөлт, төсөвлөлтийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр 2022 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан. Олон талын оролцоотой уг семинарт ЭЗХЯ, СЯ, УАГ, ЗГХЭГ, ХХААХҮЯ, БОАЯЖ, ХНХЯ-ын гол төлөөлөгчид мөн дотоодын зөвлөхүүдийн баг оролцсон. Семинарын үеэр ХЗХ-ын үр дүнг ҮДСТ-тэй уялдуулах, Алсын хараа 2050, ХЗХ-ийг хэрэгжүүлэхэд төрийн нэгдмэл бодлого, зохицуулалтын арга барилыг ашиглах нь зүйтэй гэсэн ерөнхий зөвшилцөлд хүрсэн. Оролцогчид бусад орны тэргүүн түршлага, бодлогын хийгээд техникийн дэмжлэгтэйгээр уг аргачлалыг алхам алхмаар, үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг дэмжихэд бэлэн байгаа бөгөөд бүх түвшинд чадавхыг бэхжүүлэх нь чухал болохыг илэрхийллээ.

2022 оны 7-8-р сард ХНХЯ, ХХААХҮЯ-г хамруулсан төсөв боловсруулах хоёр өдрийн тусгайлсан сургалт зохион байгуулагдлаа. СЯ-аас баталсан ТХЗ-той уялдсан Үр дүнд суурилсан төсвийн саналын маягыг хоёр яамны бодлого, санхүүгийн мэргэжилтнүүд ҮДСНУ-ын аргачлалыг ашиглан бөглөж, бодлогын үр дүнг ТЕЗ болон Хөтөлбөрийн ХҮДХ-д хөрвүүллээ.

“Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт” сургалтыг улс даяар зохион байгуулж 21 аймаг, сумд, нийслэл, дүүргийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, санхүү, тайлан, хяналт шинжилгээ хариуцсан нийт 1500 гаруй албан хаагчид хамрагдлаа (хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрийн салбарын). Сургалтыг СЯ, ЭЗХЯ, Удирдлагын Академи хамтран зохион байгуулж үндэсний болон салбарын түвшинд тулгамдаж байгаа тухайлсан сэдвүүдэд чиглэсэн хэлэлцүүлэг хийж, багийн ажлын хүрээнд салбарын үр дүнг орон нутгийн түвшинд хөрвүүллээ. Сургалтын үеэр үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн маягыг орон нутгийн түвшинд хэрэглэж болох эсэхийг туршиж үзлээ.

Гарч буй хүндрэлүүд: Туршилтын яамдын төлөөлөгчид төсөв өргөн барих, яамны удирдлага өөрчлөгдсөн мөн бусад чухал ажлууд гарсантай холбоотойгоор орон нутгийн сургалтад хамрагдаагүй. Орон нутгийн удирдлагууд нээлтийн үг хэлж, сургалтын үйл ажиллагааг дэмжсэн хэдий ч сургалтад оролцох боломжгүй байлаа. Тиймээс 2023 онд чадавхжуулах сургалтад удирдах түвшний удирдлагуудын ажлын хуваарьт нь тааруулж зохион байгуулахаар төлөвлөж байна.

ХОЁРДУГААР БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсвийн хяналт, ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх гурван үндсэн чиглэлийг тусгасан. Үүнд:

- В.1 Төсвийн хяналтад УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- В.2 Төсвийн шинжилгээ, гүйцэтгэлд хяналт тавихад ИНБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- В.3 Гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлж ил тод байдлыг хангах

Төслийн зорилт 2-4-т оруулсан хувь нэмэр:

Зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	Хэрэгжилтийн үр дүн
Зорилт 2: ҮДСТ, Бодлого, төсвийн уялдааг хангахад УИХ-аас тавих хяналтыг сайжруулах	Төсвийн санал, салбарын зардлын шинжилгээнд суурилан, Үр дүнд суурилсан төсөв, зардлын үр дүнтэй байдлын талаар хийсэн төсвийн сонсголын тоо (салбар/яам)	0	2	2023 онд хэрэгжинэ. Төсвийн байнгын хороотой тохиролцсоны дагуу 2023 онд Төсвийн сонсгол хийх ажилд дэмжлэг үзүүлнэ.
Төслийн зорилго 3: ИНБ төсөвт хяналт тавих	Төсвийн хэрэгжилтийн байдалд нь ИНБ-аас хяналт-шинжилгээ хийсэн салбар/яамны тоо (хувь) – үр дүн суурилсан төсөвлөлт, “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг тусгасан байх, нийтэд мэдээлсэн байх	0	2	Хугацаандаа хэрэгжиж байгаа. ҮДСТ ашиглан 10 ИНБ төсвийн хяналт хийлээ, үр дүнгийн тайлан 2022 оны 12-р сарын сүүлээр бэлтгэгдэнэ.
Төслийн зорилго 4: ТХЗ-н тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн аудит хийх	ТХЗ-ын тэргүүлэх ач холбогдолтой салбар, хөтөлбөрт хийсэн гүйцэтгэлийн аудитын тоо	0	1	Бүрэн хэрэгжсэн. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт гүйцэтгэлийн аудит хийж ба аудитын зүгээс УИХ, холбогдох байгууллагуудад танилцуулсан.

В.1. ТӨСВИЙН ХЯНАЛТАД УИХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Энэ зорилтын хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа хуваарийн дагуу хийгдээгүй ч 2022 оны 8-р сараас хойш бодлогын нөлөөллийн ажил эрчимжсэн. 2022 оны 9-р сард Төсвийн байнгын хорооноос зохион байгуулсан Төсвийн шинэчлэл сэдэвт хэлэлцүүлэгт төсөл оролцсон. Мөн 2022 оны 10-р сард зохион байгуулагдсан 2023 оны төсвийн төсөлд санал авах олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, саналаа цахимаар хүргүүлсэн. Мөн 2022 оны 9-р сард УИХ- дэргэдэх Нийгмийн бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан “Халамжаас Хөдөлмөрт” хэлэлцүүлэгт төслийн судалгааны үр дүн, зөвлөмжүүдийг танилцуулсан.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Гарааны тоо	Хүрэх зорилт 2022	2022 оны бодит хэрэгжилт
В.1.1 Бодлогын шинжилгээ, хяналт	В.1.1.1. Бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх	0	2 салбар	2023 онд хэрэгжинэ.
В.1.2 Үр дүнд суурилсан төсвийг нягталж, хяналт шинжилгээ хийнэ	В.1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд зарцуулж буй төсвийн хэрэгжилт, хяналт шинжилгээ, цаашид төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцааг сурталчлах талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах,	0	1	2023 онд хэрэгжинэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг 2022 онд хийсэн. УИХ-н холбогдох чиг үүргийн газруудтай зөвлөлдөх уулзалтуудыг хийх төлөвлөгөөтэй байна.
	В.1.2.2. Төсвийн зарлагад үр өгөөжийн үнэлгээ хийх (Жилийн төсөв, Хавсралт 2)	0	1	2023 онд хэрэгжинэ. Гүйцэтгэлд суурилсан тайлагналт үйл явц үр дүн, шалгуур үзүүлэлт, өртгийн мэдээллийг харуулдаг болсны дараа 2023 онд үнэлгээ хийхээр төлөвлөж байна.
	В.1.2.3. Салбар, хөтөлбөрийн зарлагын үнэлгээг холбогдох хороод хэлэлцэх	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 2022 оны 10 сард төсөл хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын шинжилгээг танилцуулах төлөвлөгөөтэй байна.
	В.1.2.4. Зарлагын үр нөлөөний талаар төсвийн сонсгол хийх	0	1	2023 онд хэрэгжинэ.
	В.1.2.5. Зарлагын чиг хандлагын дүн шинжилгээний дүгнэлт бүхий товч мэдээллийг УИХ-ын гишүүдэд тогтмол хүргүүлж байх	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. (Боловсролын салбарын зардлын талаарх тайлбарыг хүргүүлсэн)
В.1.3. Бодлого, төсвийн үр дүнтэй уялдааг	В.1.3.1. ДХТТ, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн уялдааг хангах чиглэлээр судалгаа хийж УИХ, ЗГ-г танилцуулах	0	1	Хэрэгжсэн. Үр дүнд суурилсан төлөвлөлтийг ҮДСТ-тэй уялдуулах аргазүйг боловсруулан гаргасан. 2023

хангахад УИХ-аас хяналт тавина				онд холбогдох сургалтыг төлөвлөж байна.
	В.1.3.2. ДХТТ, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн үялдааг хангах аргачлалын гарын авлага боловсруулж УИХ, ЗГ-аар батлуулах	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. ҮДСТТ-н гарын авлага боловсруулагдаж байна. 2023 оны эхээр дуусгах зорилготой байна.
	В.1.3.3. Санхүүгийн болон үр дүнгийн гүйцэтгэлийн мэдээллийг ашиглан, төсвийн гүйцэтгэлд гарч буй ялгааг судлах	0	1	2023 онд судалгаа хийгдэнэ.
В.1.4 Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг сайжруулна	В.1.4.1. Жилийн төсвийн төслийг нягтлан хянах гарын авлага бэлтгэх (шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд зориулсан аргачлалын удирдамж)	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Жилийн төсвийн төслийг нягтлан хянах гарын авлага бэлтгэх ажлыг УАГ-д зориулан гаргасан. Гарын авлагыг түгээх ажлуудыг мөн төлөвлөж байна.
	В.1.4.2. Төсөвт хяналт тавих, төсвийн зарлагын үр нөлөөг сайжруулах асуудлаар мэргэжил нэгтгүүдийн мэдээлэл солилцох арга хэмжээг дэмжих	0	1	2023 онд хэрэгжинэ. Туршлага судлах аяллыг төсвийн шинэчлэл хийж байгаа ижил төстэй нөхцөлтэй орныг сонгон хийхээр төлөвлөж байна.
	В.1.4.3. Бодлогын хэрэгжилтэд УИХ-аас тавих хяналтын талаарх сургалтыг ҮДСТ-тэй үялдуулан зохион байгуулах	0	1	2023 онд хэрэгжинэ. 2022 онд хийгдсэн судалгаа, үнэлгээний материалыг ашиглан ирэх онд сургалт зохион байгуулна.

В.1.1. Үр дүнд суурилсан бодлогын шинжилгээ ба хяналт: 2022 оны 10-р сард УИХ-н дэргэдэх Нийгмийн бодлогын байнгын хорооноос Үндэсний Аудитын Газар (УАГ)-ын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийнхээ дагуу гүйцэтгэсэн “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүн, хэрэгжилт” сэдэвт аудитын үр дүнг хэлэлцсэн. Төслийн зүгээс уг үйл ажиллагаанд шууд бус үүрэг гүйцэтгэсэн буюу ТХЗ хэрэгжилтийн аудитын аргазүйг ашиглах техникийн дэмжлэг үзүүлснийг В.3.1. хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

В.1.2. Үр дүнд суурилсан төсвийн хяналт, шинжилгээ: 2022 оноос эхлэн туршилтын хоёр салбар нь ҮДСТ-ийг сайжруулж байгаатай холбоотой, 2023 оноос УИХ төсвийн хяналт хийхэд шаардлагатай аргачлал боловсруулагдаж, хэрэглэгдэнэ. Үүнд УИХ-ын гишүүдэд зориулсан зарлагын дүн шинжилгээ, сүүлийн 3 жил төсвийн шинэчлэлийн чиглэлээр хийгдсэн ажлын тойм боловсруулах зэрэг багтана.

В.1.3. Бодлого, төсвийн уялдааг хангахад УИХ-аас тавих хяналт: Үр дүнд суурилсан төлөвлөлт болон үр дүнд суурилсан төсөвлөлтийг холбох аргазүйн бичиг баримтыг төслийн олон улсын зөвлөхүүд 2022 оны 3-р сард боловсруулсан. Энэхүү аргазүйг 2023 онд УИХ-ын байнгын хороодод танилцуулж, сургалтад хамруулах юм. ДХТТ, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн уялдааг хангах аргачлалын гарын авлага боловсруулагдаж байна. 2023 оны эхээр дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Уг зорилттой холбоотой үйл ажиллагаа 2023 онд хийгдэнэ. Төсөл нь хоёр үндсэн үйл ажиллагаагаар бодлого-төсвийн уялдааг илүү сайн шинжлэхэд УИХ- хороодод дэмжлэг үзүүлнэ i) ДХЗХ ба УИХ, Засгийн газраар батлагдсан урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын уялдааг судлах, ii) санхүүгийн болон хөтөлбөрийн гүйцэтгэлийн мэдээллийг ашиглан төсвийн гүйцэтгэлийн зөрүүг тогтмол хянах

В.1.4. УИХ-ын Төсөвт хяналт тавих УИХ-ын чадавхыг сайжруулах: Төсвийн төслийг хянах аргазүйн зааврыг олон улсын болон дотоодын зөвлөхүүдийн тусламжтайгаар УАГ-т зориулан боловсруулан гаргасан. Энэ аргазүйн зааврыг шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд хүргэх зорилготой байна. Төсөл эхэлснээс хойш УИХ-н хороодод сургалт, семинар зохион байгуулаагүй. Дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн гүйцэтгэх үүрэг ба ҮДСТ талаар анхны сургалтыг 2022 оны 12-р сард зохион байгуулахаар төлөвлөсөн. 2023 онд Төсвийн байнгын хороотой хамтран хэд хэдэн сургалтууд зохион байгуулахаар ажиллаж байна.

В.2 ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХАД ИНБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022	2022 оны хэрэгжилт
В.2.1 Салбарын бодлогын шинжилгээг хийнэ	В.2.1.1. Бодлогын үр нөлөөний талаар хамтарсан судалгаа хийх	0	1 бодлогын баримт бичиг	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 2 ИНБ бодлогын үр нөлөөний судалгааг гүйцэтгэж байна
В.2.2 Төсөвт хяналт шинжилгээ хийх ИНБ-ын чадавхыг сайжруулна	В.2.2.1. СЯ-ИНБ-ын хамтын ажиллагаанд баримтлах баримт бичиг боловсруулах	0	1 арга зүйн баримт бичиг	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Хамтын ажиллагааны санамж бичиг боловсруулагдаж СЯ-д танилцуулсан ба эхний хэлэлцүүлгийг хийсэн
	В.2.2.1. ҮДСТ заримыг ашиглаж төсвийн хяналтыг тогтмол хийх		1 төсвийн хяналтын тайлан	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 10 ИНБ төсвийн хяналтыг хийж байна. 2022 оны 12-р сарын сүүлээр тайлангаа тавина.

	В.2.2.3. ҮДСТ заримыг ашиглаж төсвийн мониторингийн үр дүнгийн талаар мэдээлэл хийх		1 мэдээллийн ажил	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 3 видео хийж олон нийтэд түгээхээр ажиллаж байна
В.2.3 Төсөвт хяналт-шинжилгээ хийх, хянах чиглэлээр ИНБ, хэвлэл мэдээллийн чадавхыг сайжруулна	В.2.4.1. ИНБ-д зориулан ҮДСТ, төсөвт шинжилгээ хийх арга зүй аргачлал, судалгааг бодлого, төсөвтэй холбох зэрэг асуудлаар сургалт зохион байгуулах	0	1	Хэрэгжсэн. ИНБ төсөвт хяналт тавих чадавхыг дээшлүүлэх 4 сургалт зохион байгуулсан
	В.2.4.2. УИХ-н сэтгүүлчид хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд зарцуулсан төсөвт хяналт тавих сургалт, ҮДСТ ба ТХЗ-ын төсөвлөлт	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 2022 оны 12-р сард зохион байгуулахаар ажиллаж байна

В.2.1 Салбарын бодлогын шинжилгээ ба ИНБ-үүд төсөвт хяналт хийх

ИНБ-үүдэд шаардлагатай чадавхын хэрэгцээний үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр хамтран ажиллаж буй ихэнх ИНБ-үүд төсвийн хяналтын талаар суурь мэдлэгтэйг тогтоосон. Тус үнэлгээг ИНБ-ын хэрэгцээнд тохирсон сургалтын төлөвлөгөөг боловсруулахаар гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний дагуу 2022 онд 3 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Үүнд: i) үр дүнд суурилсан хяналтын тайлан бичих, хэвлэлийн контент бэлтгэх тухай сургалтад 14 ИНБ-ын 40 оролцогч хамрагдсан ii) байгаль орчны салбарт төсвийн хяналт хийж буй бодит туршлагатай танилцах туршлага солилцох аялал зохион байгуулагдсан iii) Нөлөөллийн ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх сургалт зохион байгуулагдсан.

Арван ИНБ төсөвт хяналт тавих чиглэлээр чадавхаа бэхжүүлээ. ИНБ-ыг чадавхжуулах, төсөвт хяналт тавих оролцоог хангах зорилгоор 2022 оны 3-р сард жижиг мөнгөн тэтгэлэг зарласан. Монгол улсын их сургууль (МУИС)-ын Хүн амын сургалт, судалгааны төв (ХАССТ)-тэй хамтарч “Төсвийн Хяналт” сургалтыг 2022 оны 4-р сарын 15-нд зохион байгуулсан бөгөөд нийт 50 ИНБ-ын төлөөллүүд оролцож төсвийн талаар суурь ухагдахуун, мэдлэг мэдээлэл авлаа.

Тэтгэлэгт уралдаанд 17 ИНБ материал ирүүлснээс 10 ИНБ-ыг шалгаруулсан, үүнээс 3 нь орон нутгаас оролцсон. ИНБ-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр харуулав.

Төсвийн хяналтын жижиг төсөл авсан ИНБ-уудын жагсаалт

#	ИНБ-ын нэрс	Төслийн зорилго
1	Монголын эдийн засгийн шинжилгээ судалгааны төв (МЭЗШСТ)	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн сүүлийн 3 жилд зарцуулсан төсвийн мэдээлэлд шинжилгээ хийх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо, үр чадвар олгох сургалтад хамрагдагсад, болон бусад шалгуураар шинжилгээ хийх
2	Орчин үеийн шинжлэх ухаан төв (ТББ)	Шинжлэх ухааны салбарт зарцуулж буй улсын төсвийн үр өгөөжтэй байдлыг шинжлэн бодлого, зөвлөмж боловсруулж холбогдох газруудад танилцуулах
3	Хил хязгааргүй алхам (ТББ)	Хэрэглээний усны төлбөр нь улсын болон орон нутгийн төсвийн орлогын ихээхэн хувийг бүрдүүлдэг ба холбогдох орлого зарлагад шинжилгээ хийж, холбогдох журам, бодлого болон ТХЗ-ын 6, 13, 15-р зорилго хэрэгжилтийг дэмжих
4	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн Дархан-Уул салбар	Сүүлийн 3-5 жилд Дархан-Уул аймагт хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогод дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг дэмжих зөвлөмж боловсруулах, Аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох
5	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим Завхан салбар	Завхан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, бусад холбогдох хуульд үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ хийх.
6	Эрин зууны хөтөч	Орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хөтөлбөрийн хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдлыг үнэлэх Орон нутаг, салбарын бодлого, хөтөлбөрийг хөгжүүлэх боломжоор хангах
7	Олон нийтийн харилцааны стратеги судалгааны төв	Олон нийтэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг нэгжүүдийн төсвийн үйл явцыг судлах, гэр бүлийн нэг гишүүнд ноогдох зардлын хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох байгууллагуудыг үнэлж зөвлөмж өгөх
8	Монголын тандан судлаачдын холбоо	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн зардлын үр өгөөж, үр шимийг ажилгүйдлийн хувь хэмжээнд харьцуулан тодорхойлох Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн хөтөлбөрийн зорилтот бүлэгт чиглэсэн зарцуулалтын шинжилгээ
9	Сайнхүү ивээл сан (СИС)	Боловсролын салбар дахь ҮДСТ зарчмыг хэрэглэж байгаа хөтөлбөрүүдийн төсвийн хэрэгжилтийг хянах, үндэсний түвшинд бодлогын үр нөлөөг үнэлсэн тайлан боловсруулах
10	Үнэн Хатамж нийгэмлэг	Төрийн байгууллагуудтай хамтран төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллах.

ИНБ-уудын гүйцэтгэсэн төсвийн хяналтын үр дүн 2022 оны 12-р сарын сүүлээр эцэслэгдэнэ. Төсвийн хяналтад ИНБ-ын оруулсан хувь нэмрийг олон нийтэд сурталчлах зорилгоор олж авсан сургамжуудад үндэслэн видео контент боловсруулна.

[СЯ ба ИНБ-ын хамтран ажиллах санамж бичгийн төслийг](#) боловсруулж, СЯ-д танилцуулсан.

В.3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫГ БЭХЖҮҮЛЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	2022 оны хэрэгжилт
В.3.1 ТХЗ-ын тэргүүлэх хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийх	<p>В.3.1.1. Хөтөлбөрт суурилсан төлөвлөгөөг төсвийн зардлын зүйл ангиар гаргасан гүйцэтгэлийн мэдээлэлтэй харьцуулж зураглан, холбон хянах чадавхыг ажлын байранд бүрдүүлж, гүйцэтгэлийн аудит хийх</p> <p>В.3.1.2.ТХҮБ2030-ын хүрээнд ҮАГ-ын жилийн тайлангийн ТХЗ-ын тэргүүлэх чиглэлтэй холбоотой хэсгийг эргэн нягтлах</p>	0	Хөдөлмөр эрхлэлтийн салбарт 1 аудит	<p>Бүрэн хэрэгжсэн. Нийт 6 гүйцэтгэлийн аудитын техникийн удирдамж боловсруулж ҮАГ-т хүргүүлсэн</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн салбарын аудит хийгдсэн</p> <p>2023 оны төсвийн төсөлд санал өгөх аудитад дэмжлэг үзүүлсэн</p> <p>Эрүүл мэндийн салбарын ҮДСТТ гүйцэтгэлийн аудитад кейс судалгаа хийсэн</p>
В. 3.2 Иргэний танхим/ (нийгмийн) аудит	В.3.2.1. Төсвийн болон аудитын тайланг ҮДСТ-т үндэслэсэн байдлаар танилцуулах	0	1 Иргэний танхимын аудит	<p>Хугацаандаа хэрэгжиж байгаа. Нийгмийн аудитад зориулсан удирдамж боловсруулж ҮАГ-т хүргүүлсэн. ҮАГ-ын холбогдох газруудаас 95 албан хаагчид хамрагдсан.</p> <p>ҮАГ-ын 2023 оны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг хангахаар төлөвлөж байна</p>
В. 3.3 Гүйцэтгэлийн аудит хийх чадавхыг бэхжүүлэх	В. 3.3.2 Гүйцэтгэлийн аудитыг сайжруулах сургалт	0	1	Бүрэн хэрэгжсэн. 6 сургалт зохион байгуулсан

В.3.1 ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит хийх

Гүйцэтгэлийн аудиттай холбоотой 4 төрлийн техникийн удирдамжийг УАГ-н хэрэгцээнд боловсруулсан. Үүнд: i) Төрийн бодлого болон төсөв, ii) ТХЗ-той уялдсан төсөвлөлт, iii) улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, iv) 2023 оны төсвийн төсөлд санал өгөх аудит. Доор дурдсанчлан эдгээр ажлууд нь гүйцэтгэлийн аудитын чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

- ✓ Төрийн бодлогын үнэлгээ болон төсвийн хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийх техникийн удирдамж нь энэ чиглэлээр Монгол Улсад хийгдсэн анхны удирдамж юм. Тус удирдамж нь АДБОУБ-с баталсан АДБОУС-уудад нийцүүлэн боловсруулагдсанаас гадна дэвшилтэт АДБ-уудын тэргүүн туршлагыг аудитын үе шат бүрийн онцлогт тохируулан нийтэлснээрээ онцлог юм. Гүйцэтгэлийн аудитаас ялгаатай нь төрийн бодлогын үнэлгээ нь бодлогын урт хугацааны үр нөлөөг авч үздэгээрээ үнэлгээний шалгуур үзүүлэлт асуултуудыг хамруулдаг, илүү өргөн ойлголтыг хамруулдаг. Тус удирдамжийг 2022 онд УАГ гүйцэтгэсэн ‘Төрөөс хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн’ сэдэвт аудитад авч ашигласан.
- ✓ ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөд гүйцэтгэлийн аудит хийх арга зүйн удирдамжийг боловсруулан УАГ-т хүргүүлсэн. Монгол Улсын жилийн төсвийн төсөлд санал өгөх аудитад ТХЗ-той уялдсан төсөвлөлтөд (зүйл заалтын төсвөөс хөтөлбөрт суурилсан төсөв, хөтөлбөрт суурилсан төсвөөс дунд хугацааны төсвийн хүрээн дэх гүйцэтгэлд суурилсан төсөв) гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглах боломжтой. Мөн гүйцэтгэлийн аудитын чадавхыг бэхжүүлэх замын зургийг боловсруулан санал болгосон. Төсвийн захирагчдын ҮДСТ-ийн гүйцэтгэлийн тайлагналд ашиглах гүйцэтгэлийн аудитын маягуудыг боловсруулсан. Төсвийн захирагчид ҮДСТ-ийн гүйцэтгэлээ тайлагнаж эхэлмэгц УАГ-с хийх аудитдаа тус маягуудыг ашиглах боломжтой болох юм.
- ✓ Төслийн зүгээс 2023 оны төсвийн төсөлд санал өгөх аудитад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтийн асуултыг анхааран дэмжлэг үзүүлсэн. Ингэхдээ дөрвөн яамны төсвийн төслийг нягталсан. Үүнд: БОАЖЯ, ХНХЯ, Зам тээврийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг хамруулсан ба зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжид:
 - УАГ-т ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц, хоцрогдлыг төсвийн төсөлд санал өгөх аудитаар дамжуулан цааш цаашдаа илэрхийлж байх
 - Засгийн газар нь урт, дунд хугацааны бодлого төлөвлөлтийг сайжруулах, ДХЗХ-рүү шилжих, ингэхдээ хэвтээ болон босоо түвшний уялдааг хангах, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ДХТХ-г ашиглан шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох
 - СЯ нь төсвийн төсөл санал боловсруулахад зориулан, ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөрт хамаарах төсөв болон гарц ба үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын уялдааг хангах талаар нийтлэг болон тусгайлсан арга зүйгээр хангах, мөн улсын төсвийн нэгтгэл хийхдээ уялдаа болон мэдээллийн бүрэн бүтэн байдлыг нягтлах
 - ТЕЗ нь төсвийн саналаа ТХЗ-той уялдуулан боловсруулахдаа салбарын болон орон нутгийн онцлогийг харгалзан, харьцуулсан үзүүлэлтүүдийг ашиглах

Гүйцэтгэлийн аудитын чанарын хяналт хийхэд анхаарах зөвлөмжийг 2021 онд 4 гүйцэтгэлийн аудитад өгсөн техникийн зөвлөмжид тулгуурлан боловсруулж УАГ-т хүрүүлсэн үүнд: i) Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт ii) хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, iii) Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө iv) эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө. Уг зөвлөмж нь УАГ-н аудитын үйл явцыг бэхжүүлэхэд зориулагдсан.

“АДБ-н стратеги төлөвлөлт болон бүтэц” техникийн баримт бичгийг 8 улсын туршлага дээр үндэслэн боловсруулсан. Уг зөвлөмж нь УАГ-ын өөрийн стратеги төлөвлөлтийн аргачлалаа сайжруулах, аудитын төрлөөр стратегийн зорилго, зорилтоо тодорхойлох, байгууллагын бүтцийг байгууллагын стратегитай уялдуулах, УИХ-с ирдэг асуултуудад хариу өгөхөд дэмжлэг үзүүлэх баримт бичиг юм.

Талбар дээрх, кейс суурьтай техникийн дэмжлэгийг эрүүл мэнд болон хөдөлмөрийн хоёр салбарын гүйцэтгэлийн аудитад үзүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт хийгдсэн гүйцэтгэлийн аудитад АДБОУС, ТХЗ-н Аудитын загвар, Монгол Улсын төрийн аудитын стандарт, АДБ-уудын сайн туршлага дээр үндэслэж гүйцэтгэсэн. Аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шат бүрд олон улсын болон үндэсний стандарт, аргачлалыг хэрэгжүүлэх чиглэлээр цаг тухай бүрд дэмжлэг үзүүлэн ажилласан. Аудитын гол зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн үр өгөөж, үр нөлөөг үнэлэхэд оршсон. Аудитын гол илрүүлэлтийг 2022 оны 10 дугаар сард УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулсан. Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг үндэсний зөвлөлд 5, Боловсрол шинжлэх ухааны яамд 1, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс бусад холбогдох байгууллагуудад 6 зөвлөмжүүдийг тус тус хүргүүлсэн.

Эрүүл мэндийн салбар хийгдсэн үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн аудит дээр кейс ажилласан. Ингэхдээ олон улсын стандартын зүйл заалтуудын хэрэглээ, улсын секторт ҮДСТ-ийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарт үр дүнд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх зэрэгт шинжилгээ хийсэн. Уг судалгаа төсвийн гүйцэтгэлийн аудитыг илүү сайжруулах зөвлөмжүүдийг гаргасан.

В.3.2 Иргэний танхим/ нийгмийн аудит

Иргэний танхим/ нийгмийн аудитын удирдамжийн төслийг боловсруулж, УАГ-ын саналыг тусгахаар хүргүүлсэн. Удирдамжид УАГ нь сайн туршлагаа бусад холбогдох байгууллагууд болох ИНБ болон УИХ-ын хороодтой хуваалцах боломжийг дурдсан. Нийгмийн Аудитын удирдамж нь нийгмийн аудитын үндсэн нэр томъёо, зарчим, зорилго, түүний үр өгөөж, оролцогч талуудын оролцоо зэргийг багтаасан. Удирдамжийн практик хэрэглээг дэмжих зорилгоор нийгмийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, илрүүлэлт болон зөвлөмж боловсруулах зэрэг алхамчилсан зөвлөмж, олон улсын сайн туршлага зэргийг багтаасан.

В.3.3 Гүйцэтгэлийн аудит хийх чадавхыг бэхжүүлэх

Бүх техникийн баримт бичиг, удирдамжид тусгагдсан ухагдахуун болон хэрэгжүүлэх алхмуудыг цуврал сургалт, семинараар дамжуулан хүргэсэн. Зохион байгуулагдсан сургалт, семинарыг доор үзүүлэв.

2021 оны 12-р сард “ТХЗ-той уялдсан гүйцэтгэлийн аудит, өнөөгийн чиг хандлага, сайн туршлагуудыг нутагшуулах арга зам”, “ТХЗ-той уялдсан төсөвлөлт: гүйцэтгэлийн аудиторруудын анхаарах зүйлс, туршлага” сургалтуудад гүйцэтгэлийн аудитын газрын албан хаагчдыг хамруулсан. Нийт 31 мэргэжилтэн хамрагдсанаас 21 эмэгтэй, 10 эрэгтэй аудитор байв. Оролцогчид ТХЗ-той уялдсан гүйцэтгэлийн аудит жишээлбэл цаашид гүйцэтгэлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах аргачлалын талаар мэдлэг мэдээлэл хуримтлуулсан.

2022 оны 2-р сард "Төрийн бодлогын үнэлгээ, бодлогын болон төсвийн хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийх нь" сургалт зохион байгуулагдаж ҮАГ, Нийслэлийн аудитын газар, 21 аймгийн аудитын газраас нийт 165 мэргэжилтнүүд оролцсон ба 74 нь эмэгтэй 91 эрэгтэй аудиторрууд байв. Сургалтаар төрийн бодлогын үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах шинэлэг аргачлал, засгийн газар төсвийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах хамгийн сайн аргачлалуудын талаар мэдлэг мэдээллээр хангахыг зорьсон.

2022 оны 3 дугаар сард ҮАГ, Нийслэлийн аудитын газар, 21 аймгийн аудитын газрын 280 гаруй аудиторруудад "ТХЗ-той уялдсан бодлогын хэрэгжилт, үр дүнд суурилсан төсвийн аудитын практикийг бэхжүүлэх нь" хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр хөгжлийн бодлогын төлөвлөлтийг ТХЗ-той уялдуулах ач холбогдол, ТХЗ-той холбоотой гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлэхэд баримтлах зарчмуудыг онцолсон. Оролцогчид 2021 онд төслөөс үзүүлсэн техникийн туслалцаа, ирэх оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний талаар мэдээлэл авсан.

2022 оны 5-р сард 2 цахим сургалт зохион байгуулсан. Эхний сургалт нь “Үр дүнд суурилсан санхүүжилт: Төсвийн гүйцэтгэлд аудит хийх зарчмын асуудал” сэдэвтэй зохион байгуулагдсан ба улсын секторт үр дүнд суурилсан санхүүжилтийг олгож буй бусад орны жишээ, үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлд аудит хийх олон улсын туршлагыг хуваалцсан. ҮАГ-н 1-4 дүгээр газрууд, Хөгжлийн Бодлого, Төлөвлөлтийн газар, Чанарын баталгаажуулалтын албаны нийт 55 албан хаагчид хамрагдлаа. 2 дахь сургалтаар Нийгмийн Аудитын сэдвээр зохион байгуулагдсан ба нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд нийгмийн аудитын оролцоо, ҮАГ-ын гүйцэтгэх үүргийн талаар хэлэлцсэн. ҮАГ ба 14 аймгийн аудитын газраас нийт 95 албан хаагч хамрагдсан.

2022 оны 6-р сард зохион байгуулагдсан "Чанарын баталгаажуулалт ба хяналт" сэдэвт цахим сургалтад ҮАГ, аймгуудын аудитын газраас 40 (21 эрэгтэй, 19 эмэгтэй) дээд шатны удирдлага болон бусад албан хаагчид оролцсон. Сургалтаар аудитыг чанартай гүйцэтгэхэд тулгарч буй бэрхшээлүүд, чанарын баталгаажуулалт ба хяналтын аргачлалыг сайжруулах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Гарч буй хүндрэлүүд: Дунд хугацааны хөгжлийн бодлого УИХ-аар батлагдахгүй удаж байгаа нь холбогдох судалгааг хийх ажлуудыг мөн хойшлуулж байна. Төслийн зүгээс энэ асуудлыг шийдэхийн тулд 2023 онд хийгдэх судалгаа, шинжилгээг хийх аргачлал, аргагүйг боловсруулан гаргасан.

ГУРАВДУГААР БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ С. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДВАР, БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Төсөл дараах үндсэн дөрвөн чиглэлээр үр дүнд хүрэхийг зорьж байна. Үүнд:

- С.1** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг сайжруулах, харилцан уялдаатай болгох
- С.2** Инновац, гарааны бизнес, бизнес инкубаци, бизнес эрхлэхэд ээлтэй экосистемийг бэхжүүлэх
- С.3** Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх чадавх, үр чадварыг нэмэгдүүлэх
- С.4** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үр дүнтэй сургамж цуглуулах, улмаар бодлогод тусгах зорилгоор туршилтын төслүүд хэрэгжүүлэх

С.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ САЙЖРУУЛАХ, ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ БОЛГОХ

Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Төслийн дэд зорилтууд	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2022)	2022 оны хэрэгжилт
Дэд зорилт С.1.1 Одоо хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн зураглалыг гаргаж, саад бэрхшээлийг тодорхойлох.	С.1.1.4 Үндэсний хөтөлбөрүүдийг хянаж, шинэчлэх	Байхгүй	Шинэчилсэн хөтөлбөрүүд	Хугацаандаа хэрэгжиж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн. 2023 оны ХЭДХ-ийг шинэчилж, ХЭҮЗ-өөр батлуулахаар хүлээгдэж байна.
Дэд зорилт С.1.2 Үндэсний хөтөлбөрүүд болон яамны төсөвт тусгагдсан дэмжих үйлчилгээ.	С.1.2.1 Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжтой салбар\төслүүдийг тодорхойлох	Байхгүй	1 төсөл хэрэгжиж байна	Хугацаандаа хэрэгжиж байна. Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах 4 арга хэмжээг туршилтын 2 байршилд хэрэгжүүлэх, үр дүнг ХЭДХ-т тусгахаар төлөвлөсөн
	С.1.2.3 Зөвлөгөө өгөх дэмжлэгийг орон нутгийн хоршоод, бизнес, зах зээлтэй уялдуулах	Байхгүй	Холбоо тогтоох 1 үйлчилгээ	Хугацаандаа хэрэгжиж байна. Баянчандмань суманд ЗДТГ болон бизнесийн бусад байгууллагуудтай хамтран хоршоодтой холбох туршилтыг эхлүүлсэн
Дэд зорилт С.1.3 Үндэсний хөтөлбөрүүд болон	С.1.3.1 Байгууллагын менежмент болон	0	1 шинэчлэл	Хугацаандаа хэрэгжиж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх

яамны төсөвт бодит тусгалаа олсон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ.	зохицуулалтыг дэмжих үйлчилгээг хянах, шинэчлэх			үйлчилгээг E-Job платформын нэг чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн
--	---	--	--	---

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг сайжруулах чиглэлийн үр дүнд хүрэхийн тулд дараах гурван дэд зорилтыг тодорхойлсон. Үүнд:

C.1.1 Одоо хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн зураглалыг гаргаж, саад бэрхшээлийг тодорхойлох.

C.1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг тодорхойлох.

C.1.3 Дэмжих үйлчилгээг үндэсний хөтөлбөрүүд болон яамны төсөвт тусгуулах.

C.1.1 Одоо хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн зураглалыг гаргаж, саад бэрхшээлийг тодорхойлох. Үндэсний хөтөлбөрүүдийн зураглалыг гаргаж, саад бэрхшээлийг тодорхойлох нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг шинэчлэхэд чиглэсэн суурь ажил байсан тул энэхүү дэд зорилттой холбоотой ихэнх ажлыг 2021 онд хэрэгжүүлсэн. Тайлангийн өмнөх бүлгүүдэд дурдсанчлан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгоход чиглэсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд УАГ-аас хийсэн аудитын тайлангийн гол дүгнэлтүүд нь төслийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаанууд болон бусад байгууллагуудын (зарим нь 2015 онд) хийсэн судалгааны дүгнэлтүүдтэй нийцэж байна. Аудитаас гарсан зарим дүгнэлтүүдийг дурдвал:

- Засгийн газрын богино, дунд болон урт хугацааны хөдөлмөр эрхлэлтийн бодлогын баримт бичгүүдийн үзүүлэлтүүд, зорилтууд өөр хоорондоо уялдаагүй.
- Бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад холбогдох зорилтот бүлгүүдийн төлөөлөл болох талуудын оролцоог бүрэн хангаагүй.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг тооцохдоо өнгөрсөн жилийн гүйцэтгэл, эдийн засаг болон салбарын суурь судалгаа, тооцооны дүн шинжилгээг харгалзан үзээгүй.
- Хөдөлмөр эрхлэлтийн салбарын удирдлагын босоо болон хэвтээ бүтцийн хоорондын зохицуулалт хангалтгүй.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд нь орон нутгийн бодит байдалтай бүрэн уялдаагүй.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн мониторинг, үнэлгээ, тайлагналт хангалтгүй.
- МБС-ын санхүүжилтийн загвар үр нөлөөлөл багатай.

Аудитын дүгнэлтэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүд, санхүүжилт, салбарын бүтэц, үйлчилгээний удирдлага зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр өргөн хүрээний зөвлөмжүүдийг тусгасан. Өмнөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх явц удаашралтай, түүнчлэн 2011 оноос хойш ажиллах хүчний оролцооны түвшин тогтмол буурах үзэгдэл ажиглагдаж байгаа нь

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоонд дүн шинжилгээ хийж, системийн түвшинд шинэчлэл хийх шаардлага байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өнөөгийн үйл ажиллагааны ихэнх нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар (ХЭДХ) зохицуулагддаг тул загварчлал, удирдлагын зохицуулалт, санхүүжилт зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний экосистемд шинэчлэл хийхэд эхлээд ХЭДХ-инд холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай. Тиймээс төслийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж ХНХЯ-нд хүргүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, холбогдох зардлын тооцоолол, үр нөлөөллийн үнэлгээ зэргийг тусгасан бодлогын баримт бичгийг төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамны түвшинд хянан хэлэлцэж байна. ХЭДХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан гол өөрчлөлтүүдийг дурдвал:

- Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагуудын макро эдийн засгийн бодлогын түвшний чиг үүргийг тодорхойлж, нэвтрүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага буюу институцид суурилсан тогтолцооноос шилжиж, хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ (профайлинг) хийх замаар үйлчлүүлэгч төвтэй тогтолцоог нэвтрүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэгж зардлын хэмжээ болон жишиг норм, нормативыг нэвтрүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад даалгаж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн чиг үүрэг нь удирдлага, стратегийн түвшинд түлхүү байх.

ХЭДХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг харгалзан 2022-2023 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн шинэчилсэн загварын төслийг боловсруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд (ХЭДХ) тусгах үндсэн өөрчлөлийг дурдвал:

ХЭДХ 2022	2023 онд хэрэгжүүлэхээр санал болгосон ХЭДХ
<p>Зорилтот 7 хөтөлбөр, санхүүжилтийг өөр хооронд нь шилжүүлэх боломжгүй (зорилтот бүлэгт суурилсан):</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр - Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр - Ногоон ажлын байр хөтөлбөр - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр - Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 	<p>Зорилтот бүлгүүдэд чиглэсэн тусгай хөтөлбөрүүдийг дотроо агуулах боломжтой өргөн цар хүрээ бүхий 5 арга хэмжээ (арга хэмжээний чиг үүрэгт суурилсан):</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх сургалт - Санхүүгийн дэмжлэг - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ - Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ - Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс тодорхойлсон төсөл, хөтөлбөрүүд

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	
Санхүүжилт олгох хугацаа – голдуу 4, 9 дүгээр сард, ажил хайгчдын бодит хэрэгцээг харгалздаггүй	Жилийн туршид санхүүжилтийг тасралтгүй олгох
Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI) нь үйлчилгээ авсан иргэдийн тоонд суурилдаг	Ажилтай болсон, нийгмийн даатгалын шимтгэл төлж буй иргэдийн тоо зэрэг бодит үр дүнд суурилсан Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)
Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI) нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн зохих түвшинд байдаггүй	Анхан шатны нэгжүүдэд Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг хөтөлбөрийн түвшний үр дүнтэй холбох, улмаар салбарын ба үндэсний түвшинд нэгтгэх (туршилтын аймаг, дүүрэгт зайлшгүй)
Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ болон хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө шаардлагагүй	Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ болон хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө шаардлагатай (туршилтын аймаг, дүүрэгт зайлшгүй)
Нэгж зардлын хэмжээг тооцдоггүй	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэгж зардлын хэмжээг тооцно (туршилтын аймаг, дүүрэгт зайлшгүй)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ болон арга хэмжээг (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд) хэрэгжүүлэх удирдамж болон хяналт шинжилгээ ба үнэлгээний удирдамжийг боловсруулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны шинэчилсэн загвартай холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийн ажил үүргийн тодорхойлолт, хуваарилалтыг шинэчлэн боловсруулж, саналыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хянан батлуулахаар хүргүүлээд байна.

Гарч буй хүндрэлүүд: Олон тооны хүмүүст нөлөөлөх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний өнөөгийн загвар хэдэн жил үргэлжилж байгааг харгалзан бодлого боловсруулагчид шат дараатай алгуур хандахыг илүүд үзсэний улмаас 2022 оны төлөвлөгөөний холбогдох үйл ажиллагааг удаашруулахад нөлөөлсөн. Тиймээс, нийгмийн түншүүд болон хөдөлмөрийн зах зээлийн бусад оролцогч талуудад чиглэсэн нөлөөллийн болон мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

С.1.2 Хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэмжих үйлчилгээ.

Энэхүү дэд зорилтын хүрээнд үндсэн хоёр чиглэлийн үйл ажиллагаа, тухайлбал хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

а) Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх чиглэлээр нийслэл болон 21 аймгийн хэмжээнд чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Швейцарын Хөгжлийн Агентлаг болон Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн төслүүдийн хүрээнд өмнө нь

боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх аргачлалыг энэхүү Төслийн хүрээнд туршин, боловсронгуй болгож улмаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) баталсан.

2022 онд хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх аргачлалын сургалтыг орон даяар хөдөлмөр эрхлэлтийн бүх газар, хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан. Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр 21 аймаг, 9 дүүргийн 240 орчим хөдөлмөр эрхлэлтийн ажилтны (газар хэлтсийн дарга нар) чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг 2022 оны 4 дүгээр сард хэрэгжүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжүүдэд ажиллаж, орон нутгийн ажилгүйдлийг бууруулахад хувь нэмрээ оруулдаг сумын 360 гаруй мэргэжилтнийг цахим сургалтад хамруулсан. Түүнчлэн танхимын болон цахим сургалтад хамрагдсан 502 ажилтанд хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх аргачлалыг хэрхэн ашиглах талаар ганцаарчилсан зөвлөгөө, чиглүүлэг өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг гэрээгээр үзүүлдэг 30 гаруй хувийн хөдөлмөрийн биржийн ажилтнуудыг дээрх сургалтад хамруулсан.

ХХҮЕГ-аас мэдээлснээр, 2022 оны 9 дүгээр сар гэхэд нийт 13,600 орчим ажил хайгчид хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийсэн байна. Ингэснээр, Монгол Улсад анх удаа ажил хайгчдын хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ бүхий мэдээллийн сан үндэсний хэмжээнд бий болох, үйлчлүүлэгч суурьтай үйлчилгээний үндэс суурь тавигдаж, улмаар холбогдох бүх шатны нэгж байгууллагууд зорилтот бүлгүүдийг ажилтай болгох хүртэл тасралтгүй дэмжлэг үзүүлэх боломж бүрдэж байна. Энэхүү чухал үр дүнд хүрэхэд орон нутгийн (сум, хороо) хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдэд 2022 оны 2-оос 10 дугаар сарын хооронд арга зүйн зөвлөгөө, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлсэн Менторингийн баг (чиг баримжааны зөвлөгөө өгөх чиглэлээр ажилладаг ТББ болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээний чиглэлээр ажилладаг хувийн хөдөлмөрийн биржүүд, зөвлөх бүхий 20 сургагч багшаас бүрдсэн) чухал үүрэг гүйцэтгэв.

Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээний чанарын баталгаажуулалт болон мониторинг хийх ажлыг ХНХЯ-наас нийслэлийн бүх дүүрэг болон 12 аймагт төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн. Мониторингийн ажлын хүрээнд дараах үндсэн дүгнэлтийг гаргав. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлдэг өнөөгийн бүтэц нь (хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тогтоосон квот, хувь хэмжээнд суурилдаг) хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээг түгээн дэлгэрүүлэхийг дэмждэггүй, учир нь тогтоосон квот, үйлчлүүлэгчийн эрэлхийлж буй үйлчилгээний хооронд зөрүү үүсдэг.
- Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт нь үйлчлүүлэгч суурьтай үйлчилгээний (кэйс менежментийн) загварт нийцэхгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тодорхой арга хэмжээ нь зарим аймаг, дүүрэгт хамааралгүй, эсвэл эрэлт хэрэгцээгүй байна.

Мониторингийн ажлын үр дүнд үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх Ажлын хэсгийг ХНХЯ-нд байгуулсан. Ажлын хэсэг нь аймаг, дүүргийн онцлог нөхцөл байдлыг харгалзан санхүүжилтийг хуваарилах, үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн

үйлчилгээнд тохирохуйц байгууллагын бүтцийг бий болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх юм. Төслийн баг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг төсөвтэй уялдуулах чиглэлээр Ажлын хэсэгт техникийн дэмжлэг үзүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг 2022 оны сүүлчээр эхлүүлсэн. Ажил хайгч болон ажил олгогчид хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнүүдийн талаар хангалттай мэдээлэлгүй байгааг судалгаа харуулсан. Иймд ХНХЯ-ны удирдлага дор үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ болон хөдөлмөр эрхлэлтийн бусад үйлчилгээ, арга хэмжээний ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл, сурталчилгааны багцыг боловсруулсан. Мэдээлэл сурталчилгааны тус багцад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний чиглэлээр богино хэмжээний 1 видео, 4 инфографик бүхий 4 видео, 3 зурагт хуудас, 3 товхимол бэлтгэж, ХНХЯ-нд хянуулахаар хүргүүлсэн.

b) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын арга хэмжээ

2021 онд хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээний үр дүнд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн өнөөгийн болон ирээдүйн загварыг сайжруулах зорилготой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 4 гол арга хэмжээг 2022 онд туршсан. Үүнд: 1) дадлагажуулах сургалт, 2) цалинтай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих мэргэжлийн боловсрол, сургалтын арга хэмжээ, 3) хоршоодыг дэмжих арга хэмжээ, 4) хувиараа хөдөлмөр эрхлэлтийг түлхүү дэмжсэн ЖДҮ болон аж ахуй эрхлэлтийн арга хэмжээ тус тус багтсан.

Ажилгүй, ажил хайж буй нийт 91 хүн (40 эрэгтэй, 51 эмэгтэй) туршилтын арга хэмжээнд хамрагдсан ба эдгээр арга хэмжээ хэрэгжиж дуусах үед оролцогчдын тоо 240 хүртэл нэмэгдэнэ. Бүх оролцогч хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийлгэж, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөөг боловсруулсан. Туршлагатай байгууллагуудтай түншлэх, тэдний туршлага болон сургамжийг ашиглах замаар туршилтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Дадлагажуулах сургалтыг МАОЭНХ-той хамтран 2022 онд эхлүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, стратегийг хэлэлцэх явцад ажил хайгч иргэд, шинэ ажилтнуудыг сургахад ажил олгогч болон хувийн хэвшлийн үүрэг оролцоотой холбоотой асуудал ихэд хөндөгдсөн. Тиймээс, туршилтын хөтөлбөрийг ажил олгогч, бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллага болох МАОЭНХ-той хамтран эхлүүлж, дараах гурван чиглэлийн үйл ажиллагааг багтаасан, үүнд: ментор бэлтгэх; дадлагажуулах хөтөлбөрт хамрагдахаас өмнө оролцогчдын зөөлөн үр чадварыг хөгжүүлэх; дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байраар хангах тус тус багтсан. 2022 оны эцэс гэхэд дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг нийт 60 хүн төгсөх төлөвтэй байна.

Гарч буй хүндрэлүүд: Одоогоор ажил хайгч, ажил олгогчид ээлтэй дадлагажуулах хөтөлбөрийн механизм дутагдаж байна. Хөтөлбөрт дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албад, сургалтын байгууллагууд, ажил хайгчид, ажил олгогчид (хүний нөөцийн ажилтнууд, сурган хүмүүжүүлэгч нар) зэрэг олон талууд хамрагдсан бөгөөд тэдний үүрэг хариуцлага, хүлээлтийг нарийн тодорхойлж,

ойлгуулах нь чухал байсан. Тиймээс, энэ чиглэлээр МАОЭНХ-той хамтран дотоодын үнэлгээг гүйцэтгэж байна. Ажил хайгчийн хүсэл сонирхлыг ажил олгогчийн шаардлагатай нийцүүлэх нь мөн хүндрэлтэй байсан бөгөөд энэ асуудлыг хамтаар шийдвэрлэх нь илүү үр дүнтэй байх юм. Гэсэн хэдий ч дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Засгийн газрын арга хэмжээний нэг хэсэг болгон, илүү олон хүнийг хамруулж, түгээн дэлгэрүүлэх боломжтой хэмээн үзэж байна.

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих (энтрепренершип) хөтөлбөрийг 2022 онд амжилттай хэрэгжүүлж, 60 хүн, 20 жижиг бизнесийг хамруулсан. Хөтөлбөр эхлэхэд энтрепренершипийн 6 модуль сурталтанд 60 хүн хамрагдаж, улмаар бизнес санаагаа боломжит хөрөнгө оруулагчид танилцуулах питч арга хэмжээг 2022 оны 5 дугаар сард зохион байгуулсан. Хөтөлбөрийн төгсгөлд оролцогчид хувийн бизнесээ эхлүүлэх, санхүүжилтийн нөхцөл шаардлагыг хангасан байна хэмээн үзэж байна. Оролцогчдын дундаас багаар бодож нэг хүн дүүргийн гарааны бизнесийг дэмжих сангаас санхүүжилт авах нөхцөлийг хангасан байна. Энтрепренершип хөтөлбөрийн загвар, хэрэгжүүлэх арга зам нь оновчтой байсан нь харагдаж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг (санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ) шинэчлэн боловсруулах үүрэгтэй байгуулагдсан ХНХЯ-ны Ажлын хэсэг үүнийг анхааралдаа авахаар болов.

Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хоршоодын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өндөр хэмээн үзэж байгаа тул сумдад амьдарч буй ажилгүйчүүд, ажил хайгч иргэдийг нэмүү өртгийн сүлжээ, хоршоодод хамруулах зорилгоор төслийн техник арга зүйн дэмжлэгтэйгээр хэд хэдэн нэмүү өртгийн сүлжээ/хоршоодыг 2022 онд байгуулсан. Жижиг зээл олгодог байсан Сум хөгжүүлэх санг хоршоодод зээл олгох зорилготой Хоршоог дэмжих сан болгон шинэчлэв.

Төслийн хүрээнд Хоршоог дэмжих орон нутгийн сангийн шугамаар сонгогдсон хоршоодод техник арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажилласан. Иргэдийг зохион байгуулалтад оруулах, тэднийг сургах, хоршоод байгуулж нэгдэх эрмэлзлийг нь хөгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт шаардагдсан. Техникийн дэмжлэг үзүүлэх ажил үндсэндээ дуусаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээг Баянчандмань сумын засаг даргын тамгын газартай байгуулах ажил хүлээгдэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн алба, хорооны мэргэжилтнүүдэд зан төлөвийн судалгаа, сургалт явуулах шинэлэг хөтөлбөрийг эхлүүлсэн. Үйлчлүүлэгчтэй өдөр тутам харьцаж, үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжид ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдэд үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний орчин үеийн арга барил, үр чадварыг эзэмшүүлэх нь нэн чухал юм. Төрийн албан хаагчдад загварчлах сэтгэлгээ, зан төлөвийн аргачлал эзэмшүүлэх чиглэлээр НҮБХХ-ийн хуримтлуулсан өмнөх түршлагад тулгуурласан энэхүү үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар, үйлчилгээ үзүүлэх арга барилыг сайжруулахад чиглэсэн шинэ санаа санаачилга, түршлага бий болгож, түгээн дэлгэрүүлэх зорилготой.

С.1.3 Үндэсний хөтөлбөрүүд болон яамны төсөвт тусгагдсан дэмжих үйлчилгээ.

Энэхүү дэд зорилт нь Төслийн хүрээнд санаачилсан үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад гол үүрэгтэй. Тайлангийн (С.1.2) хэсэгт танилцуулсан туршилтын үйл ажиллагаануудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон арга хэмжээнд тусгах зорилготой. Эдгээрийг 2023, 2024 оны төсвийн мөчлөгт тусгахын тулд хэд хэдэн үйл ажиллагааг 2022 онд Төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн.

Хоёр байршилд хэрэгжүүлсэн туршилтын үйл ажиллагааны урьдчилсан дүгнэлтийг техник аргагүйн хэлэлцүүлгийн үеэр ХНХЯ-нд танилцуулсан. Туршилтын үйл ажиллагааны зардлын тооцооллыг хийж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээний нэгж зардлын хэмжээг тогтоож, ХНХЯ-ны 2023 төсвийн саналд тусгасан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл 2022 оны 12 дугаар сард хуралдаж ХЭДС-гийн төсвийг батлах бөгөөд төсвийн саналд хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээний нэгж зардлын тооцооллыг багтаасан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл цуглуулах явцыг хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх аргачлалтай хослуулах саналыг боловсруулж, түүнд харилцан уялдаа холбоо бүхий хоёр санал асуулгыг багтаасан. Санал болгосон загварыг ХНХЯ болон ҮСГ хянан хэлэлцэж, батлахаас өмнө техникийн бүлгээр хэлэлцэхээр төлөвлөж байна.

ДБ-ны дэмжлэгтэйгээр шинэчилж буй хөдөлмөр эрхлэлтийн цахим систем E-Job платформд хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээний мэдээлэл оруулах хэсэг байгаа бөгөөд энэхүү үйлчилгээ үзүүлэх бизнес процессын талаарх мэдээллийг ДБ-ны төслийн мэргэжилтнүүдэд өгсөн.

ХНХЯ-наас E-Job платформыг 2022 оны 12 дугаар сард нээхээр төлөвлөж байгаа ба ингэхдээ цахим сургалтын агуулгыг (хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ, аж ахуй эрхлэлтийн сургалт, ажил мэргэжлийн чиг баримжааны зөвлөгөө) цахим системд суулгасан байхаар төлөвлөж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын чиг үүргийг ХНХЯ-наас БШУЯ-нд шилжүүлсний улмаас **МБС-ын байгууллагын төгсөгчдийн мэдээллийн системийг** нэвтрүүлэх ажил анх төлөвлөснөөс удаашралтай байна. Төгсөгчдийн мэдээллийн системийн хамрах хүрээг өргөжүүлж их дээд сургууль, коллежийн төгсөгчдийг хамруулахаар шийдвэрлэсэн. Гэвч мэдээллийн систем аль яаманд харьяалагдах нь шийдэгдээгүй хэвээр байна. Төгсөгчдийн мэдээллийн системийн тогтвортой байдлыг хангахын тулд системийн зориулалт, ач холбогдол, оролцогч талуудын оролцооны талаар Төслийн хүрээнд холбогдох хоёр яаманд мэдээлэл, зөвлөмжийг үргэлжлүүлэн хүргэнэ.

Богино хугацааны, түр сургалт явуулдаг байгууллагуудын мэдээлэл агуулсан цахим хуудсыг www.mergejil.mn платформд өргөтгөл хэлбэрээр 2022 онд нэмж оруулсан. Одоогоор тус системд сургалтын төвүүд, багшлах бүрэлдэхүүн, оюутан сурагчид, сургалтын модуль, гэрчилгээ олгох журам, гэрчилгээний цахим төлбөр зэрэг мэргэжлийн боловсрол, сургалттай холбоотой 1,024 түр сургалтын байгууллагын мэдээлэл орсон.

С.2 ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, БИЗНЕС ИНКУБАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭХЭД ЗОРИУЛСАН ЭКОСИСТЕМИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Төслийн дэд зорилт	Шалгуур Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2022)	2022 оны хэрэгжилт
Дэд зорилт С.2.1 Инновац, гарааны бизнесийн санаачилгын нэгдсэн платформ	С.2.1.1 Нийтлэг платформын загварыг боловсруулж хэрэгжүүлэх	0	1 платформын загварыг боловсруулж, хэвийн ажиллагааг хангах	Хугацаандаа хэрэгжих боломжгүй. Тус үйл ажиллагааны хэлбэр, дизайныг шинэчлэх талаар ЕХ болон Төслийн Удирдах зөвлөлтэй зөвшилцөх шаардлагатай
	С.2.1.3 Төвийн бүтэц загварыг боловсруулж, хөгжүүлэх	0	1 ТЭЗҮ	
Дэд зорилт С.2.2 Донор/ОУ-ын байгууллагуудын хэрэгжүүлсэн санаачилга, төслийн зураглал, нэгдсэн үнэлгээ	С.2.2.1. Иж бүрэн үнэлгээний зураглалыг гаргах	0	1 шинэчлэл	Хугацаандаа хэрэгжих байна. Системийг эхлүүлсэн
	С.2.2.2. Засгийн газар, донор хоорондын хамтарсан дэмжлэг үзүүлэх платформыг бий болгох	Байхгүй	1 зөвлөлдөх уулзалт	Хугацаандаа хэрэгжих байна. Анхны хамтарсан уулзалтад засгийн газар, хандивлагч нарын төлөөлөгчид оролцсон
	С.2.2.3. Хөдөлмөрийн эрхлэх чадварыг бэхжүүлэх чиглэлээр оролцоог хангах	Байхгүй	Оролцоог үнэлэх	Хугацаандаа хэрэгжих байна. Системийг шинэчилж, оролцоог харуулах боломжтой болсон.
Дэд зорилт С.2.3 Залуучууд, алслагдсан бүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түлхүү	С.2.3.1. Шинэлэг/гарааны бизнесийн санааг дэмжих хүрээг тодорхойлох	Байхгүй	10-аас доошгүй бизнес санааг боловсруулах 4-с доошгүй бизнесийг дэмжих	Хугацаандаа хэрэгжих байна. 20 бизнесийг бойжуулж байна, Баянчандмань сумын 3 хоршоонд дэмжлэг үзүүлнэ.

хамруулсан гарааны бизнесийг дэмжих	С.2.3.2. хамтарсан дэмжлэг үзүүлэх платформын үнэлгээ, шинэчлэл хийх	Байхгүй	Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх 20 шинэ боломж	Хугацаандаа хэрэгжих боломжгүй.
-------------------------------------	--	---------	--	--

С.2.1. Инновац, гарааны бизнесийн санаачилгын нэгдсэн платформ.

Инновац, гарааны бизнес, бизнес инкубацийн экосистемийг дэмжих оновчтой арга замыг тодорхойлох зорилго бүхий дүн шинжилгээг 2021 оны 12 дугаар сард хийсэн. Гарааны бизнесийг дэмжих олон үйл ажиллагааг төрөл бүрийн байгууллага, төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой хэдий ч шинээр үйл ажиллагаа эхлүүлэхийн оронд одоо байгаа платформыг өргөжүүлэх, үзүүлж буй үйлчилгээг хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх чиглэлээр хамтран ажиллах нь илүү үр дүнтэй гэдэг нь дүн шинжилгээнээс харагдаж байна. Цаашид энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаар зөвшилцөх шатанд байна.

С.2.2. Донор/ОУ-ын байгууллагуудын хэрэгжүүлсэн санаачилга, төслийн зураглал, нэгдсэн үнэлгээ.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй донор байгууллагуудын төсөл, санаачилгуудыг нэгтгэсэн платформыг үүсгэж <https://projects.mlsp.gov.mn/public> цахим хуудсанд 2022 оны 4 дүгээр сард байршуулсан. Энэхүү систем нь мэдээлэл хуваалцах, ил тод байдлыг хангах, мэдээ мэдээллийг оруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих экосистемд ажиллаж буй оролцогч талуудын хамтын хүчин чармайлтыг зохицуулахад хувь нэмэр оруулна. Өнөөгийн байдлаар системд 25 төслийн мэдээлэл байгаагаас 15 нь дуусгавар болсон байна. Системийн нээлт болон анхны хамтарсан үүлзалтад ХНХЯ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын судалгааны хүрээлэн, хөгжлийн байгууллага, төслүүдийг төлөөлөл бүхий 40 гаруй төлөөлөгч оролцов. Мэдээллийг бүрэн оруулах, тогтмол шинэчлэхэд төслийн зүгээс хяналт тавин ажиллаж байна.

С.2.3 Залуучууд, алслагдсан бүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түлхүү хамруулсан гарааны бизнесийг дэмжих.

Энэхүү дэд зорилт нь аж ахуй эрхлэгч болон жижиг бизнесүүдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энтрепренершипийн туршилтын үйл ажиллагаатай (түс тайлангийн С.1.2) нягт холбоотой юм. Түс хөтөлбөрийн загвар, хэрэгжүүлэх арга зам нь оновчтой байсан нь харагдаж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг (санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ) шинэчлэн боловсруулах үүрэгтэй байгуулагдсан ХНХЯ-ны Ажлын хэсэг үүнийг анхааралдаа авахаар болсон. Харин стартап платформын үнэлгээ, шинэчлэл хийх ажлын хувьд төслийн хүрээнд үзүүлэх дэмжлэгийн эрэлт, шаардлагын талаар нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж байна. Түүнчлэн,

Залуучуудын зөөлөн үр чадвар, энтрепренершип сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 12 подкастын дугаараас тайлангийн хугацаанд 10-ыг бэлдэж, үндэсний хэмжээнд цацсан. Подкастын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-с харна уу.

С.3 АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААНЫ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ИНСТИТУТЧИЛЭХ

Дэд зорилт С2 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд түлхүү чиглэдэг бол дэд зорилт С3 нь сургалт, боловсрол, үр чадвар хөгжүүлэлт, ажил мэргэжлийн чиг баримжааны зөвлөгөө өгөх механизмыг боловсронгуй болгох, зөөлөн үр чадвар, ажилтан-ажил олгогчийн харилцааг хөгжүүлэх шинэлэг арга зүйг нэвтрүүлэх замаар хөдөлмөр эрхлэх боломжуудыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

С.3.1. Загварчлах сэтгэлгээг хөгжүүлэх, ухаалаг шийдвэр гаргах зөв дадал-зан төлөв суулгах чиглэлээр заах сургагч багш нар болон энтерпрайзинг боловсролын заах арга зүйг эзэмшүүлэх сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх.

Оюутнуудын аж ахуй эрхлэх (энтрепренершип) үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн Мэргэжлийн боловсрол дахь энтерпрайзинг сургалтын модуль, гарын авлага боловсруулах ажлыг эхлүүлсэн. Энэ бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгоход чиглэсэн чухал үйл ажиллагаануудын нэг юм. Бизнес эрхлэлтийн сургалтын агуулга, арга зүйн зөрүүг тодорхойлох, энэ чиглэлээр сургагч багш нарыг бэлтгэх арга замуудыг судлах зорилгоор МБС-ын Бизнес эрхлэх үр чадварын сургалтын хөтөлбөрийн нөхцөл байдлын судалгаа хийсэн. Судалгааны үр дүн болон төслийн хүрээнд боловсруулсан 5 зөвлөмжийг БШУЯ-ны холбогдох байгууллагууд болон МБС-ын байгууллагын төлөөлөлд танилцуулсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын хүрээг боловсруулсан, ингэхдээ төлөвлөлтөөс эхлээд үнэлгээ хийх хүртэл бүх үе шатуудыг цогц байдлаар харуулж, ажил үүргийн давхцал, давхардлыг арилгахыг зорьсон. Тус хүрээнд тодорхойлсон үе шат/түвшин бүрд зорилго, холбогдох арга хэрэгсэл, шалгуур үзүүлэлт болон оролцох байгууллага, хүлээгдэж буй үр дүнг нарийвчлан тусгасан. Тус хүрээг боловсруулахдаа техникийн 5 зөвлөмжийг дагалдуулан гаргаж, цаашдын үйл ажиллагаанд харгалзан үзэхийг санал болгосон. МБС-ын салбарын чанарын баталгаажилт бол ЕХ-ноос МУ-ын Засгийн газарт олгож буй төсвийн шууд түслалцааны нэгэн шалгуур үзүүлэлт юм. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын хүрээг боловсруулахаас өмнө гүйцэтгэсэн судалгааны үр дүнг БШУЯ-нд хүргүүлсэн болно. Чанарын баталгаажуулалт нь дараах арга хэрэгсэл, аргачлалыг агуулна, үүнд: i) сургагч багшийн ажил; ii) сургалтын хөтөлбөр; iii) МБС-ын байгууллагын үйл ажиллагаа тус тус багтана.

Мэргэжлийн боловсрол, сургалтын индексийг шинэчлэх ажлыг Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод нийцүүлэн гүйцэтгэж байна.

С.3.2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажил мэргэжлийн зөвлөх бэлтгэх зайн/цахим платформ

ХБИ-д зориулсан дараах гурван мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулж түршсан, үүнд: i) Архивын ажилтан ба оффисын туслах, ii) Цахим үйлчилгээний ажилтан, iii) Үйлчилгээний туслах ажилтан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эдгээр гурван мэргэжлийг заах нарийвчилсан заавар бүхий багшийн гарын авлагыг бэлтгэж түгээсний зэрэгцээ оюутнуудад зориулж 22 чадамжийн нэгж бүхий гарын авлагыг боловсруулж, дохионы хэлний тайлбар оруулсан. Гарын авлагыг боловсруулах явцад эрсдэл, хориг зэрэг мэргэжлийн үг, нэр томъёог тайлбарлах 300 шинэ дохио боловсруулсан ба одоо бүх гарын авлагыг хэвлэлд өгөхөөр бэлтгэж, 12 дугаар сард түгээхээр төлөвлөсөн. Түүнчлэн, гарын авлагыг цахим номын хэлбэрт оруулах ажил хийгдэж байна.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвд өнгөрсөн 2 жилийн хугацаанд хөтөлбөрийг туршин хэрэгжүүлсэн, үүнд нийт 28 оюутан хамрагдсанаас Цахим үйлчилгээний ажилтнаар 16, архивын ажилтан ба оффисын туслахаар 12 хүнийг сургасан.

ХБИ-дэд хүртээмжтэй сургалтын орчин бий болгох зорилгоор Баянчандмань сумын Политехникийн коллежид засварын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд үүний өмнө техникийн шаардлагыг тусгасан үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн болно. Дээр дурдсан сургалтын хөтөлбөрүүдийг тус политехник коллежид 2023 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

С.3.3. Ажил олгогчид чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх платформ

Ажил олгогч, ажилтнууд хоорондын харилцааг сайжруулах шинэлэг санаа, санаачилгыг дэмжих, хамгийн оновчтой санааг судлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор тэтгэлэгт хөтөлбөрийг төслийн хүрээнд зарласан. Өөрсдийн боловсруулсан шинэлэг санаа, санаачилгаар Олон улсын эмэгтэйчүүдийн худалдаа аж үйлдвэрийн холбоо, Уул уурхай ашигт малтмалын салбарын эмэгтэйчүүдийн холбоо гэсэн мэргэжлийн хоёр ТББ тус тус шалгарсан.

Олон улсын эмэгтэйчүүдийн худалдаа аж үйлдвэрийн холбоо нь тус тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Ухамсартай Манлайллын Элч” нарыг бэлтгэх бөгөөд эдгээр манлайлагч ажил олгогчид Тогтвортой хөгжлийн зорилтууд, Олон улсын хөдөлмөрийн стандартууд, бизнес, байгаль орчин, хүний эрхийн асуудлыг хэрэгжүүлэх, ажил олгогч, ажилтан хоорондын харилцааг сайжруулах хүртээмжтэй платформыг бий болгож хөгжүүлэхэд анхаарч ажиллах юм. Харин, Уул уурхай ашигт малтмалын салбарын эмэгтэйчүүдийн холбоо нь нийгмийн баялаг бүтээгч салбар болох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалан, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг Хүнс, ХАА-н чиглэлийн тогтвортой бизнес, үйлдвэрлэлийн 20 компанийн удирдлагын зан байдлын өөрчлөлтийг дэмжих замаар мэдлэг хуваалцах байнгын платформ байгуулах ажлыг гүйцэтгэхээр санал боловсруулсан.

Дээрх хоёр тэтгэлэгт хөтөлбөр нь ажил олгогч, ажилтан хоорондын эрүүл харилцаа, харилцан ойлголцлыг сайжруулах шилдэг туршлагыг бий болгож, түгээн дэлгэрүүлэх нэгдсэн талбарыг

байгуулах зорилготой. Тэтгэлэгт хөтөлбөрийг 2023 оны 9 дүгээр сар хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

С.4 БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, НОТОЛГОО БОЛОН СУРГАМЖИД ТУЛГУУРЛАСАН АРГА ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН ТУРШИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүрэлдэхүүн хэсэг С.4-ийг НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) (С. 4.1-С.4.4), С4.5-г НҮБХХ тус тус хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд доор дурдсан тодорхой таван үр дүнд хүрэхийг зорьдог.

Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
С.4.1. Хөдөө аж ахуйн салбарт (өртгийн сүлжээ) залуучуудыг олноор нь ажиллуулах боломж олгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй загварыг илрүүлж, загварлан бүтээж, туршина	С.4.1.1 Амжилттай хэрэгжүүлсэн Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тоо (ТХХТ) (эцсийн хэрэглэгчийн тоо нэмэгдсэн байна)	0	2 ТХХТ-г туршсан байна	Хугацаандаа хэрэгжиж байна: 1 ТХХТ-ийг туршсан (ингэний сүү)
	С.4.1.2 Ур чадварын хэрэгцээг тодорхойлж, сургалт явуулах	0	50 хүнд сургалт. Шаардлагатай технологи дамжуулсан байна	Хугацаандаа хэрэгжиж байна: 2 богино хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. 2023 онд сургалт зохион байгуулна.
	С.4.1.3 Сүлжээний платформыг сурталчлах	0	4 уулзалт зохион байгуулсан байна	Хугацаандаа хэрэгжиж байна: 4 уулзалт зохион байгуулсан байна
	С.4.1.4 Хөдөө аж ахуйн салбарын өртгийн сонгосон сүлжээг дэмжих	0	Шаардлагатай технологийг нэвтрүүлсэн байна	Хугацаандаа хэрэгжиж байна: Шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалт дууссан.

С.4.1. Хөдөө аж ахуйн салбарт (өртгийн сүлжээ) залуучуудыг олноор нь ажиллуулах боломж олгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй загварыг илрүүлж, загварлан бүтээж, туршина (үндэсний хөтөлбөрүүдийг газар дээр нь уялдаатай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор)

Төслийн баг нь экспортод чиглэсэн боломжит бүтээгдэхүүнийг сонгохдоо хүнс, хөдөө аж ахуйн салбарт хийгдсэн дотоодын болон олон улсын байгууллагуудын хийсэн судалгаа тайлангуудтай танилцаж, үндэсний хэмжээний 20 орчим боловсруулах үйлдвэр компаниудтай үулзалт, зөвлөгөөн хийж, бүтээгдэхүүний хувьд гар аргаар боловсруулсан бяслаг, уургийн өндөр агууламжтай шар сүүний ундаа гэх зэрэг хэдэн арван бүтээгдэхүүнүүдийг 2022 онд судалж, дотоод дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Төслөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар дамжуулан ХАА-н нэмүү өртгийн сүлжээ, тухайлбал ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээнд ТХХТ-ийг нэвтрүүлж, 2022 онд доорх **хоёр ажилд томоохон үр дүн гараад байна:**

- Ингэний сүү нийлүүлэлт буюу гинжин хэлхээг хөдөө аж ахуйн анхан шатанд нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг илүү үр ашигтай болгох болон сүүний чанарыг сайжруулах зорилгоор ТХХТ-ийн загвар, хамтын ажиллагааг дэмжин **“Ингэний сүүний үйлдвэрлэгчдийн 20 гишүүнтэй хоршоо”**-г 2022 оны 9 дүгээр сард байгуулсан.
- Нэмүү өртгийн сүлжээнд хамгийн сул хэмээн тодорхойлогдсон түүхий эд болох **сүүний нийлүүлэлт** нь Төслийн үйл ажиллагааны дүнд хоршоо байгуулснаар нэмэгдэж, 2022 оны 2 дугаар сартай харьцуулахад өдөрт 225 литр байснаас 2022 оны 9 дүгээр сарын байдлаар өдөрт 700-800 литр болсон. Хоршоо байгуулахаас өмнө 9 өрхийн 18-н малчид (*гэр бүлийн гишүүдийг тооцон*) сүүгээ нийлүүлж байсан бол одоо нийт 40 малчин болж хоёр дахин нэмэгдсэн.

Төслөөс санаачилсан гол 5 үйл ажиллагаа дараах үр дүнд хүрэв. Үүнд:

Ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээний хүрээнд ТХХТ-ийн зураглалыг гаргаж, төслөөс хамгийн үр дүнтэй оролцох чиглэлүүдийг тодорхойлсон. Зураглалыг үндэсний ингэ судлаачийн боловсруулсан суурь судалгаа болон бусад судалгаанууд¹² дээр үндэслэн суурилан гаргасан. Тус судалгаанууд нь дэлхийн зах зээлд ингэний сүү ихээхэн эрэлттэйн хувьд ингэний сүүн бүтээгдэхүүнийг худалдааны эргэлтэд оруулах, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартайг харуулсан.

“Ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээний ашиг шим хүртэгч”-дийн зөвлөлдөх үулзалтыг Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2022 оны 2 дугаар сард зохион байгуулсан. Зөвлөгөөнд олон талын төлөөллүүд болох төр, хувийн хэвшил, малчид, судлаачид, төсөл хэрэгжүүлэх нэгж оролцсон бөгөөд тэмээчин өрхүүд нь хоорондоо алслагдан суурьшсан, нүүдэллэдэг, сүү тээвэрлэлтийн өртөг өндөр, саальчин дутмаг зэрэг нь ингэний сүүний нийлүүлэлт бага байгаагийн шалтгаан болж байгаа бөгөөд нэмүү өртгийн сүлжээ дэх хүндрэл бэрхшээлийг хамтдаа тодорхойлсон.

Төслийн зураглалыг хийсний дараа зах зээлд нэгэнт байр сууриа эзэлсэн хувийн хэвшлийн тоглогчидтой хамтран ажиллаж, сүүний нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх замаар саальчин

¹² Европын холбооны санхүүжилттэй “Худалдааг дэмжих төсөл”-өөс боловсруулсан

өрхийн тоог нэмэгдүүлэх нь илүү оновчтой гэж төслийн зүгээс дүгнэж, санхүүгийн хувьд үр ашигтай, логистикийн хувьд тохиромжтой сүү цуглуулах замыг боловсруулагч тал болох ТЭСО ХХК шинээр сүү цуглуулах өрхүүдийг тодорхойлсон. Түүнчлэн, хоршоо байгуулах нь ХХААХҮЯ-наас санаачлан хэрэгжүүлж буй “Хоршооллын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр-III”-ийн бодлогын хөшүүрэгтэй сайн уялдаж байна.

Ингэний сүүний шинэлэг чанар болон хадгалах хугацааг уртасгахад нарны эрчим хүчээр ажилладаг хүйтэн гинжин хэлхээний системээр хоршооны гишүүдэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг төсөл олж тодорхойлсон. Төслийн хүрээнд хагас эрчимжүүлсэн эко-ингэний сүүний ферм болон түшиц хоршоонд нарны эрчим хүчээр ажилладаг хүйтэн гинжин хэлхээний системийн тоног төхөөрөмж (Малчин ХХК), ингэний сүүний чанарын баталгаажуулах мэдрэгч тоног төхөөрөмжийг хангаж блокчөйнд суурилсан сүүний чанарын хяналтын системийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжтэй холбох шинэ технологийг нэвтрүүлсэн. Уг шинэ технологи нь 50 литрийн багтаамж бүхий хөлдөөгчид хадгалсан ингэний сүүний температурыг мэдрэгчээр хянаж, үйлдэл бүрийг автоматаар бүртгэх юм. Энэхүү цогц шийдэл нь боловсруулагч компанид түүхий сүүний гарал үүслийг шалгаж, хоршооны гишүүдээс нийлүүлж буй тэмээний сүүний чанар, ариун цэврийн байдлыг хангах боломжийг олгож байгаа юм.

Ингэний сүү үйлдвэрлэлийн талаар олон улсын сүлжээнд мэдлэг түгээж, үнэ цэнтэй харилцах мэдээллүүдийг солилцов. Азийн сүүн бүтээгдэхүүн буюу Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой сүүн бүтээгдэхүүний олон талт түншлэлийн байгууллагаас 2022 оны 5 дугаар сард зохион байгуулсан “Ингэний сүү үйлдвэрлэл болон хэрэглээ” сэдэвт олон улсын цахим хуралд төсөл амжилттай оролцсон. Уг хурлын оролцогчид ингэний сүү боловсруулах олон улсын туршлагын тухай мэдээлэл авч, хамтын ажиллагааны сүлжээ байгуулах болон хамтын хүчин чармайлтаа нэгтгэх боломжтойг цохон дурдаж, саналуудаа хуваалцсан. Түүнчлэн Төслийн баг 2022 оны 6 дугаар сард болсон ЕХ-ны санхүүжилттэй TRAM буюу “Худалдааг дэмжих төсөл”-ийн “Монголын хүнсний бүтээгдэхүүнийг ЕХ-нд экспортлох үйл ажиллагааг эрчимжүүлэх” ажлын зөвлөгөөнд оролцсон. Ажлын зөвлөгөөний хэлэлцүүлгийн явцад ЕХ-ны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP) болон GSP+ системийн үнэлгээний талаар хэлэлцсэн. GSP+ систем нь хөгжиж буй орнуудын татваргүй бүтээгдэхүүнийг ЕХ-нд экспортлоход дэмжлэг үзүүлдэг систем юм. Төслийн баг ТЭСО компанитай хамт ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээний чиглэлээр хийсэн ажлуудаа холбогдох байгууллагуудад танилцуулсан.

Дорноговь аймгийн “МЕКН” ТББ баг “ИНАРУ” тэмээчдийн хоршооны туршлагад үндэслэн уулзалт зохион байгуулж, хоршоо байгуулах талаар туршлага солилцлоо. Мөн ингэний сүүний гаралтай бүтээгдэхүүнийг ЕХ-ны импортын барааны жагсаалтад оруулах боломжийг эрэлхийлэх талаар ГХЯ-ны Худалдааны газартай нягт уялдаатай ажиллаж байна.

Өртгийн сүлжээний оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэв. “Хүнсний аюулгүй байдлын менежмент” сургалтыг 2022 оны 6 дугаар сард МХЕГ, Нийслэлийн МХЕГ, 21 аймгийн Хүнсний аюулгүй байдлын холбогдох албаны байцаагч нарыг хамруулан зохион байгууллаа. Сургалтын үеэр Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын 22000:2018 стандартын шаардлага, хорт бодисын шинжилгээ хийх, баталгаажуулах, хянах арга техникийг танилцуулж, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 22000:2018 стандартыг амжилттай нэвтрүүлсэн “Витафит Милк” ХХК-д газар дээр нь очиж танилцсан.

Ханбогд сумын ХХААГ, Өмнөговь аймгийн МХЕГ-ын хэлтэст Ингэний сүүн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх ажлын хүрээнд дижитал рН-хэмжүүр, дулаан хэмийн мэдрэгчтэй DUO инкубатор, сүүний чанарын шинжилгээний багаж болох Lactoscan, Melamine Elisa болох хяналтын хэрэгсэл зэрэг шаардлагатай хоёр иж бүрдэл тоног төхөөрөмжийг худалдан авч хүлээлгэн өглөө. Энэхүү багц тоног төхөөрөмж нь үйлдвэрлэлийн түвшинд нэмүү өртгийн сүлжээний эхний шатнаас эхлэн сүүний чанарыг цаг тухайд нь хянан, баталгаажуулахад тусалдаг.

ӨМӨЗО-ны Хятад- Казакстаны тэмээ судлалын хүрээлэн (хуучнаар [Өвөр Монголын тэмээ судлалын хүрээлэн](#))-тэй гэрээлэн, ингэний сүүн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх, тэр дундаа БНХАУ-ын зах зээлд хэрхэн нийлүүлэх талаар цогц судалгаа хийх ажлыг эхлүүлсэн. Судалгаагаар ингэний сүүний эрэлт, нийлүүлэлтийн судлах, Хятадын зах зээлийн тухай дүн шинжилгээ хийж, монгол ингэний сүүнд суурилсан бүтээгдэхүүний чадавхыг судлах юм. Судалгааны тайлан нь экспортод чиглэсэн ингэний сүүн бүтээгдэхүүний бизнесийн стратегийг илүү нарийн бөгөөд оновчтой тодорхойлоход ТЭСО-д туслах юм.

Ингэний сүүний олон улсын зөвлөхийн дэмжлэгтэйгээр 2022 оны 9-р сард ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээнд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон. Бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах чанарын хяналтын систем бүхий нэмүү өртгийн сүлжээний үе шат бүрийг сайжруулах/сайжруулалт хийх арга хэмжээний төлөвлөгөөний хамт бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаар санал, дүгнэлт өгч, сүү үйлдвэрлэгчдийн хоршоог байгуулах, удирдан зохион байгуулах талаар олон улсын шилдэг туршлага дээр үндэслэсэн зөвлөмж өгсөн. Сайжруулах тодорхой чиглэлүүд нь:

- Тогтвортой, эрүүл, аюулгүй сүү үйлдвэрлэх зорилгоор саалийн тэмээний олон улсын технологи стандартын шаардлага хангасан, ингэний сүү үйлдвэрлэгчдийн хоршооны дэргэдэх хагас эрчимжсэн эко ферм байгуулах.
- Хагас эрчимжсэн тэмээний аж ахуйд хоршоо/малчдыг сургах багц сургалтын модультай байх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Хагас эрчимжсэн аж ахуй нь тэмээчин нүүдэлчдийн хувьд шинэ туршлага болох тул сургалтыг хийх нь зүйтэй. Сургалтад ингэний фермийн нөхцөлд хэрхэн яаж идэш тэжээлийг өгөх, сүүг саах, саасан сүүг хэрхэн хадгалах, боловсруулах зэрэг багтана. Гол зорилго нь эрүүл ингэнээс чанартай сүү саана гэсэн уриа байгаа юм.
- Ингэний сүүг олон улсын зах зээлд таниулах, сурталчлах
- ТЕСО групп нь Ойрх Дорнод болон дэлхийн бүсэд улс орнуудад зохиогддог төрөл бүрийн хүнстэй холбоотой, соёлын наадамд оролцох боломжтойг олон улсын зөвлөх холбох гүүр болох боломжтойг дурдсан. Эр-Рияд хотод болох Хаан Абдул Азиз тэмээний наадам 2022 оны сүүлээр зохион байгуулагдах бөгөөд, олон улсдаа хамгийн цар хүрээтэйд тооцогддог том фестиваль юм.
- Орлогыг төрөлжүүлэх буюу орлогын эх үүсвэрийн сүвгийг нэмэгдүүлэх нь тэмээчдэд ихээхэн тус дэмжлэг болох юм. Энэ зорилгоор торомны ноос, тэмээн поло болон тэмээ унах нь аялал

жуулчлалын салбарт, тэмээний гаралтай уламжлалт бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг нь хамгийн оновчтой байх болно.

- Цаг агаарын хүнд нөхцөлд аж ахуй эрхлэгч нарт төрөөс хөнгөлөлттэй тэжээл олгох, нэг литр сүүний үйлдвэрлэлд татаас олгох, бэлчээрийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх нь элсэн цөлд тэмээний аж ахуйг тогтвортой авч явахад томоохон дэмжлэг болно. Тэмээ бол ард түмний амьжиргаанд зайлшгүй хэрэгтэй таван хошуу малын нэг төдийгүй говь цөлийн тэнцвэртэй байдлыг хадгалах, экологийн эрүүл байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Ингэний сүүг эрүүл ахуйн шаардлага хангаж, зохистой горимын дагуу саах, хадгалах, тээвэрлэх зэрэг чиглэлээр 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй багт Сургагч багшийн сургалт явуулах. Тэмээчин, саальчдад эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын талаар богино хэмжээний сургалт явуулах шаардлагатай гэж үзсэн. Энэ нь тэмээчний мэргэжил Монголын хөдөлмөрийн зах зээлд үнэлэгдэхэд нөлөөлөх чухал ажил болох юм.

Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ТХХТ-ийн загварыг ХХААХҮЯ болон ингэний сүүний олон улсын шинжээч өндрөөр үнэлж, ХАА-н хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах аргачлалыг гаргав. Завханы улаан саримс, ясны шөл, адууны мах, луувангийн шүүс, хонины мах, хонины лаазалсан буюу нөөшилсөн мах, хатаасан цус, гэдэс дотор бүтээгдэхүүн зэрэг боломжит экспортод чиглэсэн бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийсэн. Судалгааны дүнд ХАА-н бүтээгдэхүүн, ялангуяа малын өвчин тархалт нь, малын болон хүнсний хэрэглээний эрүүл ахуйн стандартууд, олон улсын стандартад нийцэхэд бэрх байгаа нь мах, махан бүтээгдэхүүнийг энэхүү төслийн хугацаанд экспортлох боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Хятад болон бусад орнуудаас олон төрлийн хүнсний ногоо импортоор авдгийг харгалзан дотоодын зах зээлд чанартай, экологид ээлтэй бүтээгдэхүүн нийлүүлэхэд Төсөл анхаарлаа хандуулж ажиллаж байна.

Цалуут ХХК-д хатаасан цусыг уургын нэмэгдэл болгон тахианы тэжээлд ашиглаж байна. Энэхүү экологид ээлтэй, хаягдалгүй бүтээгдэхүүн нь дотоодын үйлдвэрлэл, хангамжийг хамгаалах, импортын хүнсний бүтээгдэхүүнийг орлох Ерөнхийлөгчийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” санаачилгад нийцэж байна.

“Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн сургагч нарыг сургах” сургалтыг Технологийн дээд сургуультай хамтран 2021 оны 12 дугаар сард зохион байгуулсан ба сургалтад сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, технологийн ажилтнууд, Төв, Завхан, Өвөрхангай, Ховд аймгийн сүү үйлдвэрлэлийн хоршоодын 20 төлөөлөгч (13 эмэгтэй, 7 эрэгтэй) оролцов. Сургалтын зорилго нь түүхий эд, хүнсний үйлдвэрлэл, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, үйлдвэрлэл боловсруулалтын дэглэм, стандарт зөрчигдөх өндөр магадлалтай хөдөө орон нутагт сүүн бүтээгдэхүүний жижиг үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэхэд оршсон. Сургалтад оролцогчид ХАА-н зохистой дадал (GAP), Эрүүл ахуйн зохистой дадал (GHP), Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) зэргийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний аюулгүй байдал, стандартад нийцсэн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хангаж, ааруул, цөцгийн тос, зөөхий үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах практик туршлага судлах, бизнес болон санхүүгийн хөгжлийн загвар боловсруулах практикийг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан.

С.4.1.2 Шаардлагатай үр чадварын хэрэгцээг тодорхойлж, загварчлах, залуучуудад чиглэсэн дунд болон урт хугацааны үр чадварын сургалт явуулах

Эрдэнэ сумын МСҮТ-ийн “Мал төхөөрөх ажилтан”, Баянчандмань Политехник коллежийн “ХАА-н машин механизмын оператор, засварчин” богино хугацааны сургалтын хоёр хөтөлбөрийг сургуулиудын хамтын ажиллагаа бүхий ажил олгогч байгууллагын төлөөлөл, туршлагатай ажилчдын оролцоотойгоор сургалтын хөтөлбөр боловсруулах (DACUM) аргачлалыг ашиглан амжилттай боловсруулж, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөр батлуулсан.

Ур чадварт суурилсан сургалтын “Мал төхөөрөх ажилтан” хөтөлбөр нь Монголд анхных нь бөгөөд хүнсний аюулгүй байдлын стандартыг хангасан, махан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах улмаар залуучуудын хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх боломжийг олгосон сургалт юм. Энэ нь гадаадын зах зээлд арьс ширний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг дэмжих арга хэмжээ болсон.

Ур чадварт суурилсан мэргэжлийн хоёр хөтөлбөрийн (Мал төхөөрөх ажилтан болон ХАА-н машин механизмын оператор, засварчин) хувьд дараах чадамжийн нэгжүүдийг тодорхойлсон, үүнд:

“Мал төхөөрөх ажилтан” сургалтын хөтөлбөрт: ажлын байранд малын үс засалт, мал нядлах, мах хөргөх, мах бэлтгэх, гэдэс цэвэрлэх, болон үндсэн үр чадварууд.

“ХАА-н машин механизмын оператор, засварчин” сургалтын хөтөлбөрт: Ажлын байранд хөдөө аж ахуйн машин механизмыг ажилд бэлтгэх, машин механизм жолоодох, машин механизмын засвар үйлчилгээ, үндсэн үр чадварууд тус тус багтсан.

2022 оны 6 дугаар сард түршилтын семинарыг зохион байгуулж богино хугацааны мэргэжлийн сургалтын мэргэжлийн жагсаалт, индексийг тодорхойлсон. Сургалтад ХХААХҮЯ, ХНХЯ, Нийслэлийн Хүнс, ХАА-н газар, МСҮТ-н зөвлөл, Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль 13 салбарын 30 төлөөлөгч оролцсон. Хүнс, ХАА, хөргөгчийн салбарын ажил мэргэжлийг олон улсын стандарт, ангилалд нийцүүлэн шинэчилснээр хүнс, хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээн дахь ажилчдын үр чадварын хөгжил, богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлнэ.

Хоёр шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гүний цэвэр усны худаг өрөмдлөг, хөлдөөгч, хөргөгчийн өрөөний суурилуулалт, болон сургалтын симмулятор тоног төхөөрөмжийн багцыг хүлээлгэн өгч тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.

2022 оны 8 сард Эрдэнэ МСҮТ болон орон нутгийн сум дундын хоршоотой Хамтран ажиллах санамж бичиг зурж, 2022 онд нийт 27 оюутан сургаж, мах боловсруулах цехэд ажиллуулах тохиролцоо хийгдсэн. Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн стратеги төлөвлөлттэй уялдуулан энэхүү санаачилга гаргасан Эрдэнэ МСҮТ-ийг Эрдэнэ сумын удирдлагын зүгээс өндрөөр үнэлсэн. Энэхүү ТХХТ-ийн үр дүнд Эрдэнэ МСҮТ орон нутгийн махны үйлдвэрүүдтэй хамтран ажиллах, сургалтын орчныг сайжруулахад 80 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Махны нэмүү өртгийн сүлжээний хувьд хатаасан цусан бүтээгдэхүүний боловсруулалтыг “Мал төхөөрөх ажилтан” богино хугацааны сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломжтой. Эрдэнэ МСҮТ-ийн мал нядалгааны цех нь малчдын хоршоодтой хамтран ажиллаж, уламжлалт бус нядалгааны аргаар бэлтгэсэн чанартай махыг мах боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх юм.

С.4.1.3. Агро бизнест хувиараа хөдөлмөр эрхлэх инновацад суурилсан сүлжээ /платформыг дэмжих

Инновац бол Инновацыг шинэ арга барилыг нэвтрүүлэх, шинэ нэмүү өртгийг бий болгох үр өгөөжтэй санал санаачилгыг бий болгох үйл явц гэж үзэж болно. Үүнийг нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын чадавх бэхжүүлэх чадавхыг дээшлүүлэх хоёр арга зам (техникийн болон технологийн) хэмээн тодорхойлж, төслийн хэрэгжилтэд ашиглаж байна.

Техникийн инновацын хувьд төслийн хүрээнд ингэний сүү үйлдвэрлэгчдийн хоршоо байгуулан үйлдвэрлэлийн тогтвортой байдал, ханган нийлүүлэгчдийн тогтвортой бизнесийг хангах замаар ингэний сүү нийлүүлэх сүлжээг сайжруулсан. Тус чиглэлээр төсөл дараах үр дүнд хүрсэн, үүнд:

- Ингэний сүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг хамтран хэрэгжүүлэх бизнесийн боломжийг хөгжүүлэх талаар хоршооны гишүүд, малчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн
- Хоршооны шийдвэр гаргах үйл явц, менежмент, хоршооны засаглал, бизнесийн хөгжлийг сайжруулсан
- Бизнесийн стратеги, санхүүгийн менежмент, бизнесийн үйл ажиллагаа болон гишүүдийн ашгийг нэмэгдүүлэх хүрээнд тогтвортой бизнесийг эрчимжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Технологийн инновацын хувьд, блокчэйн ухаалаг технологи нь Төслийн дэмжлэгтэйгээр хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор тэмээний сүү нийлүүлэлтийн сүлжээн дэх мэдээллийг хянах боломжийг олгодог системийг хувийн хэвшлийн түншийг нэвтрүүлэхэд тусламж үзүүлсэн. Технологийн инновацын хувьд, Төслийн дэмжлэгтэйгээр хувийн хэвшлийн түншийн нэвтрүүлсэн блокчэйн ухаалаг технологи нь хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор тэмээний сүү нийлүүлэлтийн сүлжээн дэх мэдээллийг хянах боломжийг олгодог.

Цаашилбал, төсөл нь эдийн засгийн өсөлт, орон нутгийн хөгжил, ажлын байрыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг нэвтрүүлэх зорилгоор "Агри-пренер" (Хөдөө аж ахуй дахь бизнес эрхлэлт) сэдэвт уралдаан зарлаж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төслийн зүгээс одоогийн газар тариалан эрхлэгчдийг тодорхойлох, олон нийт, ялангуяа залуучууд, тусгай хэрэгцээт бүлгийн иргэдийг хөдөө аж ахуй эрхлэх боломжит хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн боломж болгон хөгжүүлэх зорилготой юм.

С.4.2 Агробизнес эрхлэгчид ХАА-н өртгийн сүлжээнд ахин дэвшихийг дэмжсэн бүтэц, зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг дэмжинэ

Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
С.4.2 Агробизнес эрхлэгчид ХАА-н өртгийн сүлжээнд ахин дэвшихийг дэмжсэн бүтэц, зохион байгуулалтын болон техникийн шинэчлэлийг дэмжинэ	С.4.2.1 Хоёроос доошгүй тооны шинэ агро-бүтээгдэхүүн сонгож бойжуулан хөгжүүлж, сурталчлах	0	Зохион байгуулалтын загвар	Хугацаандаа хэрэгжиж байна: Нэг загвар туршсан
	С.4.2.2 Яамдын ердийн төсвийн хүрээнд өргөжүүлэх	0	1-ээс дээш бүтээгдэхүүнийг ХХААХҮЯ-ны төлөвлөгөөнд тусгана	2023 онд шилжих төлөвтэй байна

С.4.3 Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц, үндэсний болон олон улсын чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ

Төслийн дэд зорилтот оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
С.4.3 Үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц, үндэсний болон олон улсын чанар, аюулгүйн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүний үндэсний брэндүүд бий болгохыг дэмжинэ	С.4.3.1 Брэнд болох боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлох	0	2 шинэ бүтээгдэхүүн	Хугацаандаа хэрэгжиж байна: Эхний бүтээгдэхүүн нь Монгол хоёр бөхт ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн, хуурай сүүн бүтээгдэхүүн гэж тодорхойлогдсон. Ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээний суурь судалгааг Тэмээний сүүний үндэсний зөвлөх боловсруулсан. ӨМӨЗО-ны Хятад- Казакстаны тэмээ судлалын хүрээлэн (хуучнаар Өвөр Монголын тэмээ судлалын хүрээлэн)-тэй гэрээлэн, ингэний сүүн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх, тэр дундаа БНХАУ-ын зах

				зээлд хэрхэн нийлүүлэх талаар цогц судалгаа хийх ажлыг эхлүүлсэн.
--	--	--	--	---

С.4.4. Агробизнес суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, сорилт бэрхшээлийг тодорхойлж туршина

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Сүүр үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
С.4.4. Агробизнес суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, сорилт бэрхшээлийг тодорхойлж туршина	С.4.4.1 С4.1-4.3-д дүн шинжилгээ хийх	0	Дүн шинжилгээ, хяналт	2023 онд шилжих төлөвтэй байна
	С.4.4.2 Үндэсний хэмжээний семинар зохион байгуулах			
	С.4.4.3 Дээд түвшинд семинар зохион байгуулах			

Төсөл 4.1-4.3-ын үр дүнг хэрэгжүүлэхэд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг арга хэмжээний туршлага, сургамжид тулгуурлан боловсруулахад анхаарах шаардлагатай байна. Хэрэгжилт тодорхой түвшинд удаашралтай байгаа тул хэрэгжилтийн үр дүн 2023 онд шилжих төлөвтэй байна.

С.4.5 Хүнсний бус салбарын (савхи, мяндас) үйлдвэрлэлийн загварчилсан сургалтыг зохиож, турших

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Сүүр үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
С.4.5 Хүнсний бус салбарын (савхи, мяндас) үйлдвэрлэлийн жишиг сургалтыг зохион байгуулж, турших	С.4.5.1 Үйлдвэрлэл болон мэргэжлийн холбоотой хамтран сургалтын хөтөлбөр боловсруулж, 1-ээс олон туршилтын сургалт хийх	0	Жишиг сургалтын төвийн дизайн боловсруулна	Хугацаандаа хэрэгжиж байна. Судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд 2022 оны 12-р сард жишиг төвийн загварыг санал болгоно

Савхи, мяндас үйлдвэрлэлийн үр чадварын хэрэгцээ, ажиллах хүчний эрэлтийн судалгааг хийж байгаа.

Гарч буй хүндрэлүүд: Яамны чиг үүрэг, хамтрагч яамдын шууд харьцаж ажилладаг удирдах албан тушаалтнуудын өөрчлөлт. Яамны бүрэн эрх, хамтрагч яамнуудын манлайллын өөрчлөлт. Мэргэжлийн боловсролын салбарыг 2022 оны 1 дүгээр сард ХНХЯ-аас БШУЯ-нд шилжүүлсэн бөгөөд Мэргэжлийн боловсролын газрын дарга томилогдох хугацаа удааширсан. Үйлчлүүлэгч нартай холбогдож, тэдний хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөөг нь боловсруулахад хамтран ажиллах нь томоохон сорилт байв. Ажилгүй хэмээн бүртгэгдсэн олон иргэн албан бус хөдөлмөр эрхэлдэг тул үйлчлүүлэгчийн төрөл, тэдний нөхцөл байдлыг сайтар судалж, ойлгох нь чухал юм. Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын үнэлгээ хийх үйлчилгээ нь ХЭДС-гийн санхүүжилт олгохын өмнө зайлшгүй гүйцэтгэхийг шаарддаг нэгэн хийсвэр арга хэмжээ хэмээн зарим иргэд ойлгодог. Эдгээр бэрхшээл, сорилтыг даван туулахад нөлөөллийн ажил, мэдээлэл сурталчилгааны зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ D. ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ (ОУХБ)

Бүрэлдэхүүн хэсэг D-г ОУХБ хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ бүрэлдэхүүн хэсэгт дараах үндсэн зорилтод хүрэхээр ажиллаж байна. Үүнд:

D.1 Хууль эрх зүйн орчныг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх

D.2 Хөдөлмөрийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах

D.1.1. ОУХБ-ын “Хөдөлмөрийн хяналтын тухай” 1947 оны 81 дүгээр конвенц, ОУХБ-ын “Хөдөлмөрийн хяналтын тухай (хөдөө аж ахуй)” 1969 оны 129 дүгээр конвенцыг тус тус соёрхон батлах, ОУХБ-ын суурь конвенцууд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенцуудыг үр дүнтэй нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
Дэд зорилт D.1.1. ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81 дүгээр конвенц, ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын тухай (хөдөө аж ахуй) 1969 оны 129 дүгээр конвенцыг тус тус соёрхон батлах, ОУХБ-ын суурь конвенцууд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой конвенцуудыг үр дүнтэй нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	D.1.1.1 Боловсруулсан бодлогын эсвэл техникийн бичиг баримтын тоо	0	1 үнэлгээ	Хугацаандаа хэрэгжиж байна: “Хөдөлмөрийн хяналтын ерөнхий зарчмын шинэ удирдамж”-ийг орчуулсан

Дээрх хоёр конвенцыг соёрхон батлах бэлтгэл ажил явагдаж, ХНХЯ-наас холбогдох багц баримт бичгийг бэлтгэж байна. Төслөөс хэрэгжүүлсэн нөлөөллийн үйл ажиллагаа болон ОУХБ-ын Монгол, Хятадыг хариуцсан захирал, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хооронд 2022 оны 9 дүгээр сард хийсэн уулзалтын дүнд ХНХЯ-наас үзэл баримтлалын шинэ танилцуулга, үндэсний хууль тогтоомжууд хоёр конвенцтой хэрхэн нийцэж байгаа талаарх хуулийн харьцуулалтын судалгаа зэрэг баримт бичгийг бэлтгэж байна.

ОУХБ-ын “Хөдөлмөрийн хяналтын ерөнхий зарчмын шинэ удирдамж” (ОУХБ, 2022 он)-ийг орчуулж нийтийн хүртээл болгосон. Энэхүү удирдамж нь гурван талт байгууллагуудын ОУХБ-ын хөдөлмөрийн хяналтын талаарх ойлголтыг дээшлүүлж, улмаар ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцыг соёрхон батлах явцад дэмжлэг үзүүлнэ.

D.1.2. Хөдөлмөрийн хяналтын хууль эрх зүйн орчин, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зөвлөмж боловсруулах.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
Дэд зорилт D.1.2: Хөдөлмөрийн хяналтын хууль эрх зүйн орчин, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зөвлөмж боловсруулах	D.1.2.1 ОУХБ-аас өгсөн хуулийн зөвлөмжийн тоо	0	1	Хугацаандаа хэрэгжиж байна. “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд ОУХБ-аас техникийн санал, зөвлөмж өгсөн.

Төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ОУХБ-аас техникийн санал, зөвлөмжийг өгсөн. Тус техникийн зөвлөмжид: (i) урьдчилан мэдэгдэлгүй хяналт, шалгалт хийх, (ii) зөвхөн төр хяналт, шалгалтыг хийх, (iii) хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа болон давтамжийн асуудлыг онцолсон.

ОУХБ-с НҮБХХ-тэй хамтран “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийн шинэчилсэн төсөлд техникийн зөвлөмж өгч ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 1 дүгээр улиралд энэ ажил дуусахаар төлөвлөгдсөн.

D.1.3. Олон улсын хөдөлмөрийн стандартуудыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан Дэд хорооноос олон улсын хөдөлмөрийн стандарт болон Монгол Улсын хүлээх үүргийн талаар судалж, хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлсэн.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
Дэд зорилт D.1.3. Олон улсын хөдөлмөрийн стандартуудыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан Дэд хорооноос олон улсын хөдөлмөрийн стандарт болон Монгол Улсын хүлээх үүргийн талаар судалж, хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлсэн	D 1.3.1 Монгол хэлнээ орчуулсан ОУХБ-ын конвенцыг хянан засварласан тоо	0	1	0
	D 1.3.2 Олон улсын хөдөлмөрийн стандартуудыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан Дэд хорооноос өгсөн зөвлөмжийн тоо	0	1	Хугацаандаа хэрэгжиж байна. Засгийн газрын тайланг бэлтгэхэд зориулж техникийн 1 зөвлөмж хүргүүлсэн

ОУХБ-ын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 1988 оны 167 дугаар конвенцын хэрэгжилтийн тайланг ХНХЯ-ны Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт Дэд хороо төслийн дэмжлэгтэйгээр 2022 онд бэлтгэсэн. 167 дугаар конвенцын хэрэгжилтийг тайлагналтын сургалтыг ОУХБ-ын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр 2022 оны 5 дугаар сард зохион байгуулж, түүнд 24 хүнийг хамруулсан (13 нь эмэгтэйчүүд). Тус сургалтын зорилго нь шинээр нэгдэн орсон ОУХБ-ын 167-р конвенцыг ХНХЯ болон дэд хорооны гишүүдэд ойлгуулах, энэ онд боловсруулах хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн.

Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх дэд хороог яамны бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан хэд хэдэн удаа өөрчилсөн ба 2022 онд тус дэд хороог шинэчлэн байгуулахаар төлөвлөж байна. Дэд хороо шинээр бүрдсэн нөхцөлд Төсөл нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зөвлөмж боловсруулах асуудлаар дэмжлэг үзүүлнэ.

Түүнчлэн төслөөс дэд хороог чадавхжуулах, техникийн чадавхыг нэмэгдүүлэх, мөн хөдөлмөрийн хяналт, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр олон улсын хэм хэмжээ, Монгол Улсын нэгдэн орсон конвенцуудын хэрэгжилтийн тайлагналттай холбогдсон хөдөлмөр болон хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

D.1.4. Хууль эрх зүйн актууд, тэдгээрийн хэрэгжилтэд судалгаа хийж, хэрэгжилтийн явцад гарсан анхаарах шаардлагатай асуудлыг тодорхойлон, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох арга замыг боловсруулна.

Төсөл Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран 2023 онд¹³ ОУХБ-ын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 155, 187 дугаар конвенцын хэрэгжилтэд судалгаа хийхээр төлөвлөж байна. Тус хоёр конвенцыг 2022 онд ОУХБ-ын суурь конвенцын тоонд шинээр нэмж оруулсан.

Энэхүү гарах үр дүнгийн хүрээнд Засгийн газраас өгсөн арга хэмжээний зөвлөмжийг дэмжиж, хувийн хэвшилд зохистой хөдөлмөрийн нөхцөл байдлыг үнэлэх замаар ОУХБ-аас Хүний эрхийн Үндэсний комисст техникийн туслалцаа дэмжлэгийг үзүүлж ажиллана. Түүнчлэн ОУХБ-аас Үндэсний статистикийн хороонд Монгол Улс дах Тогтвортой хөгжлийн зорилгын чиг хандлага, түүний дотор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эдийн засгийн хямралаас үүдэлтэй сорилт, боломжуудыг үнэлэх, хүүхдийн хөдөлмөрийн судалгааг үндэсний түвшинд явуулахад туслах болно.

D.1.5. Хөдөлмөрийн суурь зарчим, ажлын байран дах хүний эрх, зохистой хөдөлмөрийн нөхцөл, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хөдөлмөрт шилжүүлэх, хамтын гэрээ, хэлэлцээрийн асуудлаар МАОЭНХ болон МҮЭХ-ноос нөлөөлөл, сурталчилгааны ажлыг үр дүнтэй хийхэд дэмжлэг үзүүлнэ.

“Аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчид хөдөлмөрийн хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар өөрсдийгөө үнэлэх хяналт шинжилгээний хэрэгслийг МАОЭНХ-ноос төслийн дэмжлэгтэйгээр боловсруулж байна. Түүнчлэн үйлдвэрлэлийн ослыг бууруулах, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр ажил олгогчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ОУХБ-аас боловсруулж, ажил олгогчдод зориулан гаргасан “Хөдөлмөрийн хяналт: хөдөлмөрийн хяналт гэж юу вэ, хяналтыг хэрхэн явуулдаг вэ” сэдэвт гарын авлагыг МАОЭНХ-ноос орчуулсан. Энэ хүрээнд МАОЭНХ нь 300 орчим ажил олгогч, мэргэжлийн холбоодод ХАБЭА болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаарх хэд хэдэн сургалтыг 2022 онд багтаан зохион байгуулж байна.

МҮЭХ-ноос ХАБЭА, Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуулийн хэрэгжилтийн явц барилга, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүчний салбарт ямар байгааг тандаж, хяналтын үйл ажиллагааг явуулаа. Тус хяналтын үйл ажиллагааны үр дүн, саналыг нэгтгэн мэдээлэл, судалгаанд суурилсан шийдвэр гаргалтад туслах үүднээс МХЕГ болон ХНХЯ-нд хүргүүлнэ. Дэд зорилт 2.1.1-тэй холбогдсон чадавх бэхжүүлэх сургалтыг барилга, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүчний салбарт МХЕГ-тай хамтран 2022 онд багтаан явуулах бөгөөд сургалтад тус салбаруудын ажилтнууд, Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнууд, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчид хамрагдана.

ОУХБ-аас ХНХЯ, МАОЭНХ болон МҮЭХ-той хамтарсан үйл ажиллагаандаа зохистой хөдөлмөрийн гол асуудлыг сонгон анхаарлаа төвлөрүүлж, гурван талт хамтын ажиллагааг сайжруулах бодит хэрэгсэл, арга барилыг боловсруулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрхийн хамгааллын чиглэлээр ажлын байрны хамтын ажиллагааны удирдамж өгч, салбарын болон ажлын байрны жендерийн онцлогийг харгалзан 2022, 2023 онд хамтын гэрээ, хэлэлцээрийн талаарх гарын авлага, материалыг шинэчлэх, гишүүддээ зориулсан сургалтыг зохион байгуулахад хамтран ажиллана.

¹³ Монгол Улс ОУХБ-ын 155 дугаар конвенцод нэгдсэн орсон, харин 187 дугаар конвенцод хараахан нэгдэж ороогүй байна.

D.1.6. Мэргэжлийн бүлгүүд, Зохистой хөдөлмөрийн төлөөх Монголын залуучуудын сүлжээ (DWYN)-ний залуучуудад хөдөлмөрлөх эрхийг нь эдлүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох зэрэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
D.1.6: Мэргэжлийн бүлгүүд, Зохистой хөдөлмөрийн төлөөх Монголын залуучуудын сүлжээ (DWYN)-ний залуучуудад хөдөлмөрлөх эрхийг нь эдлүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох зэрэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.	D.1.6.1 Зохистой хөдөлмөр, дагаж мөрдөх дүрэм журмыг сурталчлах кампанит ажлын тоо	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Залуучуудын хөдөлмөрлөх эрхийн талаар 1 аян зохион байгуулсан.

Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ (ЗЗХС), түүний гишүүн байгууллагууд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын хуульчдын холбоо, НҮБ-ын Залуучуудын зөвлөх хороотой хамтран 2021 онд хэрэгжүүлсэн хөдөлмөрлөх эрх болон Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуулийн талаар мэдээлэл сурталчилгааны аяныг нийгмийн сүлжээгээр өрнүүлсэн нь нийт 419,000 хүнд хүрсэн. Үүнээс гадна зохистой хөдөлмөр, хөдөлмөрлөх эрхийн талаар албан ба албан бус салбарт ажил хөдөлмөр эрхэлдэг 1000 гаруй залуучуудад сургалт зохион байгуулсан.

ЗЗХС нь 2022 онд барилга, үйлчилгээ, ноос ноолуурын салбарын залуучуудын дунд Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрлөх эрхийн ойлголтыг нэмэгдүүлэхэд гол үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирлээ. ЗЗХС-нээс ОУХБ-тай байгуулсан хамтын ажиллагааны шинэ гэрээний хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуульд заасан залуучуудын хөдөлмөрлөх эрхтэй холбоотой судалгааг барилга, сүлжмэл, үйлчилгээний салбаруудад цахим болон биечлэн уулзаж ярилцах хэлбэрээр явуулав.
- Залуучууд (15-34 насны) болон сүлжмэл, барилга, үйлчилгээ гэсэн сонгогдсон 3 салбарт ажил хөдөлмөр эрхэлдэг залуучуудад зориулан нийт 15 зурагт хуудас бэлтгэсэн.
- 2022 оны 9 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 15-ны хооронд хөдөлмөрлөх эрхийн талаар цахим аяныг зохион байгуулсан.
- Сонгогдсон дээрх 3 салбарын 100 залуучуудад хөдөлмөрлөх эрхийн талаарх сургалтыг танхимаар зохион байгуулсан.
- ЗЗХС-ний гишүүн байгууллагуудын дунд тэдний эрхэм зорилго, алсын хараа, стратегийн зорилго, зорилтуудыг дахин тодорхойлох, гишүүдийнхээ эрэлт, хэрэгцээ ялангуяа залуучуудын хөдөлмөрлөх эрх, ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх семинарыг зохион байгуулав.

D.2.1. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Төслийн дэд зорилтод оруулсан хувь нэмэр

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
D.2.1: Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.	D.2.1.1 Жил бүр хэрэгжүүлсэн СHT-ний тоо	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. Сонгогдсон 4 салбарыг 2022 оны СТ-д оруулсан.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих стратегийн төлөвлөлт (СТ) нь ОУХБ-ын аргачлал бөгөөд энэ нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сахиулдаг байгууллагуудыг уламжлалт арга ажиллагааны сул тал, хязгаарлалтыг даван гарч, хамгийн чухал ач холбогдолтой салбарт хяналт хийх, урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвхтэй ажиллах арга барилд чиглүүлэх үйл ажиллагааны стратеги юм. Гол зорилго нь мэдээ, мэдээлэл цуглуулан, асуудлын учир шалтгаанд дүн шинжилгээ хийж, нийгмийн түншлэгчид болох ажил олгогч болон ажилчдын төлөөллийн байгууллагуудтай стратегийн түншлэл бий болгож, тэдний тэнцвэртэй оролцоог хангасан үйл ажиллагааг төлөвлөх замаар хөдөлмөрийн хяналтын хязгаарлагдмал нөөцийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэдэг.

Одоогоор стратегийн төлөвлөлтийн аргачлалыг МХЕГ-т хөдөлмөрийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэхээр нэвтрүүлж байна. 2021 оны 11 дүгээр сард зохион байгуулсан сургалт, семинарын үеэр МХЕГ-аас 4 салбар (уул уурхай, барилга, ноос ноолуур/хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүчний жижиг үйлдвэрлэгч)-ыг нэн тэргүүнд анхаарах салбар гэж тодорхойлж, холбогдох үйл ажиллагааг төлөвлөн эдгээр үйл ажиллагааг МХЕГ-ын 2022 оны хөдөлмөрийн хяналтын чиглэлээр явуулах жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан. Түүнчлэн 2022 оны 5 дугаар сард төслийн дэмжлэгтэйгээр МХЕГ болон нийгмийн түншлэгчидтэй хамтран зохион байгуулсан гурван талт хэлэлцүүлэг дараа МАОЭНХ, МҮЭХ-ноос СТ-ын аргачлалаар сонгосон тэргүүлэх салбаруудад хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөсөн. Энэ хүрээнд нийт 3 аймаг (Дорнод, Баянхонгор, Өмнөговь), Улаанбаатар хотын 4 салбарын 400 орчим ажил олгогч болон ажилтнуудад хөдөлмөрийн хууль тогтоомжийн сургалтыг хийсэн. СТ-ийн порталд СТ-ийн хүрээнд төлөвлөсөн, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг оруулж, мониторинг хийхэд ашиглах болно.

Төслөөс жил бүр техникийн туслалцаа үзүүлж ажиллах бөгөөд өмнөх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэслэн, жил бүрийн СHT-г цаашдын төлөвлөлтөд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

D.2.3 МХЕГ-ын хяналт шалгалтын мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо баримт цуглуулж буй өнөөгийн тогтолцоог сайжруулах зөвлөмж боловсруулна.

Дээрх дэд зорилтууд 2021 онд үндсэндээ хангагдсан. Төслийн дэмжлэгтэй явуулсан мэдээ мэдээлэл цуглуулах ажлын судалгаа, олон улсын сайн жишээг танилцуулсан цахим үүлзалтууд (вэбинар)-ыг үндэслэн МХЕГ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо баримт цуглуулж, бүртгэлжүүлдэг өнөөгийн цахим бүртгэлийн системийн сул талуудыг тогтоосон. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа дижитал шилжилтийн хүрээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн системийг шинэчлэхэд (<http://om.inspection.gov.mn/>) дэмжлэг үзүүлсэн. Шинэчлэгдсэн энэ бүртгэлийн систем Засгийн газрын бусад мэдээллийн бааз (жишээ нь: e-hyanalt.mn гм)-уудтай холбогдсон байгаа нь МХЕГ-т үйлдвэрлэлийн осолтой холбоотой мэдээ мэдээллээ бүртгэж, илүү үр дүнтэй тайлагнах боломж олгож байна.

D.2.4: Ажлын байран дах хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар сургалтын хөтөлбөр боловсруулж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийн үйл ажиллагаатай уялдуулан, улс, аймаг, сумын түвшний нийгмийн даатгал, эрүүл ахуй, хөдөлмөрийн хяналтын албадыг хамруулна (аймагт 4 удаа, Улаанбаатарт 2 удаа).

Төслийн үр дүнд хүрэх явц

Дэд зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	2022 оны зорилт	2022 оны хэрэгжилт
D.2.4 Ажлын байран дах хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар сургалтын хөтөлбөр боловсруулж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийн үйл ажиллагаатай уялдуулан, улс, аймаг, сумын түвшний нийгмийн даатгал, эрүүл ахуй, хөдөлмөрийн хяналтын албадыг хамруулан хэрэгжүүлнэ (аймагт 4 удаа, Улаанбаатарт 2 удаа)	D.2.4.1 Хөдөлмөр эрхлэлтийг дагаж мөрдөх, албан ёсны болгоход чиглэсэн нэгдсэн үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй бэрхшээл, сайн туршлагыг тодорхойлсон үнэлгээний тайлангийн тоо	0	1	Хугацаандаа хэрэгжиж байгаа. 1 сургалт хийсэн.

Хөдөлмөрийн байцаагчдын ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай нэн чухал мэдлэг, үр чадварыг тодорхойлсон сургалтын хэрэгцээний үнэлгээ болон хөдөлмөрийн хяналт шалгалтын тогтолцооны үндэсний бодлогын зорилго, зорилтыг үндэслэн хөдөлмөрийн байцаагчдын чадамж хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байна. Энэ хүрээнд 80 орчим хөдөлмөрийн байцаагчийг 2021 оны 12 дугаар сард сургалтад хамруулснаас гадна Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвүүдийн сонгогдсон ажилтнуудыг оруулан ЗЗХС-ний 25 гишүүнийг залуучуудын хөдөлмөрлөх эрхийг дэмжих сургалтын чиглүүлэгч багшаар сургалаа.

Түүнчлэн 2022 оны 11 дүгээр сард залуучуудын хөдөлмөрлөх эрхийн асуудлаар 21 аймаг, 9 дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг сургаж, дэд зорилт D.1.6-гийн хүрээнд залуучуудад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны аяныг дэмжин ажиллаж ирлээ. ХНХЯ-ны удирдах түвшний 2 ажилтан 2022 оны 11 дүгээр сард болсон ОУХБ-ын хөдөлмөрийн хяналтын ерөнхий зарчмын талаарх шинэ аргачлалын олон улсын хуралд оролцсон. Энэ нь ХНХЯ-нд хөдөлмөрийн хяналтыг бие даан явуулах ажлыг тогтмолжуулахад чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

4. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төсөл нь төсөв болон хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд оролцогч талуудтай бат бөх харилцаа, холбоо хамтын ажиллагааг бий болгосон.

Төслийн хамтрагч, оролцогч талуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох нэлээд олон уулзалт, хэлэлцүүлгийг 2022 онд зохион байгуулав. Төслийн гол хамтрагч байгууллагуудыг доор нэгтгэн оруулав.

Засгийн газрын хамтрагч байгууллагууд: төсвийн шинэчлэлийн хүрээнд СЯ, ЭЗХЯ, ХНХЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, ҮАГ, УИХ-ын Төсвийн байнгын хороо болон ТМБС, орон нутгийн засаг захиргааны Санхүү, хөрөнгө оруулалтын газруудтай хамтран ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ, экспортын бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлаар төсөл ХНХЯ, МХЕГ, ХХААХҮЯ, ХНХСИ, ЗДТГ-ууд, аймгийн Хөдөлмөр, хөдөө аж ахуйн газруудтай хамтран ажиллаж байна.

Орон нутгийн удирдлага, хоршоод: Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйн чиглэлээр 21 аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сургалтыг зохион байгууллаа. Баянчандмань суманд хоршоодыг дэмжих ажиллагаа эхний шатандаа үргэлжилж байна.

Хувийн хэвшил, үйлдвэрлэлийн холбоод: төсөл МАОЭНХ, МҮХАҮТ, МҮЭХ, ЗЗХС болон Монгол камел ХХК, ТЭСО ХХК, Мах Маркет ХХК, Сүү ХХК, КАЙТ Монголиа зэрэг байгууллагатай хамтран ажиллав.

Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд: 2022 оны ИНБ-ын гол түншүүд төсвийн хяналтын тэтгэлэгт хөтөлбөрт оролцогч ИНБ-ууд, залуучуудын холбоод, анхан шатны түвшинд эмзэг бүлгийн хүмүүстэй ажилладаг ИНБ-ууд, “Старт-ап Монголиа”, “Хөгжлийн шийдэл” ТББ байв.

Бусад төсөл, хөтөлбөр: ДБ, АХБ, ЖАЙКА, ЕХ, ГОУХАН-ийн санхүүжилтээр Монголд хөдөлмөр эрхлэлт, төсвийн шинэчлэл, хөдөлмөрлөх эрх, хөдөө аж ахуйн хөгжлийн чиглэлээр хэд хэдэн төсөл хөтөлбөр хэрэгждэг. Эдгээр төсөл, хөтөлбөр хооронд мэдээлэл солилцох уулзалт тогтмол зохиогддог нь хамтын ажиллагааны гол механизм байсаар ирсэн.

Төсөл **ЕХ-ны Монгол дахь Төлөөлөгчийн газартай** тогтмол мэдээ мэдээллээ харилцан солилцож, нягт хамтран ажиллаж ирлээ. ЕХ-ны Төлөөлөгчийн газраас санхүүжүүлж буй төслүүд нь төсөв санхүүгийн удирдлага, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр нягт хамтын ажиллагааг бий болгосон.

10 дугаар сард НҮБХХ, НҮБ-ын ХХААБ, ОУХБ нь хөтөлбөрт суурилсан төсөв, тайлагналын ахиц дэвшлийн талаар арга барилаа хуваалцаж, идэвхтэй яриа хэлэлцүүлэг өрнүүлдэг ЕХ-ны санхүүжилттэй ДБ-ны хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төсөл,

Каритас ТББ-ын хэрэгжүүлж буй "Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө" төслүүдтэй үзэл баримтлалаа хуваалцаж, хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлсон. ЕХ нь ОУХБ-ын үндсэн болон засаглалын конвенцуудыг соёрхон батлах, хэрэгжүүлэхийг тууштай дэмждэг.

Монгол улс ЕХ-ны тогтвортой хөгжил, сайн засаглал (EU GSP+)-ын төсөл хөтөлбөрүүдийн үр шим хүртэгчдийн нэг юм. ЕХ нь хөдөлмөрийн хяналтыг баталгаажуулах үүднээс ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцод нэгдэхэд ОУХБ, Монгол улстай гурван талт хэлэлцээрийг ихээхэн дэмждэг.

5. МЭДЭЭЛЭЛ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төслийн баримт бичигт тусгагдсан мэдээлэл харилцаа холбоо, олон нийттэй харилцах стратегийн хүрээнд төслийн оролцогч талууд болон олон нийтэд төслийн үр нөлөөг сурталчлан таниулах мэдээлэл харилцааны үйл ажиллагааг хэрэгжүүлж ирлээ. Энэ хугацаанд хэрэгжүүлсэн мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд, тэдгээрийн жагсаалт, нийтэд түгээсэн арга хэлбэр, видеоны холбоосыг **Хавсралт 5. Мэдээлэл харилцааны хяналт шинжилгээний хүснэгт-д** нэгтгэн оруулав.

- Төслийн мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийн үндсэн зорилго бол төслийн зорилтот бүлэгт төдийгүй үндэсний, орон нутгийн түвшинд олон нийтэд төслийн хүрээнд гарсан гол үр дүн, сайн практик жишээг хүргэхэд чиглэдэг. Төсөл нь олон талуудтай харилцан хамтран ажилладаг бөгөөд тэдгээрийг тоймлон бүлэгт ангилбал:
- Төрийн байгууллага, агентлаг
- Хөгжлийн хамтрагч байгууллагууд
- Үндэсний болон олон улсын компани, аж ахуй нэгж, хувийн хэвшил
- Иргэний нийгмийн байгууллага
- Хэвлэл мэдээлэл
- Олон нийт.

Олон нийтийг хамарсан онцлох арга хэмжээнүүд

Европын Өдөрлөг (жил бүр)-ийг 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Сүхбаатарын талбайд өргөн тэмдэглэсэн. Төслийн майхнаар нийт 300 орчим хүн зочилсон ба тэднээс нийгмийн сүлжээнд 100 гаруй иргэд #SDGBE #EuropeDay гэсэн үгийг ашиглан идэвхтэй оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь төслийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, мэдээлэх болон сурталчлахад томоохон боломжийг олгосон юм.



Зураг. Төслийн асарт. Төслийн баг ЕХ-ноос Монгол улсад суугаа элчин сайд хатагтай Аксель Никээийн хамт



Зураг. Төслийн гэрэл зургийн хэсэг

Монгол дахь Нэгдсэн үндэстний байгууллагаас санаачлан хэрэгжүүлсэн Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг олон нийтэд сурталчлан таниулах нээлттэй өдөрлөгийн хүрээнд төслөөс

“Хөдөлмөрийн яармаг” 2022 арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Энэхүү Хөдөлмөрийн яармагийн үеэр иргэдэд ойлгомжтой, хэрэгцээтэй үйлчилгээг хүргэх замаар Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих Тогтвортой хөгжлийн 8 дугаар зорилгыг таниулах болон ажил хайгч, ажилгүй иргэдэд зориулсан дараах 5 арга хэмжээний хэсгүүдийг санаачлан зохион байгуулав. Үүнд:

Ажилд орох үйл явцын симуляцийн хэсэг: ажил хайгчид эхлээд сонирхсон ажил мэргэжлээрээ өөрсдийн үр чадвараа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээ (профайлинг)-аар үнэлүүлж, тухайн бүртгэлийн дүнг үндэслэн ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг авч, дараа нь үр чадвараа хэрхэн дээшлүүлэх, өөрсдийн товч намтраа хэрхэн бичих, ажлын ярилцлагад хэрхэн амжилттай оролцох талаар зөвлөгөө авсан. Түүнчлэн хөдөлмөрийн яармагт хүрэлцэн ирсэн хүмүүст ажлын боломжийг нь нэмэгдүүлэхэд тустай байх загвар ярилцлага хийх боломж олгосон.

Ажилд зуучлах хэсэг: ажил хайгчид үндэсний хэмжээнд ажил олголт, хүний нөөцийн асуудал эрхэлдэг байгууллагуудаас идэвхтэй байгаа нээлттэй ажлын байруудаас гадна өнөөгийн хөдөлмөрийн зах зээлд хамгийн их эрэлттэй байгаа ажлын байранд тавигддаг үр чадварын талаарх мэдээллийг авсан. Энд вэбд суурилсан ажил хайлтын сайтуудад хэрхэн хамгийн үр дүнтэй хайлт хийж, ажлын зарыг олох практик зөвлөгөөг оролцогчдод өгсөн.

Ажил олгогч байгууллагуудын хэсэг: ажил хайгчид хөдөө аж ахуй, мэдээлэл холбоо харилцаа, үйлчилгээний салбаруудад үндсэн, цагийн, сайн дурын ажил, дадлагажигчийн ажлын байруудыг санал болгосон томоохон болон дундаж хэмжээний компаниудын нээлттэй ажлын байрны мэдээллийг авсан. Үүний зэрэгцээ компаниуд ажилд орохоор хандсан өргөдлүүдийг хүлээн авч, ажилд авах эхний ерөнхий үнэлгээг өгч, боломжит хүмүүсийг тогтоосон.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төлөөллийн хэсэг: МБС-ийн байгууллагуудын төлөөлөл оролцож, өөрсдийн сургалтын үндсэн чиглэлүүдээс гадна эрэлттэй ба шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрүүд (хөдөө аж ахуйн машин механизмын операторч, засварчин зэрэг) мэргэжлүүдийн талаар танилцуулсан.

Төслийн танилцуулгын булан: хөдөлмөрийн яармагт хүрэлцэн ирсэн хүмүүст төслийн ерөнхий зорилго, үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийсэн.

Хөдөлмөрийн яармагийн асруудаар нийт 800 гаруй хүн зочилж, яармаг нь “ТХЗ Нээлттэй Өдөрлөг”-ийн онцлох арга хэмжээний нэг болж чадсан. Арга хэмжээний үеэр авсан ерөнхий асуумжаар оролцогчдын 50 гаруй хувь нь одоогоор ажил хайж байгаа, 33.7% нь үндсэн ажилтай гэсэн бол үлдсэн хувь одоогоор түр хугацааны/цагийн ажлын гэрээтэй гэсэн байна.



Зураг. Хөдөлмөрийн яармагийн орох хэсэг



Зураг. Яармагт хүрэлцэн ирсэн албаны төлөөлөл ГХЯ, ЕХ, НҮБ-Монгол, НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн сан, ХНХЯ, бусад холбогдох яамдын төлөөлөл



Зураг. Хөдөлмөрийн яармагт оролцогчид санал сэтгэгдлийн хуудас бөглөж байгаа нь



Зураг. Төслийн НҮБХХ ХХААБ-ын багийн гишүүд, НҮБ-ын Залуучуудын зөвлөх хороо болон дадлагажигчид, сайн дурын ажилтнууд

Олон нийтэд хүргэсэн мэдээлэл сурталчилгаа

Залуучуудад тэр дундаа ажил хайж байгаа залуучуудын дунд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг голлон дэмжсэн нийт 6 дугаар бүхий “Надад асуулт байна” цуврал дүрстэй подкастыг бүтээж олон нийтэд цацсан бөгөөд, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг урьж оролцуулан ярилцсан. Түүнчлэн зохистой хөдөлмөрийг дэмжих чиглэлд 4 дугаар бүхий аудио подкаст гаргасан.

Б.Хоролцэцэгийн тухай Хөдөлмөр эрхлэлтийн албанд санал болгож буй “Профайлинг” үйлчилгээ нэг хүнд хэрхэн нөлөөлж байгааг онцлон харуулах зорилгоор нөлөөллийн түүхийг бичсэн.

Төслийн ерөнхий мэдээлэл, гол баримтуудыг нэгтгэн видео, хэвлэмэл байдлаар нийгмийн сүлжээ болон төслөөс зохион байгуулсан төрөл бүрийн арга хэмжээ, сургалтаар дамжуулан нийтэд хүргэсэн. Тайлант хугацаанд мэдээлэл сурталчилгааны материалууд (үзэг, малгай, футболк, цамц, даавуун тор, шоколад, төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан бэлгийн багц, хоёр төрлийн дэвтэр) гарган, ЕХ-ноос Монголд үзүүлж буй дэмжлэг, төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэхэд ашиглаж ирсэн.

Сургалт, семинар, арга хэмжээ зэрэг төслийн бүхий л үйл ажиллагааг нийгмийн сүлжээ болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол дамжуулж мэдээлж ирсэн (Мэдээлэл харилцаа, олон нийттэй ажиллах хүрээнд хийсэн үйл ажиллагааг нэгтгэн Хавсралт 5-д оруулав).

Залуучууд болон олон нийтэд зориулсан Монгол улсын хөдөө аж ахуйн салбар дахь зохистой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар богино хэмжээний кино бүтээж, 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Европын Өдөрлөг”-ийн үеэр үзүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжсэн 1 видео, анимэйшн буюу хөдөлгөөнт дүрс бүхий (дохионы хэлний тайлбартай) 4 видео, 3 зурагт хуудас, 3 товхимол бүхий багцыг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд одоогоор эдгээрийг эцэслэн хянах ажил хийгдэж байна. Мэдээлэл сурталчилгааны энэ багцыг ХНХЯ, түүний харьяа байгууллагуудын вэб хуудас, нийгмийн сүлжээ, сургалтын арга хэмжээгээр дамжуулан олон нийтэд хүргэнэ (дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн С.1.2-оос харна уу).

Тайлант хугацаанд цаас болон цахим хэлбэрээр гаргасан материалд төслийн шинэчилсэн танилцуулга товхимол, ИНБ болон сургагч багш нарт зориулсан “Төсвийн хяналт, шинжилгээ”, Завхан аймгийн орон нутгийн төсвийн үнэлгээ” (Англи, Монгол хэлээр), “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, арга хэмжээ, санхүүжилтийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ” (Англи, Монгол хэлээр), “Цахим үйлчилгээний ажилтан” МБС-ын сурагч болон багшийн гарын авлага (чадамжийн нэгж тус бүр дээр цахим ном хийгдэж байна) орсон.

Хэвлэгдсэн материал, техникийн баримт бичгийг нэгтгэн Хавсралт 2 Хэвлэгдсэн материал/техникийн баримт бичгүүдийн жагсаалт-д оруулав.

6. ТӨСЛИЙН УДИРДЛАГА

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН): төслийн үйл ажиллагааг НҮБХХ удирдан, ХХААБ, ОУХБ-тай хамтран хэрэгжүүлж байна. Иймд ТХН нь НҮБХХ, ХХААБ, ОУХБ-ын багаас бүрдэн НҮБХХ-ийн байранд байрлан, төслийн хэрэгжүүлэгч 3 байгууллагын багийн хооронд өдөр тутмын үйл ажиллагааг явуулж байна. ТХН одоогоор 8 ажилтан (НҮБХХ-ийн 4, ХХААБ-ын 3, ОУХБ-ын 1)-тай ажиллаж байна.

Төслийн Удирдах зөвлөлийн хурал, жилийн төлөвлөгөө: Төслийн 2022 оны жилийн төлөвлөгөөг төслийн Удирдах зөвлөлийн ээлжит 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар баталсан. Төлөвлөгөөний хүрээнд батлагдсан жил (2022 оны 1 дүгээр сараас 12 дугаар сар)-ийн төсөв 2,969,863 ам доллар бөгөөд энэ нь төсөл хэрэгжилтийн 3.5 жилийн хугацааны хамгийн өндөр төсөв юм. Төслийн Удирдах зөвлөлийн 3 дахь удаагийн хурал 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр болж, төслийн хагас жилийн тайланг хэлэлцсэн. Тус хурлын тэмдэглэлийг Хавсралт 6-д оруулсан.

ЕХ-нд хүргүүлдэг тайлан: Төсөл санхүүжүүлэгч байгууллага ЕХ-нд явцын тайланг сар тутам хүргэж ирсэн бөгөөд тайланд төслийн явцыг мэдээлэхээс гадна төлөвлөж буй арга хэмжээний мэдээллийг өгч ЕХ-ны оролцоог зохицуулж ирсэн. Төслийн явцын талаар мэдээлэл хуваалцах албан бус үүлзалт хэлэлцүүлгийг 2022 оны 4 дүгээр сард зохион байгуулсан.

Үр дүнд чиглэсэн хяналт шинжилгээний ажил: хяналт шинжилгээний ажил 2022 оны 5 дугаар сард хийгдсэн. Хяналт шинжилгээ нь үйл ажиллагааны хамаарал, зохицуулалт, хоорондын уялдаа холбоо, ЕХ-ны оруулж буй үнэ цэнэ, үйл ажиллагааны логик холбоо, хяналт шинжилгээ болон суралцах үйл явцын үр өгөөж, үйл ажиллагааны үр дүнтэй болон тогтвортой байдал, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн байдал, мэдээлэл харилцаа, олон нийтэд хүргэж байгаа байдалд гол чиглэж, дараах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

- Төслийн төлөвлөсөн болон хойшлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж 2 дахь жилд төсвийн дутуу зарцуулалтыг гүйцэтгэхийн тулд үйл ажиллагааны хэрэгжилтийг боломжит бүх хэмжээгээр хурдасгаж эрчимжүүлэх;
- Хөтөлбөрийн амьдралын мөчлөгийн удирдлага, системтэй төлөвлөлт (PCM/LFA)-ийн аргачлалын дагуу төслийн үйл ажиллагааны логик холбоог илүү тодорхой болгож, дэд зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүдийг илүү цэгцтэй, тодорхой болгож төслийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө (логфрэйм)-ийг шинэчлэх ажлыг хийх;
- Төслийн үйл ажиллагааг зорилтот бүлэг ялангуяа эцсийн үр шим хүртэгчдэд хүргэхэд гарах эрсдэл, нөлөөллийг бууруулахад гол анхааран, дэд зорилтуудыг хангахад гарах саад, хойшлуулах хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Төслийн зорилтот бүлгүүдэд хүргэх үр өгөөж, тэдгээрээр дамжуулан төсөл дууссаны дараа үр шим хүртэгчдийн үр өгөөжийн тогтвортой үргэлжлүүлэх, магадгүй хувийн хэвшилтэй хамтран, тэдний оролцоог дайчилсан боломжит хувилбаруудыг судалж үзэх хэрэгтэй.

ТХН үр дүнд суурилсан хяналт шинжилгээнээс гарсан үр дүн, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хийж байна. Өнгөрсөн хугацаанд Ковид-19 цар тахалтай холбоотой хойшлогдсон төсвийн зарцуулалт хийгдсэн, одоогоор төслийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө (логфрэйм)-нд өөрчлөлт оруулж, шинэчилж байна. Төслийн зорилтот бүлгүүдэд хүрэх үр өгөөж цаашид тогтвортой үргэлжлэх нөхцөлийг хангах, баталгаажуулах талаар 2023 оны жилийн төлөвлөгөө болон хүрэх зорилтуудад

тусгах хэрэгтэй байна. Энэ хүрээнд хийгдэх ажлуудыг 2022 оны 12 дугаар сард хийхээр төлөвлөж байгаа стратегийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн үүлзалтаар хэлэлцэх болно.

Худалдан авалт: Өнгөрсөн тайлант хугацаанд ТХН төлөвлөсөн үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжилтийг хангах, зохицуулах үүднээс нийт 37 зөвлөх-хувь хүн (19 эмэгтэй, 18 эрэгтэй), 11 гэрээт гүйцэтгэгч-хуулийн этгээдтэй хамтран ажилласан.

Нэгдсэн аргачлалаар хийгддэг мөнгөн хөрөнгийн шилжүүлэг (НАСТ)-ийн бичил үнэлгээ, спот шалгалт: НҮБ-ын системийн хэмжээнд нэгдсэн аргачлалаар мөнгөн хөрөнгийг хамтрагч төрийн болон төрийн бус байгууллагад шилжүүлэх журам байдаг. Иймд нэгдсэн аргачлалаар хийгддэг мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн бичил үнэлгээний аргачлалын дагуу төслийн засгийн газрын түвшний хамтрагч байгууллага (Сангийн яам)-ын нэгдсэн аргачлалаар хийгдсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн бичил үнэлгээг 2022 онд гадаад аудитын компани хийсэн. Ерөнхий эрсдэлийг “бага” гэж үнэлж, нийт 5 зөвлөмжийг өгсөн.

НҮБХХ-ийн санхүүгийн дүрэм журмын дагуу Сангийн яам дээр спот шалгалтыг 2022 оны 11 дүгээр сард хийхээр төлөвлөж байна. Спот шалгалтыг хамтрагч талуудад шилжүүлсэн мөнгөн хөрөнгийн санхүүгийн бүртгэлийн үнэн зөв байдал, хөтөлбөрийн статусыг үнэлэхийн зэрэгцээ дотоод хяналтад хамаарах голлох өөрчлөлтүүд байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийдэг.

7. БЭРХШЭЭЛ/ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Засгийн газрын түвшний шүүд хамтрагч байгууллагууд (яамууд), яамны чиг үүрэг, удирдлагын бүтцэд хийгдсэн өөрчлөлт: Мэргэжлийн боловсрол сургалтын төв 2022 оны 1 дүгээр сараас эхлэн ХНХЯ-наас БСШУЯ-нд шилжиж, Мэргэжлийн боловсрол сургалтын газрын дарга томилогдох хугацаа удааширсан.

2022 оны 1 дүгээр сард Эдийн засаг, хөгжлийн яамыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (ХБТГ)-ыг оролцуулан 7 газар, 8 хэлтэстэй байгуулсан. Үр дүнд суурилсан жилийн төлөвлөлтөөр ХБТГ-тай хамтран ажиллаж байна.

Төсөл хөдөлмөрийн хяналтын асуудлаар ХНХЯ-тай байнгын холбоо харилцаатай ажилладаг. Төрийн хяналт шалгалтыг түр хугацаагаар зогсоох хуулийн төсөл төслийн төлөвлөгөөнд мөн нөлөөлсөн. Гэхдээ төслийн зүгээс ОУХБ-ын Суурин төлөөлөгчийн Монголд хийх айлчлал, ХНХЯ-нд шинээр бий болох хөдөлмөрийн хяналтын бүтэц, дизайны талаар мэдээлэл өгөх зэрэг хөшүүргүүдийг үндэслэн Монгол Улс ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцод нэгдэн ороход үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. ХНХЯ-ны ажилтнуудын чиг үүрэгт өөрчлөлт хийгдэж байгаатай холбоотойгоор олон улсын хөдөлмөрийн стандартыг нэвтрүүлэх асуудлаар гурван талт дэд хороог дахин байгуулах ажил харьцангуй удаан байна.

Хоршоо байгуулах: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Баянчандмань суманд, НҮБ-ын ХХААБ-аас Өмнөговь аймагт хоршоо байгуулах нь 1990 оноос хойш баримталж ирсэн хамтын ажиллагааны арга барилтай төдийлөн тохирохгүй байсан. Тиймээс хоршоод байгуулахын ач холбогдлыг харгалзан хоёр баг хоёулаа орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах зөвлөхийг гэрээлж ажиллуулсан. НҮБХХ

10 дугаар сард Баянчандмань сумын Засаг даргатай хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар зөвлөлдөх уулзалт хийсэн.

8. СУРГАМЖ БОЛОН ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛС

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд, дэд зорилтууд болон НҮБХХ/ХХААБ/ОУХБ-ын бусад төслүүд хоорондын зохицуулалт: Төслийн бүрэлдэхүүн бүр тодорхой дэд зорилт, үйл ажиллагаатай бөгөөд эдгээр нь нэгэн зэрэг хэрэгждэг. Иймд 2022 онд төслийн дэд зорилт, бүрэлдэхүүн хэсгүүд хоорондын уялдаа холбоог сайжруулахын тулд төслөөс ихээхэн хүчин чармайлт гарган ажилласан. Бүрэлдэхүүн хэсэг С.3.3-ын хүрээнд ажил олгогч-ажилтан хоорондын харилцаа холбоог сайжруулахад олгосон тэтгэлгийг хөдөлмөрийн эрхийн асуудалд анхаардаг Бизнес ба хүний эрхийн төсөл (НҮБХХ) болон ОУХБ-ын техникийн мэдлэг туршлагатай холбосон.

Мэдлэгийн менежмент: Төслийн үйл ажиллагааг 2022 онд эрчимжсэнтэй холбоотой гэрээгээр ажил гүйцэтгэгчид, хамтрагч байгууллагуудын тоо нэмэгдсэн нь мэдээлэл солилцох, танилцуулга өгөх ажилд цаг нэлээд зарцуулж, тэднийг ТХН-ээс нэгдсэн удирдлагаар чиглүүлэхэд хүндрэл сорилтууд гарсан. Иймд 2023 онд НҮБХХ-ийн мэдлэгийн төвтэй адил илүү технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлж, түүнээс суралцах, хамтдаа бүтээх, идэвхжүүлэх талаар зөвлөхүүдэд эрчимжүүлсэн байдлаар мэдээлэл өгөх, танилцуулга хийх тодорхой хугацаатай байх шаардлага үүсэж байна.

Төслийн үр дүнд хүрэх явц: 2023 онд төсөл нь 3 дахь жилдээ хэрэгжих бөгөөд илүү үр дүн гарна гэж үзэж байна. Иймээс үр дүнд чиглэсэн стратегийн төлөвлөлтийг 2022 оны сүүлээр хийж, төслийн үйл ажиллагааг бодит үр дүн, үр нөлөө гаргахад чиглүүлж, нарийвчлан авч үзэх болно. Түүнчлэн энэ төлөвлөлтөөр 2022 оны 5 дугаар сард ЕХ-ны үр дүнд чиглэсэн хяналт шалгалтаас гарсан зөвлөмжүүдийн дагуу авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгах болно.

ЕХ-ны төсвийн дэмжлэгийн зорилтуудыг хангахад дэмжлэг үзүүлэх: 2021 он Засгийн газар, ЕХ-ны Төлөөлөгчийн газартай тодорхой мэдээлэл солилцох анхны жил байсан. Засгийн газрын төсвийн дэмжлэгийн санхүүжилтийн дараагийн хэсгийг авахын тулд Сангийн яам Төсвийн дэмжлэгийн гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн явцыг танилцуулах шаардлага гарсан. Төсөл 2022 онд хүрэх шаардлагатай шалгуур үзүүлэлтүүд, зорилтуудын талаар мэдээлэлтэй байж, тэдгээрийг тайлагнах, бэлтгэхэд Сангийн яаманд дэмжлэг үзүүлэн ажиллана. 2023 онд төсөл дээрх шалгуур үзүүлэлтүүдэд хүрэхэд анхаарах зүйлс, тайланг бэлтгэхэд юунд анхаарах талаар ХНХЯ, БШУЯ, СЯ-нд холбогдох зөвлөмжүүдийг үргэлжлүүлэн өгөх болно.

9. ЦААШДЫН ЧИГЛЭЛ

2022 онд боловсруулсан үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйн бодитой хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлох ажлыг бусад салбарт түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үр дүнд суурилсан төсөвлөлтийг туршилтын салбарууд болох хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуйгаас гадна байгаль орчин, боловсролын салбаруудад хэрэгжүүлэхэд анхаарна. Сангийн яамтай хамтран салбар яамд болон орон нутагт үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын удирдамжийг боловсруулна. УИХ-ын Төсвийн байнгын хороо, ЭЗХЯ, СЯ, ЗГХЭГ, УАГ, салбар яамнууд, болон орон нутгийн

захиргаатай хамтран төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-үнэлгээ, тайлагналын тогтолцоог боловсронгуй болгоход түлхүү анхаарч ажиллана.

Цаашид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, өртгийн тооцоолол хийх, ялгаатай газар зүйн байршил, хүн амын бүлэгт хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ хэрхэн хүрч буйг шинжлэх зэрэг ажлууд хийгдэнэ. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогын урамшууллыг нийгмийн халамж, нийгмийн даатгал зэрэг салбар дундын асуудлыг хамран туршилтаар хэрэгжүүлнэ.

Ингэний сүүн бүтээгдэхүүнтэй холбоотой эхлүүлсэн ТХХТ-ийн аргачлалыг цаашид бэхжүүлж, уг загварыг төслийн хүрээнд болон ХХААХҮЯ-наас бусад бүтээгдэхүүнүүдэд санал болгоно.

МХЕГ-ын бүтцийн өөрчлөлтөд хөдөлмөрийн хяналтын асуудал тулгамдсан хэвээр байгаа хэдий ч Төсөл энэхүү сорилтыг хөдөлмөрийн нөхцөлд эерэг нөлөө үзүүлэхүйц боломж болгон хувиргах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.

Төслийн хэрэгжилт талаасаа илүү хувьдаа орж байгаатай холбоотой 2023 онд хэрэгжилтийн хяналт, үнэлгээнд илүү анхаарал хандуулах болно. Ингэхдээ холбогдох талуудын оролцоо, хамтын ажиллагааг чухалчилна.

10. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайлан доор тусгав.

Бүрэлдэхүүн хэсэг	Зардал (2020.10.1- 2021.9.30)	Зардал (2021.10.1- 2022.9.30)	2022.9.30-нээрх төлбөрийн хариуцлага	Нийт зардал
Бүрэлдэхүүн хэсэг А	73,107	597,049	162,977	833,134
Бүрэлдэхүүн хэсэг В	24,670	196,445	96,733	317,847
Бүрэлдэхүүн хэсэг С	93,101	786,277	151,242	1,030,620
Бүрэлдэхүүн хэсэг D	10,733	69,661	-	80,393
Төсөл хэрэгжүүлэгч нэгж	98,622	195,407	-	294,028
Ерөнхий удирдлагын зардал (7%)	21,016	129,139	-	150,155
Нийт дүн	321,248	1,973,977	410,952	2,706,177

11. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Урьдчилсан төсөв бүхий ажлын төлөвлөгөө (НҮБХХ, ХХААБ, ОУХБ-ын)-г хавсралтад оруулав.

12. ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАВСРАЛТ 2

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭВЛЭГДСЭН МАТЕРИАЛ/ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ

Бүрэлдэхүүн хэсэг	N	ТАЙЛАН, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ, ХЭВЛЭЛИЙН НЭР	Хэл Холбоос
Бүрэлдэхүүн хэсэг НЭГ (А)			
Зорилт А.1	1	Үр дүнд суурилсан төлөвлөлт болон үр дүнд суурилсан төсөвлөлтийг холбох (уялдуулах) тухай үзэл баримтлал	Англи Монгол
	2	Үр дүнд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тухай үзэл баримтлал	Англи
	3	Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ	Англи
	4	Үр дүнд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог Монгол Улсад хэрхэн нэвтрүүлэх, хэрэгжүүлэх замын зураглал: үе шат, үйл ажиллагаа, хугацаа	Англи
	5	МУ-ын төсөв, санхүүгийн удирдлагын шинэчлэлийн төлөвлөгөөний төсөл 2022-2025	Монгол
	6	Дунд хугацааны төсвийн хүрээнээс Дунд хугацааны макро-төсвийн хүрээ рүү шилжих үзэл баримтлал	Англи
Зорилт А.2	7	Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн саналын маягт бөглөх заавар (загвар маягтуудын хамт)	Монгол
	8	Хөвсгөл аймгийн 2022 оны батлагдсан төсөв, хөтөлбөрт суурилсан төсөвлөлт, тулгамдаж байгаа асуудал, шийдэл, зөвлөмж	Монгол
	9	Төсвийн ангиллын хэрэглээний өнөөгийн байдал (Хөвсгөл аймгийн ТЕЗ-ын төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээлэлд үндэслэв)	Монгол
	10	Завхан аймгийн орон нутгийн төсвийн шинжилгээ өнөөгийн нөхцөл байдал	Англи Монгол
	11	Төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайлагналын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ	Монгол
	12	Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах удирдамж	Монгол
Зорилт А.3	13	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ	Англи Монгол

	14	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ	Монгол
	15	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд	Монгол
	16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа: Өвөрхангай, Орхон, Дорноговь	Монгол
	17	Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн өртөг тооцох тухай тайлан	Монгол
Бүрэлдэхүүн хэсэг ХОЁР (В)			
Зорилт В.2	18	Сангийн яам, Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаанд баримтлах баримт бичгийн судалгааны тойм	Монгол
	19	Иргэний нийгмийн байгууллагуудын сургалтын хэрэгцээний судалгаа	Монгол
	20	Төсвийн хяналт шинжилгээ-сургагч багшийн гарын авлага	Монгол
	21	Төсвийн хяналт шинжилгээ-ИНБ-д зориулсан гарын авлага	Монгол
Output В.3	22	Арга зүйн төсөл: ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөд аудит хийх арга зүйн удирдамж	Англи Монгол
	23	Төрийн бодлого болон төсвийн хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийх техникийн удирдамж	Англи Монгол
	24	Гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлэх талаар өгсөн санал: Замын зураг	Монгол
	25	Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн гүйцэтгэлийн аудитад ашиглавал зохих маягтууд	Англи Монгол
	26	Reports on pilot audits conducted to strengthen the MNAO's performance audit practice.	Англи
	27	Монгол Улсын Үндэсний Аудитын Газрын гүйцэтгэлийн аудитын чанарын хяналтыг бэхжүүлэх зөвлөмж	Англи Монгол
	28	Аудитын дээд байгууллагын стратеги, байгууллагын бүтэц	Англи
	29	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТХЗ-той холбогдох гүйцэтгэлийн аудит хийх техникийн удирдамж	Англи Монгол
	30	Хөдөлмөр эрхлэлтийн салбарын Гүйцэтгэлийн аудитын техникийн зөвлөмж	Англи
	31	Төслийн (эрүүл мэндийн) салбар дахь ҮДСТ-ийн гүйцэтгэлд аудит хийх нь	Англи Монгол
	32	Иргэний танхимын (нийгмийн аудитын удирдамжийн төсөл)	Англи Монгол
33	Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төслийн аудитын дүгнэлтэд тусгах зөвлөмж	Англи Монгол	
Бүрэлдэхүүн хэсэг ГУРАВ (С)			
Output С.1	34	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах хуулиудын төсөл, үзэл баримтлал	Монгол
	35	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлан	Монгол
	36	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан	Монгол

	37	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа	Монгол
	38	Одоогийн статистикийн ойлголт, тодорхойлолт, мэдээлэл цуглуулалт, цоорхой, саад бэрхшээлийг бусад улс орнуудтай харьцуулсан үнэлгээний тайлан	Монгол
	39	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл цуглуулалтыг сайжруулах санал болгож буй “Мэдээлэл цуглуулах хүрээ”	Монгол
	40	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын сайн туршлага	Монгол
Output C.3	41	МБС-ын Бизнес эрхлэх үр чадварын сургалтын хөтөлбөрийн талаар хийсэн нөхцөл байдлын судалгааны тайлан	Монгол
	42	Богино хугацааны мэргэжлийн сургалтын чиглэл, индекс өмнө судлагдсан байдал	Монгол
	43	Богино хугацааны мэргэжлийн үр чадвар олгох сургалтын чиглэл, индексийг тодорхойлон шинэчлэн боловсруулсан ажлын тайлан	Монгол
	44	Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын бодлогын тойм судалгаа	Монгол
	45	Сурагчийн гарын авлага: Цахим үйлчилгээний ажилтан_Чадамжийн нэгж 1	Монгол
	46	Сурагчийн гарын авлага: Цахим үйлчилгээний ажилтан_Чадамжийн нэгж 2	Монгол

ХАВСРАЛТ 3

ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН СУРГАЛТУУД БОЛОН ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

#	ОГНОО	СЭДЭВ	Оролцогчид		
			Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
БҮРЭЛДЭХҮҮН А					
1	2022 оны 3 дугаар сарын 02	ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТИЙН НЭГДСЭН СТРАТЕГИ, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖИЙГ ТАНИЛЦУУЛАХ (цахим болон танхим) (СЯ)	57	23	34
2	2022 оны 3 дугаар сарын 10-11	ҮР ДҮНД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСӨВЛӨЛТИЙН АРГАЧЛАЛЫГ ОРОН НУТАГТ НУТАГШУУЛАХ НЬ (ХХААЯ)	172	102	70
3	2022 оны 3 дугаар сарын 16	ҮР ДҮНД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ (ХНХЯ)	35	19	16
4	2022 оны 3 дугаар сарын 17-18	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙГ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТЭЙ УЯЛДУУЛАХ, ОРОН НУТГИЙН САЛБАРЫН САНХҮҮГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ (ЭМЯ)	114	32	82
5	2022 оны 4 дугаар сарын 14-15	БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ, ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ (БОЯ)	74	37	37
6	2022 оны 4 дугаар сарын 30	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТИЙН СЕМЕНАР	32	13	19
7	2022 оны 5 дугаар сарын 05	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ЦААШДЫН АЛХАМ СЭДЭВТ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ (Оролцогч талууд)	46	28	18
8	2022 оны 7 дугаар сарын 7-8	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ (ХХААЯ болон ХНХЯ)	106	46	60
9	2022 оны 7 дугаар сарын 28-29	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ (БШУЯ)	23	6	17
10	2022 оны 8 дугаар сарын 2-4	ҮДНУ-ЫН ХҮРЭЭНД ТУРШИЛТЫН ЯАМДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРУУЛАХ СУРГАЛТ (ХНХЯ болон ХХААЯ-ны Төсвийн санал)	49	23	26
11	2022 оны 8 дугаар сарын 17	ҮДНУ: ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН НЭГДСЭН АСУУДГУУД	35	11	24
12	2022 оны 8 дугаар сарын 19	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ (ЭЗХЯ)	17	7	10
13	2022 оны 9 болон 10 дугаар сар	ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСӨВЛӨЛТ (Орон нутгийн сургалт- 21 аймаг, 9 дүүрэг, болон нийслэл)	1593	567	1026
НИЙТ			2353	914	1439
БҮРЭЛДЭХҮҮН В					
14	2022 оны 2 дугаар сарын 07	ТӨРИЙН БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ, ЗАСГИЙН ГАЗАР, ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН АУДИТЫН ГҮЙЦЭТГЭЛ ЦАХИМ СЕМИНАР (УАГ)	165	91	74

15	2022 оны 3 дугаар сарын 30	“ТХЗ-той ХОЛБООТОЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН АУДИТЫН ПРАКТИКЫГ БЭХЖҮҮЛЭХ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (ҮАГ)	100	49	51
16	2022 оны 5 дугаар сарын 05	ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ: АУДИТ, ТӨСӨВ ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ (ҮАГ)	55	29	26
17	2022 оны 5 дугаар сарын 06	НИЙГМИЙН АУДИТ (ҮАГ)	95	46	49
18	2022 оны 6 дугаар сарын 29	ЧАНАРЫН ХЯАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ ЦАХИМ СУРГАЛТ (ҮАГ)	77	40	37
19	2022 оны 4 дугаар сарын 15	ТӨСВИЙН ХЯНАЛТ (ИНБ)	47	8	39
20	2022 оны 6 дугаар сарын 13	2022 ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТИЙН СЕМИНАР (ИНБ)	43	8	35
21	2022 оны 8 дугаар сарын 31-аас 9 дугаар сарын 03	ТЭТГЭЛЭГТ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ– ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСЛИЙН ТАЙЛАГНАЛ СЭДЭВТ СУРГАЛТ (ИНБ)	37	7	30
22	2022 оны 9 дугаар сарын 27	БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДЭМЖСЭН НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ (ИНБ)	37	10	27
НИЙТ			656	288	368
БҮРЭЛДЭХҮҮН С					
23	2022 оны 3 дугаар сарын 25	“ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ” БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БОЛОН ИРЭЭДҮЙН АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА”-НЫ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА	52	25	27
24	2022 оны 4 дугаар сарын 18	АЖИЛ ХАЙГЧ, АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЗҮЙН СУРГАЛТ	242	59	183
25	2022 оны 5 дугаар сарын 11	"АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ХӨГЖИЛ БА ШИЙДЭЛ " ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	40	16	24
26	2022 оны 6 дугаар сарын 03	ХЗЗ-ИЙН СТАТИСТИК МАЯГТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ХЭРЭГЛЭЭ, ТАЙЛАГНАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭГ ТАНИЛЦУУЛАХ , ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ (АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙТЭЙ НЭГДСЭН)	38	17	21
27	2022 оны 6 дугаар сарын 23-24	ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЗҮЙН СУРГАЛТ	49	11	38
28	2022 оны 9 дугаар сарын 15	ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ХҮРЭЭ	10	3	7
29	2022 оны 6 дугаар сарын 07	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛСАН МБС-ЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТ	37	12	25

30	2022 оны 6 дугаар сарын 23	МБС-ЫН ИНДЕКСИЙГ ХЭЛЭЛЦЭХ	35	7	28
31	2022 оны 6 дугаар сарын 27	ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ WWW.EDU-TRACK.GOV.MN СИСТЕМИЙН НЭЭЛТ	40	21	19
32	2022 оны 8 дугаар сарын 26	МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН (БШУЯ)	784	263	521
33	2022 оны 3 дугаар сарын 29	СЭТГЭЛГЭЭНИЙ ӨӨРЧӨЛТИЙН ШИНЭЛЭГ АРГА ХЭРЭГСЛҮҮД	34	9	25
34	2022 оны 4 дугаар сарын 14	ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮЖИЛТТЭЙ ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН НЭЭЛТ	44	20	24
Нийт			1405	463	942
Бүгд			4414	1665	2749

ХАВСРАЛТ 4

ДАРААГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

ХАВСРАЛТ 5

2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАВСРАЛТ 6

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ